



ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

2018.01.12, БААСАН ~ №009, 010 (808, 809)

~ СОЁЛТ ХҮНИЙ ӨГЛӨӨ СОНИН УНШИХААС ЭХЭЛДЭГ ~

ҮНЭ: 1000₮

Б.Лхагважав: Татварын нэмэгдлийг цуцлах боломж бий

Татвар, цалинтай холбоотой асуудлаар нийгмийг бухимдуулах хэрэггүй. > 6

Бизнесийн чагнуурын таатай чимээ

Бизнесийн орчны эрүүл мэндийн гол туслагч нь гадаад орчны эерэг төлөв байна. > 11



■ Мүн Жэ Ин Умардын удирдагчийг уулзалтад урив
■ Мьянмар Британийн хоёр сэтгүүлчид ял тулгалаа

Ubinfo.mn сайт шилдэгт багтлаа

“Засгийн газрын мэдээ” сонины цахим хуудас Ubinfo.mn нь Монголын мэдээллийн шилдэг сайтуудын тавдугаарт бичигдлээ.

- Gogo.mn
- Xopom.com
- Ikon.mn
- Caak.mn
- Ubinfo.mn
- Zалуu.com
- News.mn
- Medee.mn
- Olloo.mn
- Dorgio.mn

Эх сурвалж: Alexa.com©

ОНЦЛОХ

УЛС ТӨР

Алдар цолтон ахмадуудад олгодог тэтгэмжийн хэмжээг шинэчлэхийг УИХ дэмжив.
Өнөөдөр ардчилсан Үндсэн хуулийг баталсны өдөр тохиож байна.
Төрийн гурван өндөрлөг Монголд суугаа дипломат корпусын тэргүүн нартай уулзлаа.
Цагаачлах иргэдийн тоог жилд 100-гаас дээшгүй байлгахыг ЗГ дэмжив.
Хоёр яамны ТНБД-ын сонгон шалгаруулалтыг ирэх сарын 5-нд хийнэ.

ЭДИЙН ЗАСАГ

Хөрөнгийн биржийн "MSE ALL" индекс 1153.99 нэгж болж, 0.24 хувиар өсөв.
Алтны мөнгөжүүлэлтээс орсон орлого валютын албан нөөцийн өсөлтийн 62.9 хувийг бүрдүүлээ.
Монгол Улс өнгөрсөн сарын байдлаар 33.3 саян тонн нүүрс экспортлов.
Банкны салбарын зээлийн өсөлт сүүлийн 17 сар дараалан эерэг гарчээ.
Нийт газар нутгийн 7.03 хувийг ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэлж байна.

НИЙГЭМ

Зөвшөөрөлгүй байрлуулсан сурталчилгааны самбаруудыг өнөөдрөөс албадан буулгана.
НӨАТ-ын сугалааны тохирлын хэмжээ өөрчлөгджээ.
Энэ онд 25 хүнд элэг, 23 хүнд бөөр шилжүүлэн суулгана.
Элэгний С вирусстэй цэргийн алба хаагчдад үнэ төлбөргүй эм олгоно.
Сүхбаатар дүүргийнхэн хогтой тэмцэхээр 25 байршилд камер байршууллаа.

ДЭЛХИЙ

Зарим улс аюулгүй байдал нэрээр худалдаанд саад хийж буйг Хятадын тал шүүмжлэв.
Норвег улс Северный поток-2 хийн хоолой тавихад Орост туслахыг санал болголоо.
WikiLeaks-ийг үндэслэгч Ж.Ассанж дипломат статус хүссэн боловч Лондон татгалзав.
Энэтхэгийн Jet Airlines компанийн нисгэгчид бүхээгтээ зодолдсон учир халагджээ.
Их Британи 2033 он гэхэд пластик хог хаягдлаас салахаар төлөвлөсөн байна.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

2018.01.12



-9° -21°

ҮҮЛШИНЭ

ЦАГ АГААРЫН ДЭГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛИЙГ
8 ДУГААР НҮҮРЭЭС УНШИНА УУ



Бүх эрх хуулиар хамгаалагдана ©

Х.Баттулга: УИХ-ыг тараах саналыг дэмжинэ



Ажил хийхэд саад тотгор алга. Хэрэв энэ боломжийг ашиглаж, Засгийн газраа ажиллуулж чадахгүй бол Ерөнхийлөгчийн хэлсэнчлэн энэ УИХ тарах нь хамгийн зөв алхам. ►2

НИЙТЛЭЛЧИЙН БУЛАН

Төрийн өмчит компани ногдол ашиг тараадаггүй

Б.Даваатогтох
@datoZGM

Дэлхийн зах зээл дээр Австралийн коксжих нүүрсний үнэ тонн нь 330 ам.долларын оргил ханшид хүрч байсан 2011 онд Монгол Улс Тавантолгой ордын лиценз эзэмшигч “Эрдэнэс Тавантолгой” компанийн хувьцааг иргэн бүрт олгох санааг олсон байдаг. 2008 оны УИХ-ын сонгуулийн амлалтаа биелүүлэхийн тулд улс төрийн хүчнүүд санал нэгдэж, Эрдэнийн хувь болон Эх орны хишгийг 1072 хувьцаа

болгон хувиргаж, иргэн бүрт үнэ төлбөргүй тараасан юм.

Тодруулбал, 2012 оны дөрөвдүгээр сард Засгийн газраас шинээр тогтоол гаргаж, “Эрдэнэс Тавантолгой” компанийн нийт хувьцааны 20 хувийг Монголын ард түмэнд тараана гэснээр нэг хүнд 1072 хувьцаа оногдсон билээ. Ингэхдээ сонгуулийн амлалтын нэг сая төгрөгийг 1072 ширхэгтээ хувааж, хувьцааны нэрлэсэн үнийг зах зээлийн бус улс төрийн шийдвэрээр хүчээр тогтоож, 933 төгрөг болгосон байдаг.

►3

ЗГМ: СУРВАЛЖИЛГА

Шинжлэх ухаанч бизнесүүд бодит дэмжлэгийн эрэлд гарчээ

Б.Баярмаа
@bayarmaaZGM


Эрдэмтдийн олон жил зарцуулсан судалгааны дүнд бүтсэн, байгалийн цэвэр түүхий эдээр хийсэн инновацийн бүтээгдэхүүнүүд ХААИС-ийн Инноваци, бизнес хөгжлийн төвийн “дэлгүүр”-г өрөөстэй байна. Сонирхсон нэгэнд шилдэг бүтээлүүдээ танилцуулдаг энэ өрөөний ханаар төрөл бүрийн бордоо, малын эм бэлдмэл, улаанбуудайн шинэ сортуудыг зайгүй өржээ. ХААИС-ийн багш, судлаачид 300-400 орчим инновацийн бүтээлд зохиогчийн эрх авсан байдаг.

Энэ төвийн харьяа 26 гарааны компани байдгаас зарим нь дөнгөж бүтээгдэхүүнээ хийж эхэлж буй бол том үйлдвэрийн хэмжээнд хүрсэн нь ч бас бий.

2015 онд 13, 2016 онд 18 гарааны компани боловсрол, шинжлэх ухааны байгууллагын дэргэд бий болсон бол энэ сард 11 компани шинээр бүртгүүлжээ. Их, дээд сургууль, шинжлэх ухааны хүрээлэнгүүдийг түшиглэн боссон гарааны компаниудын тоо жил ирэх тусам нэмэгдсээр байгааг тус сургуулийн Инноваци, бизнес хөгжлийн төвийн захирал Б.Мөнхбат өгүүлэв.

►5

ЗГМ: ИНФОГРАФИК



Улс төр

ЕРӨНХИЙЛӨГЧ

Х.Баттулга: УИХ-ыг тараах саналыг дэмжинэ

Утааны сэдвийг анхаарлын төвд авчирч, дүлий төрийг түргэн авахуулав

Б.Энхжаргал
@enkhjrglZGM

Төр засаг, нийслэлийн удирдлагууд олон жил ярьж, олон ч төсөл хөтөлбөр хэрэгжүүлж бас, олон арван тэрбум төгрөг зарцуулж ирсэн Улаанбаатарын утаа энэ өвөл онцгой их, илүү өтгөн, улам хортой байна.

Нийслэлд, тэр дундаа утааны бүсэд амьдарч буй сурагч хичээлдээ явах замдаа угаартаж, анги дээрээ ухаан алдсан тохиолдол урьд өмнө арай ч сонсогдож байсангүй. Гэхдээ нийслэлийнхэн нийтээрээ чимээгүй хордож байсан өнгөрсөн он жилүүдийг энд үгүйсгэхгүй. Харин “Ийм л байсан, цаашид ч гэсэн тийм л байна” гэх гутранги бодол тээж, өвлийн гурван сарыг өнгөрөөгөөд мартаж болохгүй гэсэн дохиог парламентыг тараах анхааруулгаар Ерөнхийлөгч өглөө. Тэрбээр өнгөрсөн долоо хоногийн ажлын сүүлийн өдөр УИХ-ын чуулганы хуралдаанд хэлсэн үгэндээ “Утааны талаар дорвитой арга хэмжээ авахгүй бол УИХ-ыг тараах санал оруулна” хэмээн мэдэгдсэн нь байх ёстой үзэгдэл мэт болтлоо угжирсан утааны сэдвийг анхаарлын төвд авчирч, дүлий төрийг түргэн авахуулав.

Зөвхөн Ерөнхийлөгч бус сөрөг хүчин ч ард иргэдийн халаас руу гар дүрсэн, аж ахуйн нэгжийг



Б.Ганбаяр / ЗГМ ©

сульдаасан шийдвэрээ эргэж харахгүй бол УИХ-ыг тарах ёстой гэсэн улс төрийн мэдэгдэл хийсэн нь хүч нэмлээ.

Нийслэл төсвийнхөө арван төгрөг тутмыг есийг нь татвар төлөгчдөөс бүрдүүлдэг

Лхагва гарагт Ерөнхийлөгч Х.Баттулга хоёр телевизэд ярилцлага өгч, өөрийн үйл ажиллагааны чиг шугам болон зорилт, зорилгынхоо талаар мэдээлэл өгөв.

Энэ үеэр “ард иргэдийн зүгээс

эрх баригчдад итгэх итгэл алдарч байна. Энэ талаар олон ч гомдол, санал ирсэн. Ингэхдээ УИХ-ыг тараах тухай санал ч олноор ирүүлж байгаа. Миний хувьд үүнийг УИХ дээр хэлсэн. УИХ-ын нэр бүхий гишүүд ч хэлж байна лээ. Би энэ саналыг дэмжинэ” хэмээн тодорхой яриw.

Харамсалтай нь онц байдал зарлах хэмжээнд хүрсэн утааны асуудлыг УИХ-аар хэлэлцэх үед гишүүдийн ирц хангалтгүй байлаа. Мөн одоогоос яг нэг жилийн өмнө YABЗ хуралдаад УИХ, Засгийн газар, нийслэлийн удирдлагуудад өгсөн үүргээс нэг нь ч хэрэгжээгүй. Гэсэн атлаа зуух, агаар цэвэршүүлэгч тараах, маск зүүлгэх зэрэг түр аргацаасан, нүд хуурсан ажлууд хийхээр УИХ-аар танилцуулж суугаа УИХ, Засгийн газар өөрөө угаартаад, ухаан санаа

нь балартаа юу гэлтэй. Ийм байдлаар яривал энэ УИХ-ыг тараах Ерөнхийлөгчийн саналыг дэмжих хэрэгтэй.

Ерөнхийлөгч “Өнөөдөр гэрийг дулаалах тухай яриад байна. 1.5-2 сая төгрөгөөр таван ханатай гэр дулаална гэнэ. Энэ мөнгө гэр хороололд амьдарч байгаа улсад байхгүй. Утааг ажилгүйдэл ядууралтай хамт тэглэхээс өөр арга байхгүй. Богд уулаа тойрсон дагуул хотуудыг бий болгоё. Дагуул хотууд руу нүүдлээ зоригтой эхлэх хэрэгтэй. Зарим яамд, агентлагуудаа гаргая. Хөдөлгөөн хийгдээд эхлэнгүүт хөдөөгийн нүүдэл ихэснэ. Ахуйг нь өөрчилье. Энэ шийдлийг одоо хийхгүй бол дөрөвдүгээр сард газар гэснэ, ажилгүй иргэдээ ажилтай болгоё. Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдээ ажилд оруулъя. Хүмүүсээ

насаар нь ангилаад ажилтай, мэргэжилтэй болгоё” гэв. Үнэхээр Ерөнхийлөгчийн хэлсэнчлэн энэ УИХ, Засгийн газарт онцгой итгэл үзүүлсэн.

УИХ-д 65 гишүүн сонгогдсон үнэмлэхүй нэг нам засгийн эрхийг дангаар барьж буй. Засгийн газраа 100 хувь парламентаас бүрдүүлж, давхар хамгаалалттай, бяртай сайдуудтай Засгийн газарт хориг, завсарлагын аль нь ч үйлчлэхгүй. Өөрөөр хэлбэл ард түмэн МАН-ыг дэмжсэн шиг дэмжиж, үнэмлэхүй олонхтой УИХ-ын улс төрийн хамгаалалтыг Засгийн газарт давхар өгсөн. Ажил хийхэд саад тогтор алга. Хэрэв энэ боломжийг ашиглаж, Засгийн газраа ажиллуулж чадахгүй бол Ерөнхийлөгчийн хэлсэнчлэн энэ УИХ тарах нь хамгийн зөв алхам. [ЗГМ]

төсөл

Их “юм” шийдэхийн тулд эрх мэдэл хэрэгтэй байна

Нэг саяас дээш хүн амтай дэлхийн 400 гаруй хотын нэг

Б.Сэлэнгэ
ЗГМ

Засаг, захиргааны тархай бутархай нэгжтэй, тэнд нь зах зээлийн жамаар амьдрах нөхцөл нэн хомс болохоор иргэд Монголын дөрвөн зүг, найман зовхисоос нүүдэллэн нийслэлээ бараадаж гэдэс дүүрэн амьдрах, үр хүүхдээ газрын мухарт түгжиж, боловсролгүй болгохгүй гэснийх. Бараг л сум бүрт өндөр хүчдэлийн шугам татаж, зам тавьж, гар утас, интернетийн сүлжээ барьдаг болсон ч хөдөөгөөс хот руу чиглэсэн их нүүдлийг хязгаарлаж огт чадсангүй. 500 мянган хүн амьдрах бүхий л тооцоо, төлөвлөлтэй өнөөдрийн Улаанбаатар өдгөө гурав дахин илүү ачаа үүрч байгаа. Гэвч өдөрт хэдэн зуу, мянгаараа нүүдэллэн ирэгсдийг захиргааны аргаар хорьчихоод байгаа болохоос уг нь тэднийг буруутгах, хориглох эрх хэнд ч байхгүй. Төвлөрөл нэмэгдэх тусам хотын асуудал улсын хэмжээнийх болж, том яригдах ёстой шаардлага үүсэн. Их “юм” шийдэхийн тулд нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, НИТХ-ын эрх мэдлийг нэмэх шаардлага тухалчрээ.

УИХ-аар удахгүй хэлэлцэх Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн талаар нээлттэй хэлэлцүүлгийг УИХ дахь Ардчилсан намын бүлэг зохион байгууллаа.

Улсынхаа нийт хүн амын бараг талыг өөртөө шингээж, улсын нийт эдийн засгийн 60-70 хувийг бүтээж байгаа нийслэл болон түүний удирдлагад зохих эрх мэдлийг нь өгөх ёстой гэж УИХ-д нийслэлээс сонгогдсон гишүүд хэлж байна.

Тулгамдсан асуудал нь хоолой даваад ирэхээр хөгжингүй хийгээд хөгжиж байгаа улс орнуудын төр, засаг нь Нийслэлийн даргаа Засгийн газрын бүрэлдэхүүндээ оруулдаг юм билээ. Тухайлбал, Энэтхэгийн нийслэл Делигийн дарга Ерөнхий сайдынхаа орлогчийн хэмжээний эрх мэдэлтэй байдаг бол Унгарын Будапешт, Кубын нийслэлийн Засаг дарга парламентын гишүүн байдаг аж. Цаашлаад Москва, Берлиний захирагч сайдын статустай байх юм. Харин Улаанбаатар хотын дарга Засгийн газрын хуралдаанд оролцож байгаа нь өрөвдөлтэй.

ПАРЛАМЕНТ

Алдар цолтон, ахмадуудад олгодог тэтгэмжийг шинэчилнэ

Монгол Улсын баатар, хөдөлмөрийн баатар, ардын болон гавьяат цолтон ахмад настанд төрөөс өндөр насны тэтгэвэрээс нь гадна нэмэгдэл олгодог.

Мөн төрийн шагналт, төрийн соёрхолт, ахмад дайчин, Улсын ударник, хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн ахмад настанд сар бүр олгох мөнгөн тусламж бий. 2008, 2012 онд батлагдсан хуулиудын дагуу нийт алдар цолтой 2440 ахмад настанд 4.5 тэрбум төгрөгийг улсын төсвөөс зарцуулж байжээ.

Өчигдөр УИХ-ын чуулганаар

Ердөө л мэдээлэл өгнө, асуултад хариулна. Гэтэл түүний хариуцсан хот улсынхаа ачааны дийлэнхийг үүрдэг. Хоолойд тээглэсэн асуудлаа шийдье гэхээр төсвийг нь Засгийн газар халаасалчихсан байх жишээтэй. Ийм үед хотын даргыг Засгийн газрын бүрэлдэхүүнд оруулах зайлшгүй нөхцөл үүсээд байгаа гэж тайлбарлаж буй.

Хэлэлцүүлэгт тус хуулийн төслийг боловсруулах Ажлын хэсэг, УИХ, Засгийн газрын гишүүд, нийслэлийн удирдлагуудыг урьсан байлаа. Гэвч хотын дарга С.Батболдын зөвлөхийг эс тооцвол яг ажил хариуцсан хүмүүс ирээгүй нь хэлэлцүүлгийг Ардчилсан намын байр сууриа илэрхийлэх боломж болгон хувиргасан юм.

Ц.БААТАРХҮҮ:НИЙСЛЭЛ ЭДИЙН ЗАСГИЙН ХУВЬД БИЕ ДААСАН БАЙХ ЁСТОЙ

Энэ үеэр НИТХ дахь Ардчилсан намын бүлгийн дарга Ц.Баатархүүгээс зарим зүйлийг тодрууллаа.

-Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг УИХ-аар хэлэлцэхэд бэлэн болсон. Энэ хуулиар нийслэлийн юуг шийдэх ёстой гэж бодож байна?

-Төслийг харахад хууль гэхээсээ илүү бодлогын баримт бичгүүдийг нэгтгэж өгсөн гэж харж байгаа. Засаг захиргааны нэгж, нийслэл, хот гэсэн гурван зүйлийн ялгааг хуульд тусгах ёстой. Нийслэл маань есөн дүүргээс бүтдэг. Харин Улаанбаатар хотын хувьд зургаан дүүргийг хамардаг. Тиймээс бусад хотуудаас нийслэл юугаараа ялгаатай гэдгийг л хуульд тодорхой тусгах шаардлага бий.

-Нийслэл бусад хотуудаас юугаараа ялгаатай байх ёстой

депутат, Улсын Бага хурлын гишүүн ахмад настанд сар бүр 150 мянган төгрөгийн нэмэгдэл олгохоор тусгасан байна.

2018 оны улсын төсөвт тэтгэвэр нэмэх эх үүсвэр болгож 117 тэрбум төгрөг тусгасан. Өнөөдрийн байдлаар нийгмийн даатгалын сангаас 388 мянган ахмад тэтгэвэр авч байгаа бөгөөд дээрх хэмжээний эх үүсвэр нь багагүй хөрөнгө гэдгийг салбарын сайд С.Чинзориг хэллээ. Гишүүдийн олонх нь нэмэгдлийн хэмжээ тогтоох тогтоолыг төслийг УИХ-аар хэлэлцэхийг дэмжсэн. [ЗГМ]

гэж?

Нийслэл төсвийнхөө арван төгрөг тутмын есийг нь татвар төлөгчдөөс бүрдүүлдэг. Нийслэл хотын иргэн татвараа өгчихөөд шаардлагатай төрийн үйлчилгээг авч чадаж байна уу гэдэг хамгийн чухал асуудал. Харин иргэддээ энэ эрхийг эдлүүлэхийн тулд нийслэл өөрөө эдийн засгийн хувьд бие даасан байх ёстой. Тиймээс эрх өгөх нь Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн гол зорилго. Өөрөөр хэлбэл, нийслэлийн ИТХ болон Засаг дарга юуг өөрөө шийдэх эрх нь тодорхойгүй байна. УИХ, Засгийн газрын түвшинд бүх эрх мэдлийг төвлөрүүлснээс болж нутгийн өөрөө удирдах ёс алдагдсан. Нийт хүн амын 45 хувь нь Улаанбаатар хотод амьдарч байна. Гэтэл агаар, хөрсний бохирдол, түгжрэл, төвлөрөл гээд толгойны өвчин болоод буй бүх асуудал Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуультай холбоотой.

-Хотын даргад Засгийн газрын гишүүний хэмжээний эрх мэдэл өгөх ёстой гэж УИХ дахь Ардчилсан намын бүлгийн гишүүд хэлж байна. Та үүнтэй санал нийлэх үү?

-Улаанбаатар хотын дарга Засгийн газрын гишүүний хэмжээний эрх мэдэлтэй байна гэдэгтэй би санал нийлдэггүй. Учир нь Ерөнхий сайдын шууд хараан дор ажиллах шаардлага гарна. Харин нийт иргэний эрх ашгийг хамгаалж бодлого гаргадаг, түүнийгээ УИХ, Засгийн газрын түвшинд хамгаалдаг, нөлөөлдөг байх ёстой. Гэтэл Засгийн газрын гишүүн болчихвол кабинетын зарчим гээд Засгийн газраас гарсан шийдвэрийг дагаж мөрддөг нэг агентлаг төдий л болох сөрөг талтай юм. [ЗГМ]

ТОВЧХОН

» ХАРИЛЦАА

Манай улсад үйл ажиллагаа явуулдаг гадаадын дипломат корпус, олон улсын байгууллагын удирдлагуудыг төрийн гурван өндөрлөг шинэ оныг тохиолдуулан хүлээн авч уулздаг уламжлалтай. Энэ дагуу Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Улаанбаатарт суугаа дипломат корпусын тэргүүн, гишүүд, Элчин сайд нарыг хүлээн авч уулзлаа. Уулзалтад, УИХ-ын дарга М.Энхболд, Ерөнхий сайд У.Хүрэлсүх, Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар нар оролцож, Элчин сайд нарыг хүлээн авав.

» МЭДЭГДЭЛ

Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайд Д.Загджав “Оюу толгой”-н үйл ажиллагааг зогсоох ёстой хэмээн байр сууриа илэрхийлсэн. Тэгвэл тус салбарын сайд Д.Сумъяабазар “Энэ бол манай яамны, сайдын байр суурь биш. Мөн Засгийн газрын ч байр суурь биш” хэмээн мэдэгдлээ.

» ТОМИЛГОО

Сангийн яам болон Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн даргын сонгон шалгаруулалтыг ирэх сарын 5-нд хийхээр болжээ. Сонгон шалгаруулалтад шаардлагад нийцсэн хэн ч бүртгүүлж, өрсөлдөх боломжтой гэж Төрийн албаны зөвлөл тодотгосон байна.

» ТОО

13

Хувь. Өнөөдрийн байдлаар нийт 250 мянга гаруй өрх ипотекийн зээлд хамрагдах хүсэлтэй байгаа ч ердөө 13 хувь нь зээлийн шаардлага хангаж буйг Сангийн сайд Х.Булгантуяа мэдээллээ.

» ШИЙДВЭР

Засгийн газраас Монгол Улсад 2018-2020 онд цагаачлуулж болох гадаадын иргэдийн тоо, бүтэц, байршлын тухай УИХ-ын тогтоолын төслийг хэлэлцээд, өргөн мэдүүлэх болов. Цагаачлах иргэдийн тоог жилд 100-гаас дээшгүй байлгахаар тогтоолын төсөлд тусгасан байна.

ЭШЛЭЛ



-Өмнөх хэрэгт хариуцлага тооцох асуудлыг шүүхээр шийдвэрлүүлж байгаа. Зарим асуудлыг шалгаж дуусаагүй. “Цэвэр агаар” санг татан буулгаж, манай яаманд өглөг, авлага нь шилжиж ирсэн. Өглөг хоёр тэрбум төгрөг байсныг БОАЖЯ барагдуулсан. Одоо 3.4 тэрбум төгрөг дээр эрүү үүсгээд явж байна.

Хоёрдугаарт, бүх гэр хороололд зуух тарахгүй. Утааг бий болгож буй түлшний асуудлыг тодорхой болгож, зарим бүсэд цахилгаан халаалт бий болгоно.

БОАЖ-ын сайд Н.Цэрэнбат

ТОДРУУЛГА & ЗАЛРУУЛГА

Уншигч та манай сонины мэдээ, нийтлэл, сурвалжилгатай холбоотой тодруулж, залруулах шаардлагатай санал, хүсэлт байвал

» **INFO@ZASAG.CO**

Утас: 99903584 хаягаар бидэнтэй холбогдоно уу.

Нийтлэлчийн булан

*Ашигтай
ажилладаг ч ард
түмний хувьцаанд
ногдол ашиг
өгөхгүй л байна*

◀1
Тэд стратегийн ордын дээрх хувьцааг иргэдэд ямар ч үнэ төлбөргүйгээр зүгээр л өгчихсөн юм. Үр дүнд иргэд хувьцаанд найдаж, нэг л өдөр ногдол ашиг гэж мөнгө авна гэж горьдож суусаар өнөөдрийг хүрэв. Гэтэл эдийн засгийн эргэлтэд орж, иргэн бүрт ногдол ашиг тараах үүрэг даалгавар хүлээсэн “Эрдэнэс Тавантолгой” компани өнгөрсөн хугацаанд өөдтэй явсангүй. Учир нь, тус компани өнөөг хүртэл уурхайн аман дээрээс нүүрсээ түүхийгээр нь зарж байна. Түүхий нүүрсийг нь



С.Батсайхан / ЗГМӨ

Төрийн өмчит компани ногдол ашиг тараадаггүй

Хятадын зуучлагч компаниуд маш хямд үнээр худалдан авч цааш дамладаг тогтолцоотой байна. Зарсан нүүрс нь орлого болох биш “Чалко”-гийн өрөнд явсаар өнгөрсөн онтой золгов. Ашигтай ажилласан хэмээн захирлууд нь зарладаг хэрнээ ард түмний хувьцаанд ногдол ашиг өгөхгүй л байна. Ашиг нь төсвийн алдагдлыг нөхөхөд л зарцуулагдаж байгаа юм. Нөхцөл байдал ийнхүү орвонгоороо эргэх болсон нь тэнгэр өөд цойлоод байсан Монголын “хар алт”-ны үнэ дэлхийн зах зээл унасантай шууд холбоотой. Өөрөөр хэлбэл, тухайн үед төрийн эрхийг барьж байсан бодлого тодорхойлогчид нүүрсний ханшийн өсөлтөд хэт найдаж, үр дүнд нь иргэн бүр үхмэл хувьцаатай, төр засаг нь алдагдал “үйлдвэрлэдэг” аж ахуйн нэгжтэй болоод үлдэв. Тэгвэл Монголын төр гаргасан


алдаагаа таван жилийн дараа дахин давтах гэж байна. УИХ-д үнэмлэхүй олонхыг бүрдүүлж буй МАН “Эрдэнэт үйлдвэр” хязгаарлагдмал хариуцлагатай компанийг нээлттэй хувьцаат компани болгож, нийт хувьцааны тодорхой хувийг иргэдэд эзэмшүүлэх шийдвэрийг урьдчилсан байдлаар гаргав.

Нийт хувьцааны 10 хувийг иргэдэд үнэ төлбөргүй тарааж, ногдол ашиг хүртээх боломжтой хэмээн ярьж буй нь нөгөө л таван жилийн өмнөх дүр зураг харагдаж байгаа юм. Хэрэв зэсийн ханш уруудвал “Эрдэнэт үйлдвэр”-ийн хувьцаа мөн л үнэгүйдэж, “Эрдэнэс Тавантолгой” компанийн 1072

хувьцааны бараан түүхийг давтана. Нөгөөтэйгүүр, зэсийн ханш өсөлтийн зүгт чиглэж, тонн тутамдаа 7000 ам.доллар даваад буй үед “Эрдэнэт үйлдвэр”-ийн хувьцааг иргэн бүрт үнэ төлбөргүй тараахаар зэхэж буй шийдвэр үнэн хэрэгтээ хувийн өмчид хууль бусаар халдсан төрийн алхмыг хаацайлах

гэсэн оролдлого. Товчхондоо, түүхий эдийн үнийн өсөлтөд хэт найдсан төрийн бодлого, шийдвэр алдаа болж, ард түмнийг хөлдөө чирдэг. Түүхий эдийн үнэ өссөн шигээ унадаг зах зээлийн зарчмыг Засгийн газрын бодлого дааж чадахгүй байна. Үнэ өссөн үед хувьцаа тараадаг, үнэ унасан үед өрний

нь буруу юм байна, хувийн хэвшилдээ итгээ, үлдээе гэсэн дийлэнх гишүүний байр суурь нь олон нийтэд ч, бизнесийнхэнд ч ихэд таалагдаж, улмаар УИХ-ын тогтоол болон гарсан нь тэр.



- **Бодлого тодорхойлогчид нүүрсний ханшийн өсөлтөд хэт найдаж, үр дүнд нь иргэн бүр үхмэл хувьцаатай, төр засаг нь алдагдал “үйлдвэрлэдэг” аж ахуйн нэгжтэй болоод үлдэв.**
- **Хэрэв зэсийн ханш уруудвал “Эрдэнэт үйлдвэр”-ийн хувьцаа мөн л үнэгүйдэж, “Эрдэнэс Тавантолгой” компанийн 1072 хувьцааны бараан түүхийг давтана.**

- **Хуулийн нэг заалтыг өөр өөрөөр ашиглаж байгаа нь төр үнэндээ хэн нэгэн, хэсэг бүлэг хүмүүсийн эрх ашигт хөтлөгдөж буйн илэрхийлэл.**

10 сая төгрөгийн шагналтай яруу найргийн наадам болно

**НЭРТ ЗОХИОЛЧ, ЯРУУ НАЙРАГЧ, ЭХ ОРОНЧ
З.ДОРЖ, О. ДАШБАЛБАР АГСНЫ НЭРЭМЖИТ
ЯРУУ НАЙРГИЙН НААДМЫН УДИРДАМЖ**

Монгол Улсын төрийн соёрхолт
Сүхбаатарын одонт, Соёлын
гавьяат зүтгэлтэн, нэрт зохиолч,
яруу найрагч **ЗУНДУЙН ДОРЖ**,
Монгол Улсын Төрийн шагналт,
төр нийгмийн нэрт зүтгэлтэн,
нэрт яруу найрагч
ОЧИРБАТЫН ДАШБАЛБАР
агсны нэрэмжит яруу найргийн
дээд шагнал гардуулах наадмыг
“Сод Монгол Групп” ХХК
санаачлан 01 дүгээр сарын 26-ны
өдөр зохион байгуулах гэж байна.

Шагналын сан:
1-р байр: Цом, 10.000.000 сая
2-р байр: Цом, 5.000.000 сая
3-р байр: Цом, ном хэвлүүлэх эрх

Яруу найргийн наадмын үе шат:
I үе шат- 2018.01.10-01.19-ний хооронд /Бүтээлийг цахим хуудсаар хүлээн авах: naadam@sodmongolgroup.com/ Шүүгчдийн бүрэлдэхүүний шийдвэрээр шалгарсан яруу найрагчид II,III шатанд өрсөлдөнө.
II, III үе шат-2018.01.26-нд Corporate Convention Center –т болно.

Холбоо барих утас: 99104180, 99096867
Яруу найргийн наадам зохион байгуулах холбоо

Яруу найргийн наадмын садаа:
I үе шат:
-Эх дагина Дондогдуламын үйл хэрэг,
-Эх дагина Дондогдуламын эрдэм чадал,
-Эх дагина Дондогдуламын нэрээр нэрлэсэн анагаах увидас нь олны дунд түгэн гайхагдсан Дондогдулам рашааны тухай
II, III үе шат
-Эх оронч сэдвийн хүрээнд өрсөлдөнө.

Оюуны боловсролд үнэлж баршгүй хувь нэмрээ оруулсан эх оронч, нэрт яруу найрагчдын алдрыг мөнхлөх, залуу хойч үедээ эх оронч үзлийг түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Сод Монгол Групп” ХХК-аас яруу найрагч, зохиолчдын дунд хамгийн өндөр шагналтай яруу найргийн наадмыг энэ жилээс эхлэн зохион байгуулахаар боллоо.

Энэхүү наадам нь Монгол Улсын төрийн соёрхолт Сүхбаатарын одонт, Соёлын

гавьяат зүтгэлтэн, нэрт зохиолч, яруу найрагч Зундуйн Дорж, Монгол Улсын Төрийн шагналт, төр нийгмийн нэрт зүтгэлтэн, нэрт зохиолч, яруу найрагч Очирбатын Дашбалбар агсны нэрэмжит бөгөөд энэ сарын 26 нд болох юм байна.

Зохиолч, яруу найрагч З.Дорж, О.Дашбалбар агсны нэрэмжит яруу найргийн наадмын тэргүүн байрын шагнал 10 сая төгрөг, хоёрдугаар байр таван сая төгрөг, гуравдугаар

байр ном хэвлүүлэх эрхийн эзэн болно.

Хамгийн өндөр шагналын сантай энэхүү яруу найргийн наадмын эхний үе шатанд зохиолчид:

-Эх дагина Дондогдуламын үйл хэрэг,
-Эх дагина Дондогдуламын эрдэм чадал,
-Эх дагина Дондогдуламын нэрээр нэрлэсэн анагаах увидас нь олны дунд түгэн гайхагдсан Дондогдулам рашааны тухай зэрэг сэдвийн хүрээнд naadam@sodmongolgroup.com имейль хаягаар 01 дүгээр сарын 19-ний өдрийн дотор бүтээлээ илгээх юм байна.

Нэгдүгээр шатанд ирсэн шүлэг, яруу найргийг мэргэжлийн шүүгчид шүүж шалгарсан бүтээлийн эзэд II, III шатанд эх оронч сэдвийн хүрээнд өрсөлдөх юм байна.

Зохиолч, яруу найрагч З.Дорж, О.Дашбалбар агсны нэрэмжит яруу найргийн наадам нь эх оронч сэтгэлгээг алдаршуулах, Монголд оюуны бүтээлийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, зохиолч уран бүтээлчдийг дэмжих зорилготой юм. Түүнчлэн Монголын яруу найрагч, зохиолчдын бүтээлийг гадаад хэлээр орчуулан олон улсад гаргах зорилгыг агуулсан болохыг Зохиолч, яруу найрагч З.Дорж, О.Дашбалбар агсны нэрэмжит яруу найргийн наадмыг зохион байгуулагчид онцолж байна.

**ЯРУУ НАЙРГИЙН НААДМЫН ТАЛААР
МЭДЭЭЛЭЛ АВАХ УТАС: 99096867, 99104180**

Гэхдээ УИХ тухайн үед нэн чухал хуулийн заалтыг “мартсан” байдаг юм. Тэр заалтаа өнөөдөр гэнэт санаж, “Эрдэнэт үйлдвэр” ХХК дээр хэрэгжүүлнэ хэмээж байна. Тэр нь Ашигт малтмалын тухай хуулийн 5.6 дахь заалт. “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа этгээд нь хувьцааныхаа 10-аас доошгүй хувийг Монголын хөрөнгийн биржээр арилжина” гэсэн заалт. Өнгөрсөн 10 жилийн хугацаанд амьдрал дээр огт хэрэгжээгүй заалтыг өнөөдөр гэнэт санасан нь хачирхалтай. Адилхан зэсийн орд, адилхан стратегийн орд, адилхан хувийн хэвшил. Гэхдээ өөр өөр ашиг сонирхол. Хуулийн нэг заалтыг өөр өөрөөр ашиглаж байгаа нь төр үнэндээ хэн нэгэн, хэсэг бүлэг хүмүүсийн эрх ашигт хөтлөгдөж буйн илэрхийлэл.

Төр засаг ээлжит популизм нь татварын нэмэгдлийн шуугианыг дарж, 10 хувийн хувьцаа өгөх нэрийдлээр ард түмнийг аргалах гэж оролдож байна. Гэхдээ ард түмэн өнгөрснийг мартаагүй. Тавантолгойгоос хувь өгнө гээд хулхидуулснаа мартаагүй. Үүнтэй адилхан Эрдэнэтийн 10 хувийг өгөх нэрийдлээр 90 хувийг төрд авч шахааны бизнесээ цэцэглүүлэх гэсэн далд бодлоготой байхыг үгүйсгэхгүй. Товчхондоо, төрийн өмчит уул уурхайн компани ногдол ашиг тараана гэж хэзээ ч байдаггүй. Ард түмэнд ашгийг нь өгнө гээд байгаа “Эрдэнэт үйлдвэр” гэхэд зэсийн үнэ цойлж байсан жилүүдэд хэдхэн тэрбумын ашиг тарааж байсныг тоо гэрчилнэ. [ЗГМ]

Судлаачийн үг



Пхеньяны эрх баригчдыг айлгаж ичээх хүчин дэлхийд алга гэмээр

Олхонуд Баярхүү
Судлаач профессор

Солонгосын хойгийн байдал онц ихээр хурцадмал байна. Пуужинт цөмийн зэвсэглэлээр Хойд Солонгос илэрхий хөөцөлдөж, зохих амжилтад хүрч байгаа нь тодорхой харагдлаа. Тэрхүү цөмийн зэвсэг, стратегийн пуужин нь тус улсын оршин байхын, тусгаар тогтнолын баталгаа гэгдэх дээрээ тулав. Тэгж хийрхэх түүхэн нөхцөл шалтгаан хангалттай байсан учраас БНАСАУ-ын төр засгийг зөвтгөх аргумент ч араас нь хангалтгүй цувах төлөвтэй. Энэ бүхний учгийг бага ч болов тайлах зорилгоор дараах өгүүллийг толилуулья.

2017 он БНАСАУ-ын түүхнээ тэмдэглэгдээр жил боллоо. Тус улс цөмийн зэвсэгтэйгээ албан ёсоор зарлаж, тив хоорондын баллистик пуужин бүтээж туршив. Дагалдаад зэвсэгт хүчнийх нь мөн чанарт өөрчлөлт орлоо. Солонгосын ардын арми хэмээн нэрлэж ирсэн явган цэрэг, танк, их буу, нисэх онгоц, багахан хэмжээний флоттой тэрхүү зэвсэгт хүчин нь эдүгээ Азид, тэр дундаа Зүүн Азидаа пуужинт цөмийн зэвсэг бүхий хүчирхэг армитай хэмээн тооцогдох болж байна.

Ийм хүчирхэг зэвсэг хэн хаанаас өгч бүтээлгэв гэдэгт түүхчид толгойгоо гашилгасаар өнөө хүрэх шиг боллоо. Тэр талаар баримт түшин дор өгүүлье.

1960-аад оноос эхтэй пуужинт техникийн бүтээн байгуулалтын



АНУ-ын Ерөнхийлөгч цөхрөнгөө барахын хэрээр түүний засаг захиргаа Хойд Солонгосын талаарх байр сууриа байн өөрчилж, холбоотон хайх болов.

итгүүлж, цөмийн хөтөлбөрөөс нь татгалзуулах гэнэ. Хятад энэ талаар АНУ-д тусалж байгаа, харин Орос байдаггүй хэмээн Трамп уулга алдан ярьжээ. Хариуд нь ОХУ бас нэг загвар болгох тайлбартай болж авсан. Тэр нь АНУ-ыг цөмийн цохилт өгөх, үйл явдлыг дэвэргэх хэнээрхлээсээ татгалз гэх санал юм. Санкц угсруулж тавиад үр дүнгүй байна, санкцын бодлогоо ч өөрчил гэсэн санал Оросоос өмнө нь цухалзсан.

Хойдуудын ойворгон занг явж явж дэлхий тэсэхээ болилоо, бас цөхөрлөө. НҮБ-д тогтоол санаачлагч, шавдуулагч АНУ бүр ч цөхөрлөө. НҮБ-д суугаа байнгын төлөөлөгч хатагтай Никки Хейли цөхрөлийн үгсээ урсгана. БНАСАУ-тай аливаа харилцаагаа таслаач хэмээн НҮБ-ын бүх гишүүн улсад

2017 он БНАСАУ-ын түүхнээ тэмдэглэгдэнэ

тухай өгүүлэх болж таарч байх шиг. Тухайн үеийн СССР, Хятад, мөн Ойрх Дорнодын зарим улс хамтран ажиллаж ирсэн түншүүд нь. 1960-аад онд СССР-ээс “Луна”, “Луна-М” (өөрсдөө “Фрог-5”, “Фрог-7” хэмээн нэрлэсэн) гэх хатуу түлшээр ажилладаг залуурт бус пуужин авч зэвсэглэлдээ оруулжээ. Дараа нь 1980-аад онд юм болов уу, Египетээс оператив тактикийн гурван пуужинг суурьтай нь авсан байдаг. Тэр нь шингэн түлшээр ажилладаг 8К14 (“Скад-В” гэж алдаршсан, өөрсдөө “Хвасон-5” хэмээн нэрлэнэ) хэмээх цогцолбор ба түүнийгээ дуурайлган үйлдвэрлэж эхэлсэн, гадаадад ч худалдсан. 1980-аад оны сүүлч үед Хятадын тусалцаатайгаар “Скад-С” (“Хвасон-6”) хэмээх шинэчилж сайжруулсан пуужин бүтээсэн.

Өрнөдийн зарим хэвлэлийн мэдээгээр баллистик пуужин бүтээх ажиллагаа нь 1988 онд эхэлсэн байдаг. Тэр нь хожим бүтээж туршсанаар бол шингэн түлшээр ажиллах, толгойн хэсэг нь салдаг дунд тусгалын баллистик “Нодон-1” (хөрвүүлбэл “Хөдөлмөр-1”, өрнийнхөн “Скад-Д” гэж нэрлэдэг) пуужин ба түүнийг бүтээхэд Иран, Ливи оролцсон гэх мэдээлэл буй. Энэ пуужин 1990-ээд оны төгсгөл хавьд тус улсын зэвсэглэлд албан ёсоор бүртгэгдсэн.

БНАСАУ 1998 оны зургадугаар сард пуужингийн хөтөлбөр хэрэгжүүлж байгаагаа дэлхий нийтэд албан ёсоор мэдэгдсэн бол дараагийн ээлжинд дунд тусгалын баллистик “Нодон-2” (2000 км-ийн тусгалтай) пуужингаа зарласан. Хожим 2007-2008 онд зэвсэглэлдээ хөдөлгөөнт байрлал бүхий пуужингийн KN-02 хэмээх цогц зэвсэгтэй болсон ба тэр нь оператив тактикийн зориулалттай. 1990-ээд онд Сириэс шилжүүлэн авсан зөвлөлтийн “Точка” хэмээх хатуу түлшний пуужингийн солонгос хувилбар байв.

Толгойн хэсэг нь ганц салдаг байсныг хоёр болгон “Тэпходон” (“Аугаа их аян”) пуужин бүтээх ажлаа 1990-ээд оны дунд үед эхлүүлж, “Тэпходон-1” пуужингаа бүтээгээд байна. Энэ нь “Нодон-1”-ийн сайжруулсан хувилбар. Нэг тонн жинтэй ачааг 2300 км зайд агаарт авч хөөрөх, 500 кг ачааг 3000 км зайд хүргэх хүчин чадалтай.

1998 онд “Тэпходон-1” пуужинг туршихдаа “Кванменсон-1” хиймэл дагуулыг сансрын тойрог замд гаргасан нь үнэхээр лут амжилт юм. Зөвлөлтийн “Точка” пуужингийн суурин дээр сайжруулалт хийсээр ийм амжилтад хүрчээ. Харин өнөөх хиймэл дагуул сансарт удсангүй, эргээд дэлхий рүү унаж, Номхон далайд живсэн учраас эл хөтөлбөрийг зогсоосон юм. “Тэпходон-1”-ээ дараа нь сэргээж, “Тэпходон-2” гэх баллистик пуужин (хольн тусгал нь 3500-6000 км) бүтээн 2006 онд туршсан боловч бүтэлгүйтжээ. НҮБ-ын Аюулгүйн зөвлөл

тогтоол баталж, тус улсыг баллистик пуужин бүтээлгэхгүй гэсэн боловч 2007 он гэхэд энэ төрлийн пуужин хийн ойрын зайд (120-140 км) амжилттай туршлаа гэх мэдээлэл Пхеньянаас цуурайтаж байв. Өмнөх “Скад” төрлийн пуужингуудаасаа цэц тусгал нь эрс сайжирлаа гэх мэдээ ч дагалдсан. Тэр үеэс хойш пуужин бүтээж турших, түүнийгээ сүрлэгээр зарлах, заналхийлэх явдал жил дараалан шахуу үргэлжилсээр өнөө хүрчээ.

2009 оны хавар сансрын тойрог замд “Кванмёнсон-2” (“Хурц од”) хэмээх хиймэл дагуул оруулж, түүнийгээ “Ынха-2” (“Сүүн зам”) пуужинд дайж хөөргөлөө, “Ынха-2” нь 700 кг ачааг 5000-6000 км зайд хүргэж чадахаа харуулав гэсэн мэдээ цацагдсан. Харин тийм хиймэл дагуул сансрын тойрог замд ороогүйг дэлхийн сансар судлалынхан нотолсон. Гэхдээ л “Ынха-2” олон угсраат пуужинг цэрэг дайны зорилгод ашиглаж магадгүй гэх хардлага үүсч, Хойд Солонгосыг буруушаах, санкцаар заналхийлэх явдал дэлхийн хамтын нийгэмлэгийн зүгээс нэг бус удаа цухалзсаар өнөө хүрчээ.

Өнөө цагт өрнөж буй үйл явдлын эх 2012 оны дөрөвдүгээр сарын 13-ны өдөр буюу их удирдагч Ким Ир Сений 100 жилийн ойгоор тохиожээ. Тухайн үед “Ынха-3” пуужингаар “Кванмёнсон-3” хэмээх хиймэл дагуулаа хөөргөсөн юм. Гэвч пуужин хөөрөөд хэдхэн минутын дараа хоёр хуваагдан далайд унажээ. “Тэпходон-2” пуужингийн технологийг ашиглан бүтээсэн ч бүтэлгүйтлээ өөрсдөө хүлээн зөвшөөрсөн. Дараагийн пуужин ба хиймэл дагуулаа өмнөх нэрээр нь “Кванмёнсон-3”, “Ынха-3” гэж нэрлэн Сохэ дэх космодромаас синхрон тойрог замд оруулсан боловч дэлхийн гадаргын хавьд баримжаагаа алдан төөрчээ.

Удалгүй 2016 оны “Ынха-3” хэмээх зөөгч пуужингаар “Кванменсон-4” хэмээх ээлжит хиймэл дагуулаа амжилттай туршлаа гэж мэдээлэв. Хэд хэдэн баллистик пуужингийн туршилт хийсний нэг нь Японы дээгүүр өнгөрч, тус улсын усан хилд унах нь тэр. Үүнээс улбаалан НҮБ-ын Аюулгүйн зөвлөл ээлжит тогтоол баталж, БНАСАУ-ыг эрс буруушаасан боловч Хойд Солонгос үл тоомсорлон туршилтаа үргэлжлүүлсээр 2017 оны тавдугаар сарын 14-нд 30 минутын турш 800 км-т пуужин хөөргөж эсэргүүцэгчдээ даапаалж байв. Япон тэнгист, Солонгосын хойгоос зүүн тийш 400 км зайд унасан эл пуужин Японы талын үзсэнээр 2000 км өндөрт ниссэн болж таарсан. Энэхүү “Хвасон-12” гэх баллистик пуужин атомын ба цөмийн цэнэгт хошуугаар зэвсэглэж өлхөн чадна гэж тэр үед мэдээлж байлаа. Тэр оныхоо тавдугаар сарын 29-нд Өмнөд Солонгосын Штабуудын дарга нарын хорооны (Жанжин штаб нь) мэдээлснээр үл танигдах нэгэн пуужинг Хойд Солонгосын

Вонсан хот хавиас хөөргөж, тэр нь дорно зүг хурдалсаар Японы эдийн засгийн үйл ажиллагааны бүсэд уналаа гэсэн дэлхийг дэлдийлгэсэн үйл явдал болсныг энд эшлэх нь зөв болов уу.

2017 оны намар устөрөгчийн цэнэг амжилттай туршсанаа Пхеньян зарласан. Түүнийгээ тив хоорондын баллистик пуужинд байршуулна гэдгээ ч мэдэгдсэн. Япон, Өмнөд Солонгосын цэргийнхэн устөрөгчийн тэр бөмбөгийн хөнөөх чадварыг 160 килотонн гэж багцааллаа. Японы Хирошима хотод 1945 онд хаяж сүйдлэсэн бөмбөгөөс 10 дахин их хүчин чадалтай гэсэн үг. Энэ бол хойдуулын хийсэн зургаа дахь цөмийн туршилт болж таарсан.

НҮБ-д түгшүүр улам мэдрэгдлээ. Аюулгүйн зөвлөл санал нэгтгэигээр БНАСАУ-ын эсрэг хориг тавьж, экспорт, импортын бүх боломж, гарцыг хязгаарлав. XXI зуун гарсаар НҮБ-ын Аюулгүйн зөвлөлөөс баталсан хамгийн хатуу чанга заалт бүхий тогтоол хэмээн тэр тогтоолыг нэрлэж байна. Пхеньян тэрхүү тогтоолыг өөрийнх нь эсрэг дайн зарласан хэрэг хэмээн сүржин мэдэгдэж, бүр ч нулимлаа.

Дээрхээс үзвэл БНАСАУ нь пуужинт цөмийн зэвсэглэлээр хөөцөлдөхдөө ажралыг үл тоон үргэлжлүүлсээр байх төлөвтэй. Түүнд саад болдог, зогсоож чаддаг нэг ч улс үндэстэн дэлхийд байхгүй мэт авирлана. Явж явж Бээжин л зогсоовол нэг зогсоох байх. Эс хүсвэл Пхеньяны эрх баригчдыг айлгаж ичээх хүчин дэлхийд алга гэмээр. Хэлэлцээний ширээний ард

асуудлыг шийдвэрлэх ёстой гэх Хятадын байр суурь байнга цуурайтна. Орос ч мөн тэгж мэдэгдэнэ. Хэрэв пуужингаа Япон руу чиглүүлэн харваад байх аваас замд нь устгана хэмээх Японы Ерөнхий сайд Шинзо Абэгийн мэдэгдлийн хариуд “хэлэлцээний ширээ” гэх ээлжит, залхуутай саналаа Хятад дэвшүүлсээр. Цаадуул нь хэлэлцээ хийхгүй ээ гэсээр байхад ингэж ярих нь нэг талын эмгэнэлтэй ч юм шиг. Хоёр улс нягт координац хийсний үндсэн дээр Хойд Солонгосын пуужинг амдан сөнөөж устгана хэмээн Шинзо Абэ, Дональд Трамп нар мэдэгдлээ. Тэгтлээ ч удах биз ээ.

Баллистик пуужин бүтээх ажиллагаа нь 1988 онд эхэлсэн байдаг

АНУ-ын Ерөнхийлөгч цөхрөнгөө барахын хэрээр түүний засаг захиргаа Хойд Солонгосын талаарх байр сууриа байн байн өөрчилж элдэвлэнэ, холбоотон хайна. Явж явж Оросыг гол түншээ гэж үзэж мэдэхээр. Путийн хэвлэлийн төлөөлөгчийн мэдээлснээр Вашингтоноос Трамп утас цохиж, Путинтэй ярилцсан. Хойд Солонгосын эргэн тойрны асуудлыг шийдвэрлэхэд Оросыг туслаач хэмэн хүссэн аж. Цагаан ордныхны ажигласнаар ганцхан Москва л Пхеньяныг

Эндээс ямар дүгнэлт хийх вэ? НҮБ-ын Аюулгүйн зөвлөл яаралтай хуралдаан зарладаг нь ч тоолж барахгүй олон боллоо. Хойд Солонгосын пуужин хөөргөж л байдаг, тэр дор нь Нью-Йоркт хуралдаж л байдаг. Гэтэл энэ бүхэнд дэлхий залхах байдалтай боллоо хэмээн үзэж болно.

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2018.01.12

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР:

Гэмтэл согог судлалын үндэсний төвийн 2018 онд худалдан авах эм, эмнэлэгийн хэрэгсэл, лабораторын урвалж, цус, цусан бүтээгдэхүүн худалдан авах нээлттэй тендер

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР: №201801001

[Гэмтэл согог судлалын үндэсний төв] эрх бүхий тендерт оролцогчдоос 2018 онд худалдан авах эм, эмнэлэгийн хэрэгсэл, лабораторын урвалж, цус, цусан бүтээгдэхүүн]-ыг нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна. Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь [50.000,00] төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн [45] хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:
Борлуулалтын хэмжээ:Сүүлийн 5 жилийн борлуулалтын хэмжээ 150,0 сая төгрөгөөс багагүй байх
Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Тендерт санал болгож буй үнийн днгийн 50 хувиас багагүй
Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: 2 жил
Сүүлийн гурван жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: 100,0 сая төгрөгөөс багагүй байх
Тусгай зөвшөөрөл ирүүлнэ.

Тендерийн хамт **tender.gov.mn** сайтад заасантай тэнцэх төгрөг, эсхүл түүнтэй тэнцүү чөлөөтэй хөрвөх валютын дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ. Тендерийг [2018 оны 2 дугаар сарын 12-ны 11 цаг 00 минут]-аас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг [2018 оны 2 дугаар сарын 12]-ний өдрийн, [11 цаг 30 минут]-д нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй. Дотоодын давуу эрх тооцно. Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

УБ. БГД 7-р хороо Гэмтэл согог судлалын үндэсний төв. Санхүү эдийн засгийн алба Утас: 70005031

ЗГМ: Сурвалжилга

Шинжлэх ухаанч бизнесүүд бодит дэмжлэгийн эрэлд гарчээ

Амжилттай бизнесийн тулгуур багана нь шинжлэх ухаан

◀ **БИЗНЕСИЙН ГАРАА, АНХНЫ БОРЛУУЛАЛТ**

ХААИС-ийн дэргэдэх “Гарааны агро энерги” компани ямар ч төрлийн үрийг бордоо болон бусад эрдсээр бүрэх боломжтой төхөөрөмж бүтээжээ. Энэ нь том, жижиг хоёр тогоотой бөгөөд үрийн хэмжээ, бордох бодисоос шалтгаалан тохируулдаг. Том тогоо нь нэг удаад 10 кг үр бүрнэ. Үүнд үрийн том, жижгээс шалтгаалж 10-30 минут зарцуулдаг байна. Ингэснээр үрийг чийгээ алдахаас хамгаалахаас гадна бордоо болон үрийг хэмнэдэг давуу талтай. Үр бүрт бордоо ногдлог учраас тун сайн ургадаг гэсэн үг. Таван сая төгрөгийн өртөгтэй уг төхөөрөмжийг уул уурхайн “Монполимент” компани нөхөн сэргээлтэд ашиглахаар анхны захиалгыг өгчээ.

Мөн малчдын хөдөлмөрийг хөнгөвчлөх автомат худгаа тус компанийн захирал, ХААИС-ийн Инженер, технологийн сургуулийн багш Д.Баатархүү танилцуулав. Энэ нь автомат-жуулсан нарны эрчим хүчээр ажилладаг усалгааны төхөөрөмж юм. Худгийн орчинд мал ирмэгц хөдөлгөөн мэдрэгч нь ажилладаг. Малыг дүрсээр нь ялгаж таньснаар ховоог усаар дүүргэдэг байна. Түүнчлэн ховооны ус багасах, ихсэхийг мэдэрдэг учраас ус татах хэмжээг нь тухай бүрт автоматаар зохицуулдаг аж. Харин өвлийн улиралд мал уугаад үлдсэн ус хөлддөг тул гар удирдлагад шилжүүлэх боломжтойгоор хийжээ. Уг автомат худга 1.5 сая төгрөгийн өртөгтэй. Харин хамгаалалтын хашаа, суурилуулах зардал, эрчим хүчний үүсгүүр, зай зэргийг нэмбэл худгийн гүнээс хамаарч таван сая орчим төгрөг болдог байна. “Энэ төхөөрөмж малчдыг тав тухтай амьдарч, мал услах цаг хугацааг өөр зүйлд зарцуулах боломж олгоно. Одоогоор эхний захиалга зөвхөн яриа төдий байгаа ч малчдад хэрэгтэй төхөөрөмж тул удахгүй ажил хэрэг болох байх” гэж Д.Баатархүү өгүүллээ. Дөрвөн жилийн өмнө их, дээд сургууль, шинжлэх ухааны



С.Батсайхан / ЗГМ©

байгууллагуудын дэргэд гарааны компаниуд байгуулах шийдвэр гарсан. Үүний дагуу байгуулагдсан отгон компанийн нэг нь ХААИС-ийн Инженер, технологийн сургуулийн багш нарын дээрх компани болж байна.

● **“Гарааны рецептор” компани өнгөрсөн жил 100 сая төгрөгийн хөнгөлөлт эдэлжээ.**

● **Инновацийн тухай хуульд орох гэж буй өөрчлөлтүүдийг хоног тоолон хүлээж байна гэв.**

● **Гарааны компаниудын шалгуурыг улам чангалах хэрэгтэй.**

АШИГ ӨГСӨН ШИЛДЭГ САНААНУУД

Мал эмнэлгийн салбарын хүнд ачааг хөнгөвчлөх инноваци шингэсэн 10 гаруй төсөл эрдэмтний ширээн дээр сан-

хүүжилт хүлээн өрөөстэй байна. ХААИС-ийн Мал эмнэлгийн хүрээлэнгийн дэргэдэх “Гарааны рецептор” компанийн 30 ам метр талбайтай жижиг лабораторид дөрвөн төрлийн бүтээгдэхүүн “бойжиж”, үйлдвэрлэлд нэвтэрчээ. Өнгөрсөн жил гэхэд харшил, амьсгалын замын өвчнийг анагаадаг царцааны бэлдмэлээ 38 мянган ширхгийг борлуулсан байна. Өмнө нь өдөрт 50 бэлдмэл үйлдвэрлэдэг байсан бол өдгөө хоёр дахин олныг хийдэг болжээ. Уг бэлдмэлийг хийхдээ орон нутгийн иргэдтэй гэрээ хийж, түүхий эдээ авдаг. Нэг кг хатаасан царцааг 50 мянган төгрөгөөр худалдан авдаг бөгөөд түүнээс 5000 ширхэг бүтээгдэхүүн гардаг аж. Үүнд ямар ч химийн бодис ороогүй, байгалийн гаралтай орцтой гэдгийг “Гарааны рецептор” компанийн захирал, шинжлэх ухааны доктор Я.Ганболд тайлбарлалаа.

Тус лабораторийн хөргөгчинд бэлэн болсон бүтээгдэхүүний дээжээс гадна судалгаанд ашиглаж буй цөөнгүй түүхий эд харагдлаа. Тухайлбал, харшил үүсгэдэг луулиар эм хийхээр хатааж бэлдсэн байна. Хаа саагүй ургадаг энэ шарилжид үрэвсэл дардаг бодис байдгийг тогтоож, дараагийн инноваци шингэсэн бүтээгдэхүүнээ хийхээр бэлдэж буй нь энэ аж.

Харин Шинжлэх ухаан, тех-

нологийн их сургуулийн дэргэдэх “Гарааны ШУТИС хүнс” компани аль хэдийнэ өөрийн гэсэн бүтээгдэхүүнтэй болж, гурван жилийн хугацаанд бүрэн бойжжээ. 10 орчим жилийн судалгаанд үндэслэсэн найман төрлийн хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг. Бүхэл үрийн, хөх тариа, буудайн хоёрдугаар гурилаар эмчилгээ сувилгааны зориулалттай талх, нарийн боов хийдэг.

Багш захиралтай компаниудын хамгийн том сорилт нь борлуулалт

Сард 6000 гаруй нарийн боов, 4-5 мянган талх борлуулдаг ч заримдаа захиалгаа гүйцэхгүй байх тохиолдол гардгийг тус компанийн захирал, шинжлэх ухааны доктор, профессор Д.Цэцгээ хэлж байлаа. “Мах импекс” компанийн төсөлд шалгарснаар тус компанийн байранд үйлдвэрлэлээ эрхэлдэг болжээ.

Бизнес, инновацийн бүтээлийг хослуулан амжилттай яваа бас нэг жишээ бол ХААИС-ын дэргэдэх “Гарааны монгол экологийн бордоо” юм. 2013 онд Агро,

экологийн сургуулийн багш нар малын бууцны биологийн идэвхт бодисуудыг үлдээж, ургамлын үртэй хамт боловсруулж экологийн цэвэр бордоо гарган авчээ. Эдний гурван төрлийн эрдсийн, хоёр төрлийн органик бордоог хэрэглэснээр ургац 30 хувиар нэмэгддэг гэдгийг туршилтаар нотолжээ. Анх жижиг цехээс гараагаа эхэлсэн тус компани өдгөө Төв аймгийн Баянчандмань суманд жилд 30-50 мянган тонн бордоо үйлдвэрлэх хүчин чадал бүхий үйлдвэртэй болж.

Манай орны бордооны жилийн хэрэгцээ 150-170 тонн байдаг бол уг үйлдвэр энэ зах зээлийн 30 хувийг дангаараа хангах боломжтой юм. Өнгөрсөн хугацаанд олсон ашгаараа 800 сая төгрөгийн лаборатори барьжээ. “Ямар ч үйлдвэрлэл судалгаагүй явна гэж байхгүй. Шинжлэх ухаан, бизнес хоёр нийлж байж инновацийн бүтээгдэхүүн бий болдог. Манай бордоог тариаланчид хавар 30 хувийн урьдчилгаа төлөөд, үлдсэнийг нь намар төлөн авах боломжтой. Мөн Төв аймгийн тариаланчдад 50 хувийн хямдралтай өгдөг. Цаашид үйлдвэрлэлийнхээ хэмжээ, борлуулалтыг нэмж, үнээ улам хямдруулахыг зорьж байгаа. 2020 онд Сэлэнгэ, Булганы тариалангийн бүсэд салбаруудаа нээхээр төлөвлөсөн” гэж тус компанийн захирал Ч.Багбаяр хэлэв.

ОЛОН СОРИЛТЫН ДУНД

Их, дээд сургуулийн дэргэдэх гарааны компаниуд аж ахуйн тооцоотой буюу өөрсдийн орлогоор санхүүждэг. Тэдний хувьд хамгийн том сорилт нь борлуулалт гэдгийг компанийн төлөөллүүд хэлж байлаа. Хэчнээн сайхан санаа, хэрэгцээтэй бүтээгдэхүүн байлаа ч түүнийг сурталчилж, борлуулж чадахгүй бол шүүгээнд тоосонд дарагдан хэвтэх хувь заяа хүлээж байдаг. Тиймээс өмнө нь хэний ч сэтгэж байгаагүй шинэ санаанаас бүтсэн инновацийн бүтээлийг амилуулахад эхний санхүүжилт амь тариа нь болж байдаг. Дээр дурдсан “Гарааны монгол экологийн бордоо” компанийн хувьд 2013 онд анх онд Өндөр технологи, инновацийн газраас 90 мянган ам.долларын санхүүжилт авч байжээ. Харин үүн шиг санхүүжилт авч чадаагүй компаниудын бизнес цаасан дээрх төлөвлөгөө хэвээр байгаа юм.

Уг нь Инновацийн тухай хуулийн анхны төсөлд шинжлэх ухааны байгууллагын дэргэдэх гарааны компаниудыг Инновацийн сангаас дэмжинэ гэж байсан ч хууль батлахдаа үүнийг хассан. Тиймээс эхний санхүүжилтийн асуудал зохицуулалт, дэмжлэгтгүй үлдсэн юм. “Гарааны агро энерги” компанийн захирал Д.Баатархүү “Их, дээд сургуулийн харьяа гарааны компанийн захирлуудын ихэнх нь багш нар. Багш нар бүтээгдэхүүний чанарт анхаарлаа хандуулна уу гэхээс борлуулалт, сурталчилгааны тал дээр мэдлэг байдаггүй. Тийм ажил хийгээд явах цаг зав ч гардаггүй. Тиймээс маркетингийн тал дээр дэмжлэг үзүүлэх нэг байгууллага хэрэгтэй гэж боддог” гэв. Харин энэ асуудлыг шийдэж чадсан компани бол “Гарааны монгол экологийн бордоо”. Эднийх ХААИС-ийн Эдийн засаг, бизнесийн сургуулийн багш нартай хамтарч маркетингаа хийдэг аж.

Гарааны компаниудын хувьд Инновацийн тухай хуульд орох гэж буй өөрчлөлтүүдийг хоног тоолон хүлээж буй. Тухайлбал, Инновацийн сантай болох, зарим төрлийн татвараас чөлөөлөх зэрэг заалт нэмэхээр ярьж байгаа аж. Мөн гарааны компани гэж ямар байгууллагыг хэлэх вэ гэсэн шалгуурыг улам чанга болгох шаардлагатай гэж зарим нь үзэж байна.

Гэхдээ ийм бизнесүүдийг Засгийн газар ор тас мартаж орхиогүй. Нэмүү өртгийн албан татвар болон хувь хүний орлогын албан татвараас чөлөөлдөг аж. Тухайлбал, ХААИС-ийн харьяа “Гарааны рецептор” компани өнгөрсөн жил 100 сая төгрөгийн хөнгөлөлт эдэлсэн байна. Нэг үеэ бодвол их, дээд сургуулийн дэргэдэх инновацид суурилсан бизнесүүд хөлөө олж эхэлжээ. Харин явалал нарийн зохицуулалттай, бодит дэмжлэгтэй болох вэ гэсэн бодлогын эрэлд бүгд гараад байна. [ЗГМ]

С.ЦОГТБАЯР ЗУРЖ БАЙНА



ЗГМ: Зочин

Б.Лхагважав: Татварын нэмэгдлийг цуцлах боломж бий

Татварын шинэчлэл эдийн засгийн өсөлтийн суурь болдог

З.Цэлмэг
@tselmegZGM

Энэ оноос хэрэгжиж буй татвар болон нийгмийн даатгалын шилтгэлийн нэмэгдэл бизнесийн орчинд хэрхэн нөлөөлөх талаар МҮХАҮТ-ын Ерөнхийлөгч Б.Лхагважавтай ярилцлаа.

-Татварын мөн чанар юу вэ гэдгээс яриагаа эхэлье. Яагаад гэвэл татварын нэмэгдлээс болж нийгэмд нэлээд бухимдал үүсээд байна?

-Татварын онол, систем, эрх зүйн үндсэн үзэл санаа нь Үндсэн хуулиас урган гардаг. Өмнөх нийгэмд иргэнээ өмчгүй байлгах, чөлөөт худалдааг хориглосон байсан тул татварын систем ч түүнд нь үйлчилж байсан. Харин нийгмийн тогтолцоо өөрчлөгдөж, иргэд аж ахуйн үйл ажиллагаа чөлөөтэй эрхэлж, тэр хэрээр хөдөлмөрийн харилцаа ч чөлөөтэй болсон. Тиймээс үүнд тохирсон татварын бодлого явагдах ёстой байсан. Гэвч бид 1992 оны Үндсэн хуулийн үзэл санаатай нийцсэн татварын системийг зах зээлд шилжихдээ бүрдүүлж чадаагүй.

1993 оноос татварын багц хуулиуд батлагдсан ч социалист үзэл санаа ихтэй байсан. Хууль хэрэгжүүлэгчид нь ч ялгаагүй. Энэ байдал явсаар байгаад 2005 онтой золгосон.

-Та тэр үеэс л эхлэн өдийг хүртэл энэ талаар ярьж байна?

-Надад ярих шалтгаан бий. Өнгөрсөн 27 жилийн турш бизнес эрхэлсэн миний хувьд эргэд харахад татварын бүх хууль нь хүн татвар төлөөд жаргалтай бус харин зовлон, дарамтад орох систем болсныг ойлгосон хэрэг. Уг нь иргэн хүн аж ахуй эрхлэхэд нь тусалдаг, зах зээл дээр зөв өрсөлдөөнийг бий болгоход татварын систем чиглэх ёстой. Тиймээс ч 2005 онд хийсэн татварын орчны шинэчлэлд тэрхүү сул талыг засаж сайжруулахад анхаарч, “дөрвөн 10”-ын бодлого гаргаж байлаа. Өмнө нь хувь хүн болон аж ахуйн нэгж орлогоосоо 45, 25, 15 хувийг татварт төлдөг, НӨАТ-т 15, нийгмийн даатгалын шимтгэлд 19 хувийг төлдөг байсан. “Дөрвөн 10”-ын бодлогоор энэ бүхнийг 10 хувь болгож бууруулсан юм. Харамсалтай нь, энэ бол татварын тоо, хэмжээг багасгасан зохицуулалт байнаас биш Үндсэн хуулийн үзэл санаанд нийцсэн, иргэндээ ээлтэй шинэчлэл болж чадаагүй.

-Татвараа төлдөг системийг 2008 онд бүрдүүлж чадаагүй -Энэ өөрчлөлтийн бодит ач холбогдол, бас сургамж нь юу байсан бэ?

-Шинэчлэл 2007 оноос үйлчилж эхлээд удаагүй байтал дэлхийн санхүү, эдийн засгийн томоохон хямралууд болсон. Харин бид татварын шинэ орчинтой эзрэгцүүлэн татварын өршөөл үзүүлснээр аж ахуйн нэгжүүд бүгд нэг гараанаас эхлэх боломж олгосон. Өршөөл үзүүлснээр 5.6 их наяд төгрөг буюу тухайн үеийн ханшаар дөрвөн тэрбум ам.долларын бараа ажил, үйлчилгээг ил болгож, 1992 оноос үйлчилсэн татварын хуучин системийг амжилттай хаасан. Ер нь нийгмийн шилжилтийн үед татварын тогтолцоо 10-15 жилийн хугацаанд шинэчлэгддэг зүй тогтол бий.

Түүнээс гадна тухайн үед “Оюутолгой”-н хөрөнгө оруулагчдаас дөрвөн тэрбум ам.доллар Монгол Улсад орж ирсэн. Ингээд өөрсдөө ил болгосон, гадаадын хөрөнгө оруулалтын нийт найман тэрбум ам.доллар л үндсэндээ 2010, 2011 оны эдийн засгийн өсөлтийг

бий болгосон юм шүү дээ. Гэхдээ татварын өршөөлийн хуулийг тэр үед бүртгэлтэй байсан 43 мянган компанийн 2200 нь л ашигласан. Хуулийн хүртээмж муу байсан нь зах зээл дээр хууль тэнцвэртэй бус үйлчилсэн хэрэг. Ингэснээр эдийн засгийн эрх чөлөө эдэлж чадсан компаниудын орлого эдийн засгийн ид өсөлтийн үед 3-5 дахин нэмэгдсэн. Ашиглаж чадаагүй 41 мянган компанийнх нь массаараа хоёр дахин багассан байгаа юм. Бас өршөөлд хамрагдсан аж ахуйн нэгжүүд цаашид татвараа яах аргагүй төлдөг системийг 2008 онд хийж өгч чадаагүй нь гол сургамж юм.

-Энэ удаагийн шинэчлэлээр тэр алдааг зассан уу?

-2011 онд би иргэний хөдөлгөөний гишүүн байхдаа тухайн үеийн Ерөнхий сайдтай татварын системийн өөрчлөлтийг төгс хийе, банкны системийг өөрчилье гэж тохиролцож чадсан. Эдийн засаг 17 хувь өсөж байсан цаг. Хэрэв уг хоёр өөрчлөлтийг хийж чадвал эдийн засгийн макро өсөлт татварын системээр дамжиж микро эдийн засагт шингэх байсан юм. Харамсалтай нь, 2012 онд хүрд эргүүлэх бололцоо олдоогүй.

Харин 2013 онд эхэлсэн хямрал татварын системийг шинэчлэхэд давуу тал болсон. Яагаад гэвэл хямралын үед л улстөрчдийн чих зөөлөрдөг байхгүй юу. Тиймээс хямралыг далимдуулж 2015 онд 145 мянган аж ахуйн нэгжийн санхүү, татварын тайлан балансыг нэг болгож, өмчийн хуваарилалтыг цэгцэлсэн. Тэгэхдээ 2008 оны алдааг давтахгүйн тулд НӨАТ-ын хуулийг шинэчилсэн. Үндсэндээ 2016 оноос санхүү бүртгэлийн хуулиуд бүгд шинэчлэгдсэн. Одоо татварын ерөнхий болон аж ахуйн нэгж, хувь хүний орлогын албан татварын хуулиудаа шинэчилж чадаагүй байгаа нь бидний дутуу хийсэн нэг ажил. Тийм учраас би УИХ-аас одоо батлахыг шаардаад байгаа юм. Энэ гурван хууль НӨАТ-ын шинэ хуультай араа шүдээрээ холбогдож, татварын шинэчлэлийг хурдасгах учиртай.

-Өнгөрсөн оны эдийн засгийн өсөлтийн ноён нуруу нь НӨАТ байсан. Энэ таны хувьд хэр зэрэг хангалттай үзүүлэлт вэ?

-НӨАТ-ын шинэ систем үйлчилж эхлэхэд улсын хэмжээнд 1700 касс байсан. Түүнээс хойш жил хагасын хугацаанд 63 мянга болж нэмэгдсэн байна. Өөрөөр хэлбэл, татварын орлого 1.3 их наяд төгрөгөөр давж биелсэн нь татварын бааз суурийг 40 дахин

өсгөсөн 63 мянган кассын машины үр дүн.

НИЙГМИЙГ БУХИМДУУЛБАЛ ТАТВАРЫН СИСТЕМ ГАЦНА
-Оны эхнээс хэрэгжиж байгаа бүхнүүн нэмэгдлийг эсэргүүцэгчдийн нэг нь та. Энэ шийдвэрийн учруулах хор уршиг нь их үү?

-Энэ шийдвэрийг гаргасан хүмүүс ОУВС-гийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд зүгээр цаасан дээрх тоо харж байгаад л татвар нэмэх ёстой гэж үзсэн. Уг нь татварын бааз суурь өргөжсөн, НӨАТ-ын систем сайжирсан, 2016 онд 500 тэрбум төгрөгөөр давж биелсэн гээд олон боломж байна. Гэвч энэ бүхнийг огт хараагүй учраас муйхар шийдвэр гаргасан. Төсвийн цоорхойг нөхөх маш амархан шүү дээ.

-Сангийн яаманд хичээл заах болчихсон бололтой?

-Заахгүй бол болохгүй байна. Сангийн яам дахиад муйхарлана гэдгийг мэдсэн учраас би их сургуулийн докторуудтай хамтраад улсын төсвийн долоон төрлийн орлого, зарлагыг оновчтой байлгах хоорондын хамаарлыг гаргаж, загвар боловсруулсан юм. Үүнийгээ онолын ном болгосон. Бас программыг нь ч бэлдэж Сангийн яам, УИХ-ын даргад гардуулж өгсөн. Ном нь хэвлэлтээс гарангуут УИХ-ын гишүүдэд үнэгүй тараана. Одоо татвар, төсвийн бодлогыг онолтой явуулахыг бид шаардана. Сангийн яам, ОУВС-гийн онолын загварыг үзэж, өөрсдийн боловсруулсантай харьцуулна.

-Та бүхний загвараар төсвийн алдагдлыг бууруулах ямар боломж байна вэ?

-Ойрын хоёр жилдээ гадаад өр зээлийг 122 хувиар багасгаж байж төсвийн алдагдал багасна. Мөн төрөл бүрийн татаасыг 77 хувь багасгаж хэрэгтэйг бидний боловсруулсан загвар харуулж байна. Татаас зах зээлийн эрүүл мэндэд асар их хохирол учруулдгийг нийтээрээ харж байгаа. Гурилын хувьд гэхэд үйлдвэрлэгчид импортын улаанбуудайг өөрсдөө худалдаж авсан нь илүү дээр гэдгээ хэлж байна шүү дээ. Мөн төрийн албан хаагчдын цалинг 10 хувь нэмэхэд төсвийн бусад орлого, зарлага яаж өөрчлөгдөж байгааг тооцоолж, харуулдаг. Нэг ёсондоо бид Сангийн яамны ажлыг хийгээд өгсөн хэрэг.

-Гол нь хэрэглэх юм болов уу?



Б.Ганбаяр / ЗГМӨ

-Миний хэлснийг аль болох түрүүлж хэрэгжүүлсэн нь хождог юм. Би 27 жил зах зээлийн тоглогч байсны хувьд макро эдийн засгийн сайн, муугийн горыг татвар төлөгчид үүрдэг гэдгийг биээрээ мэддэг хүн. Төгрөгийн ханш 80 хувиар унахад хэн гэдэг дарга хохирдог юм бэ. Та хэлж чадах уу. Ханшийн уналтын зөрүүг өнөө хэдэн компани нөхөж, эрсдэл үүрдэг. Тиймээс татвар төлөгчид бид татвартай холбоотой аливаа асуудалд маш сонор сэрэмжтэй байхгүй бол үргэлж дарга нарын буруу шийдвэрийн золиос болдог.

-Одоо мэдсээр байж л золиос болчихлоо шүү дээ?

-Өнгөрсөн оны дөрөвдүгээр сард гаргасан шийдвэр одоо хэрэгжиж байна. Хамгийн харамсалтай нь манайхан тэр үед “унтаж” байсан. Сүх далайтал үхэр амар гэгчээр. Гэхдээ аргыг нь олбол зарим нэг татварын нэмэгдлийг цуцлах боломж бий. Ч.Хүрэлбаатар сайдад нь хэлсэн. Тухайлбал, ХХОАТ-ын нэмэгдлийг гэр бүлийн гишүүдийн тоонд хуваах зохицуулалт хийхэд л хангалттай. Гэр бүлийн гишүүн тус бүрд 1.5 сая төгрөгийн орлого

ногдохгүй нь тодорхой шүү дээ. Дэлхий даяараа л ийм хүмүүнлэг арга хэрэглэж байгаа.

Энэ сарын дундуур ирэх ОУВС-гийнханд 1.3 их наяд төгрөгөөр давж биелсэн татварын орлогын дүнгээрээ тайлбарлаж болно шүү дээ. Татварын системийн шинэчлэлийн ачаар татварын орлого 26 дахин давж биелсэн. Тиймхээр татвар, цалинтай холбоотой асуудлаар нийгмийг хэрэггүй гэдгийг ойлгуулж, эвтэйхэн уучлалт гуйхад нааштай хариу өгнө гэж найдаж байна. ОУВС-гийн ард ч бас хүн л бий шүү дээ. Хэрэв татварын орлого биелээгүй байсан бол бид муухай царайлаад төлнө л дөө.

-Та маш их найдлага тавьж байна, тийм үү?

-Хэдийгээр ОУВС манайд хөтөлбөр хэрэгжүүлж байгаа боловч татвар нэмэх, хасах, байхгүй болгох онцгой эрх нь УИХ-д бий. Татварын орлого давж биелсэн нь 63 мянган кассын машины ач тус болохоос биш бизнесийн болон гадаад, дотоод орчин сайжирсантай огт холбоогүй шүү дээ. Тийм учраас уяагуучуд, ажилгүйчүүдийн тоо өссөн өнөө үед нийгмийг бухимдуулж яагаад ч болохгүй. Нөхцөл байдал хүнд байхад дахиад татвар нэмж нийгмийг бухимдуулбал татварын систем дахиад гацна шүү. Компаниудыг яаж урамшуулж, хөнгөлж байж энэ системийг бий болгосныг бүгд мэдэж байгаа. Одоо үүнийг гацаавал гурав дахь удаагаа хийж чадахгүй. Энэ шинэчлэлийг эхлүүлэх үед сөрөг хүчин байсан өнөөгийн эрх баригчид хар машиныг шатаана гээд л явж байсан шүү дээ. Гэтэл өнөөдөр үр шимийг нь хүртчихээд сууж байна.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН СИСТЕМ ХӨРӨНГӨ МЕНЕЖМЕНТ ТУЙЛЫН БУДУУЛЭГ

-НДШ нэмэгдсэнээс болж компаниуд цомхотгол хийнэ, эсвэл ажилчдынхаа цалинг өөр маягаар олгож эхэлнэ гэх мэтээр яриад байна л даа. Ер нь Засгийн газрын хүссэн шиг нийгмийн даатгалын сангийн орлого нэмэгдэх болов уу?

-Үүнийг компаниуд өөрсдодөө амраар зохицуулаад л явчих байх. Хамгийн гол нь нийгмийн даатгалын санд төвлөрдөг хоёр их наяд төгрөгийн менежмент туйлын бүдүүлэг байна. Энэ мөнгийг зах зээлд нь зөв эргэлдүүлж, өсгөх ажлаа л сайн хиймээр байгаа юм. ОУВС-д хандах болсон үндсэн шалтгаан бол эрх баригчид их мөнгөний менежмент ерөөсөө хийж чаддагтүйд л байгаа юм.

Манай улсын төсөв ДНБ-ий 30 орчим хувьтай тэнцдэг. Үлдсэн 70 хувь нь чөлөөт зах зээл дээр байгаа. Их мөнгөний менежмент хийж чаддаггүйгээс төсвийн 30 хувиас гадна цаана нь байгаа 70 хувийг ч давхар унагачих эрсдэл өндөр байгааг ОУВС мэддэг учраас л оролцоод байгаа юм. Тиймээс тусламж болгож өгч байгаа зургаан тэрбум ам.долларын менежментийг мэргэжлийн хүмүүсээр хийлгэх гээд байгаа юм. Харин тэдний хийсэн ажлын цалинг өөр хүмүүс аваад байна л даа /инээв/.

-Та татвар, НДШ-ийн нэмэгдлийг тооцоогүй хийсэн гэж байна. Харин тэтгэврийн насыг хойшлуулсан талаар бодлоо хэлэхгүй юу?

-Нэг хүн тэтгэвэрт гарахад дараагийн хүн орох ажлын байр бий болдог. Энэ сэлгээ хэдэн насанд оновчтой байхыг 1950-иад онд хүн төрөлхтөн судлаад мэдчихсэн юм аа. Хүний ид нас 42. Энэ үеэс хүн тэтгэвэрт гарах бэлтгэл хийгдээд, боловсон хүчний залуу үе доороосоо бэлтгэгддэг юм. Тиймээс эмэгтэй хүн 55, эрэгтэй хүн 60 насандаа тэтгэвэрт гардаг. Тэтгэврийн насыг нэмэх нь механикаар хийчихдэг зүйл биш.

ХҮНИЙ НӨӨЦ, ТЕХНОЛОГИДОО ХӨРӨНГӨ ХАЯСАН КОМПАНИ ХОЖНО

-Ажил олгогчид танд ямар зовлон хэлж байна?

-Татварын өршөөлөөр 33 мянган компани 34 их наяд төгрөгийн ажил, үйлчилгээг ил гаргасан. Тийм учраас гол хэлдэг зовлон нь харьцангуй намжаад байна. Гэхдээ дөрвөн жил үргэлжилсэн эдийн засгийн зудын дараа компаниуд дөнгөж л өндийж байгаагаар тул зах зээл дээр дахин байр сууриа олох гээд завгүй байгаа. Хамгийн гол нь, үүн дээр нь нэрмээс болж, дахиад татвар хураамж нэмж, ажилчдын сэтгэл санааг үймүүлэх хэрэггүйг анхааруулж байна.

Татварын нэмэгдлээ тайлбарлахдаа хөдөлмөр эрхлэгчдийн 6-7 хувьд л хамаатай гэж байна. Уучлаарай, тийм амархан зүйл байхгүй. Нарийн яривал, 1.5 сая төгрөгөөс дээш цалинтай хүмүүс бол мэргэжилдээ маш сайн, хөдөлмөрийн хуулийн арай өөр зохицуулалт үйлчилдэг хэсэг байдаг юм.

-Ажил олгогчдын хүсэж байгаа зүйл яг юу вэ?

-Манай бизнесийнхэнд тайван, тогтвортой орчин хэрэгтэй байна. 5.8 хувийн өсөлтөө гурван жил барьчихмаар байна. Уг нь компаниуд ажилчдынхаа цалинг нэмэх сонирхолтой байсан юм шүү дээ. Нийгмийн даатгалын сангийн алдагдал нөхөгдөх байсан гэсэн үг. Гэтэл одоо 1,499.000 төгрөгийн цалинтай болчихлоо. Нийгмийн шинжтэй аливаа зүйлд дээд, доод хязгаар тавихын хор нөлөө их байдаг юм. Сургамж ч бий. 1997 онд НӨАТ-ын хуульд компаниудын татвар төлөх борлуулалтын орлогод 10 сая төгрөгийн босго тогтоож өгсөн. Зөвхөн энэ заалтаас болж Монголын аж ахуйн нэгжүүдийг давхааруулж, компанийн хөгжилд хамгийн их гай тарьсан. 100 компанитай хүн хүртэл байлаа шүү дээ.

Тиймээс эрх баригчид ухаантай царайлахын оронд жимсээ хураахад бэлдэх ажлаа л сайн хий. НӨАТ-ын хар машинаа сайн байрлуулах хэрэгтэй. Тэгвэл 34 тэрбум биш 300 тэрбум байтугайг олно. Орлого олж л байгаа бол бүгд татвар төлдөг шударга тогтолцоог л хүсдэг. Татвараа төлж байгаа нь л зах зээлээ эзэлбэ гэж бизнес эрхлэгчид хэлж байна. Эцсийн эцэст нийгмээр хожих аргыг л хайх хэрэгтэй. Тиймээс татвар нэмэх биш хүндээ хөрөнгө оруулахыг компанидаа уриалсан нь хамаагүй үр дүнтэй. Өнгөрсөн жилүүдэд компаниуд ахуйгаа сайжруулсан бол одоо засаглалаа сайжруулж, хүний нөөц, технологидоо хөрөнгө хаях цаг ирсэн. Ингэсэн компани хожно. [ЗГМ]

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2018.01.12

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР:
Гэмтэл согог судлалын үндэсний төвийн 2018 онд худалдан авах өндөр өртөгт мэс засалд хэрэглэгдэх имплант, протез, хэрэгсэл худалдан авах нээлттэй тендер
ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР: **№201801002**

[Гэмтэл согог судлалын үндэсний төв] эрх бүхий тендерт оролцогчдоос Өндөр өртөгт мэс засалд хэрэглэгдэх имплант, протез, хэрэгсэл]-ыг нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь **[50.000,00]** төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютууд худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **[45]** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:
Борлуулалтын хэмжээ: Сүүлийн **5** жилийн борлуулалтын хэмжээ **300,0** сая төгрөгөөс багагүй байх
Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Тендерт санал болгож буй үнийн днгийн **50** хувиас багагүй
Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: **2 жил**
Сүүлийн гурван жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: **200,0 сая** төгрөгөөс багагүй байх
Тусгай зөвшөөрөл ирүүлнэ.
Тендерийн хамт **tender.gov.mn** сайтад заасантай тэнцэх төгрөг, эсхүл түүнтэй тэнцүү чөлөөтэй хөрвөх валютын дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.
Тендерийг **[2018 оны 2 дугаар сарын 12-ны 10 цаг 00 минут]**–аас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байцлуулан тендерийг **[2018 оны 2 дугаар сарын 12]**-ний өдрийн, **[10 цаг 30 минут]**-д нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй.
Дотоодын давуу эрх тооцно.
Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот. БГД 7 дугаар хороо Гэмтэл согог судлалын үндэсний төв. Санхүү эдийн засгийн алба
Утас: 70005031

ZGM DAILY

President demands serious actions against air pollution

The opposition pressures the Parliament to revoke tax raise.

Demand for foreign securities increases

The operational revenue of brokerage firms increased by 57 percent in 2017.

Meat exports reach 27.8 thousand tons as of December 2017

Meat exports totalled 7 times higher than the five-year average.

Bill on immigrants submitted

The bill stated to limit the annual number of immigrants at 100.

ZGM: HIGHLIGHTS

POLITICS

President Battulga Khaltmaa receives diplomatic corps.

Baatarbileg Yondonperenlei, Head of the Parliament's Standing Committee on Social Policy, Education, Culture and Science, meets Philip O'Keefe, a Lead Economist in the Social Protection and Labor Global Practice at the World Bank.

The Cabinet decides to submit a bill on number of foreigners who can immigrate to Mongolia in 2018-2020. The bill stated to limit the annual number of immigrants at 100.

ECONOMY

Rio Tinto drops out from bidding for a stake in SQM.

A total of 250 thousand households have applied for the 8 percent mortgage loan program; however, only 13 percent of the applications meet the loan requirements.

MSE ALL index increased 0.24 percent, to 1,153.99 points. The market cap stands at MNT 2.45 trillion.

SOCIETY

Mongolia to ill host five international competitions of Jiu Jitsu, Chess, Freestyle Wrestling, Boxing and Archery in 2018.

Bayan Mongol Ensemble of the State Philharmonic to perform 2018 Movie Swing Concert on January 19.

According to the Ministry of Food, Agriculture and Light Industry, Mongolians consume 2.5 times more salt than world average.

Parliament may be discharge as President stands firm on his stance



The President announces to dismiss the Parliament if the members fail to take decisive actions against air pollution.

On Wednesday, the President gave an interview to two television channels and said "The public is losing trust towards the authorities. Many complaints have been issued already. Several requests on disbanding the Parliament were also among them. I made my statement on the Parliament's session. I will support those requests."

Unfortunately, the attendance of members during the Parliamentary session to discuss air pollution was not enough. Furthermore, none of the National Security Council's order issued last year to the Parliament, Cabinet and capital authorities have been fulfilled; but instead, the Parliament is discussing temporary measures, such as stoves, masks and air purifiers.

The President added "The air pollution has to be solved alongside poverty and unemployment. Satellite cities near the capital needs to be established. If this solution is not going to work, let us employ the unemployed and develop vocational centers." [ZGM]

Enkhjargal.B, Tugsbilig.B

ZGM

The Government and capital authorities have discussed and implemented many projects and

programs with multiple billions of MNT for many years; however, the air pollution in Ulaanbaatar reached a disaster level this winter.


Although the citizens have been suffering from air pollution for several years, a case of a student

collapsing in their classroom had never been heard until now. Therefore, the President gave a warning to dismiss the Parliament if the issue is not solved soon. During his speech at the Parliament session last week, the President addressed

Ganbayar.B / ZGM©

"I will submit a request to dismiss the Parliament if no serious actions are taken against the air pollution". Additionally, the opposition party made an announcement that the Parliament must disband if the decision on tax raise is not revoked.

COMMODITY MARKET



SECURITIES MARKET

Securities market participants prefer foreign stocks over domestic securities



Batsaikhan.S / ZGM©

As of today, a total of 52 companies have been listed as underwriters, brokers and dealers at the Financial Regulatory Commission, of which 5 companies have permissions to participate in foreign stock exchange trades. Companies highlighting the fact that people are increasingly buying up foreign companies' stocks over domestic securities.

The popular instrument among them are Facebook, Alibaba and Tencent. For instance, the majority of stock trades conducted at Golomt Capital were foreign companies in 2017. However, the exchange rate risks and premiums raise issues when participating in foreign stock exchange trades. The regulation on dual listing, which was approved in

2017, now allows foreign stocks to be traded with MNT at Mongolian Stock Exchange.

As of the third quarter of 2017, the operational revenue of brokerage firms increased by 57 percent and reached MNT 5.5 billion. Accordingly, the net profit increased by 227 percent, to MNT 1.4 billion within the period, confirming the increase in financial market participants. Golomt Capital also informed that trades intensified after introducing online trading.

Additionally, "By taxing the savings interest revenues, the number of stock buyers have drastically increased and the number of clients quadrupled in the brokerage firms last year," reported TDB Capital. For instance, the number of individuals and enterprises participating in securities trade increased to 5200 in 2017, tripling the previous year's amount. Moreover, the MSE trades reached a record high of MNT 850 billion in 2017. [ZGM]

INDUSTRY

Meat exports showing sign of boom in 2018

Tugsbilig.B

@tugsbiligZGM

According to the Ministry of Food, Agriculture and Light Industry, the meat exports reached 27.8 thousand tons as of December 25, 2017. The total meat export totalled 7 times higher than the five-year average and three times the amount of previous year. As a result, the total revenue of meat exports reached approximately MNT 140 billion.

Mongolian Customs General Administration reported that horse meat formed nearly 90 percent of

meat exports, while goat meat, beef and mutton exports totalled 3 tons.

As of the end of December, Mongolia exported 24.9 thousand tons of horse meat to People's Republic of China, Russian Federation, Kazakhstan and Japan. Furthermore, heat-processed canned meat export totalled 2 thousand tons.

Mongolia's trade is heavily dependent on mining-industry. Therefore, the main economic objective is to diversify export products, especially the agriculture products.

According to a study of National Council for Food Safety, Mongolia

can export 27.9 thousand tons of beef, 43.6 thousand tons of horse meat in 2018. On the other hand, the Government set no limits to mutton and goat meat exports. Considering the current resources, a total of 61.4 tons of mutton and 47 thousand tons of goat meat can be exported in 2018.

As of December 2017, eight companies have a special license to export horse meat to PRC and six companies have the license for mutton and goat meat. The related ministry reported that a total of 29 companies have special license to export meat to Russia. [ZGM]

POLITICS

Baatarkhuu Tsend: the Mayor should not equal a Cabinet member

With an aim to broaden the Mayor's scope of responsibility and set the Mayor's authority to equal a Cabinet member status, the Revision of Law on Legal Status of the Capital City has been submitted to the Parliament and will be discussed soon. On this matter, Baatarkhuu Tsend, Head of the DP's group in the Citizens' Representative Khural of the Capital, informed "Around 90 percent of the city budget is

collected from the taxpayers. The public needs to receive public service equal to the taxes they have paid. In order to exercise their rights, the capital has to be independent, which is the main objective of the bill. Currently, the Governor and Citizens' Representative Khural's authorities are uncertain."

He further explained that the bill is required not because the city is overpopulated, but the lack of

government policies and regulations have raised a need to revise the legal status of the capital.

"However, I do not fully approve the bill. The authority of the Mayor should not equal a Cabinet member. Because the Mayor will be put under direct order of the Prime Minister. If that happens, the City Governor's Office will become a mere agency that follows the Cabinet's order," added Mr. Baatarkhuu Tsend. [ZGM]

Лавлах

АНХААРУУЛГА

Ибупрофен, нурофен эм үргүйдэлд хүргэдэг



М.Мөнхзул
ЗГМ

АНУ-ын Шинжлэх ухааны академийн “PNAS” сэтгүүлд ибупрофен болон нурофен эмийг эрэгтэйчүүдийн үргүй-дэлд хүргэдэг талаар мэдээлжээ. Сүүлийн үед ялангуяа, баруу-ны орнуудад эрэгтэйчүүдийн үр тогтоох чадвар муудаж, үргүйдэл ихсэх хандлагатай болсон тул эрдэмтэд судалгаа хийхээр шийдсэн байна. Хэдийгээр дэлхий дахинд янз бүрийн өвчин намдаагчийн хэрэглээг эрэгтэйчүүдийн үргүйдэлтэй холбож сэжиглэдэг байсан боловч нарийн судалгаа огт хийгээгүй байсан аж.

Европын Денмарк эмийн үйлдвэрийн эрдэмтэд эдгээр эмийг эсийн үржвэр дээр судлахад эр бэлгийн эсийн үйл ажиллагаанд шууд өөрчлөлт орж, ялангуяа шар биеийн гормонууд өөрчлөгдсөн байна. Тиймээс эдгээр өөрчлөлтүүдийг эр бэлгийн эсийг идэв-хигүйжүүлж, үргүйдэл үүсгэх үндсэн гол шалтгаан болдог гэж дүгнэсэн байна. [ЗГМ]

онцлох мэдээ Улсын аварга малчид тодорно

Монгол түмний уламжлалт Цагаан сарын баярын өмнө Засгийн газраас оны аварга малчин, тариаланч, фермерийг шалгаруулдаг уламжлалтай. Энэ жил 128 хүн улсын аварга малчин болох болзол хангажээ. Мөн Хошой Аварга малчин 11, аварга саальчин 13, Аварга фермер таван аж ахуйн нэгж, Тэргүүний тариаланч хамт олон 10, Аварга тариаланч 27 тус тус тодорсон байна. Засгийн газраас удахгүй аваргуудын нэрийг олон нийтэд мэдээлнэ. [ЗГМ]


ТЕХНОЛОГИ Гар утсыг нөүтбүүк болгодог систем

Лас Вегаст энэ долоо хоногт болж байгаа CES үзэсгэлэн дээр Razer компани Project Linda хэмээх төсөл танилцууллаа. Энэ нь гар утсыг нөүтбүүк болгодог систем юм. Тодруул-бал, гар утасаа зөөврийн компьютерийн сууринд суулган ажиллуулж болдог шийдэл юм. Razer-ийн шийдэл нь гар утсыг нөүтбүүкний точпад хэсэгт суулгадаг. Ингэхэд USB-C оролтоор суурьтай холбогдож, гар утасны дэлгэц нөүтбүүкний дэлгэц болж шилждэг аж. Ингэснээр гар утасны дэлгэц нь нөүтбүүкний хоёр дахь дэлгэц болно. Нөүтбүүкний суурь нь зөв-хөн 1080p дэлгэц, баттерей, нэмэлт хатуу диск агуулсан тул гар утасгүйгээр бие дааж ажиллахгүй юм. [ЗГМ]

ТВ ХӨТӨЛБӨР

	MNB	Bloomberg	Боловсрол	Монгол ТВ
08.00	07.00 “Өглөө” хөтөлбөр	08:00 “Bloomberg Daybreak Asia”	08.05 “Монголчууд XX зууны эхэнд” нэвтрүүлэг	06.30 “Өнөө өглөө”
12.00	11.00 “Монголын мэдээ” мэдээллийн хөтөлбөр	11:30 “Эврика” нэвтрүүлэг	12.10 Үүнийг хэрхэн хийдэг вэ?	12.00 “Хөтөч” мэдээллийн хөтөлбөр
14.00	15.35 Хөгжмийн агшин	14.00 “Дэвид Рубенштэйний шоу” нэвтрүүлэг	15.00 “Япон хэлний” алсын зайн сургалт / анхан шат №9/	15.30 “Цэнхэр тэнгисийн домог” СОАК 11 дүгээр анги
18.00	17.00 Самбо бөхийн улсын аварга шалгаруулах тэмцээн-2018 /шууд/	17.00 “Bloomberg Surveillance”	19.00 “Долоон өдрийн хатан” ОАК 12 дугаар анги	18.30 “Наашаа Цаашаа”
20.00	20.00 “Цагийн хүрд” мэдээллийн хөтөлбөр	20.00 “Блумбергийн ярилцах цаг” нэвтрүүлэг	20.40 “Баярлалаа ээжээ” кино бүтсэн түүх	20.00 “Оргил цаг” мэдээллийн хөтөлбөр
22.00	23.35 Үдшийн мэдээ	22.00 “Орон сууц санхүүжилтийн форум” нэвтрүүлэг	23.00 “Их хотын амьдрал” ОАК 1.19-20 дугаар анги	00.00 “Чадвал намайг хуур ОАК 36 дугаар анги

ЗГМ: ҮГИЙН СҮЛЖЭЭ



БОСООГООР:

- 13 настайдаа АНУ-ын Залуучуудын аварга болж, 14 настайдаа Их мастер болсон дэлхийн аварга шатарчин (АНУ)
- Галдан Бошигтод охиноо өгсөн бөгөөд түүнээс ихэд айдаг байсан, Манж Чин улсын хаан Энх...
- 1970-аад оны үедээрлэг танхай тоглолтоороо цууд гарсан Канадын алдарт

хоккейчин

4. Аливаа нэгэн байгууллагын салбар нэгж
5. Төрийн шагналт найруулагч
6. ӨМӨЗО-ны Шилийн гол аймгийн хошуу
10. Сүм хийдийн ханархуй, бурангуй үзлийн золиос болж амьдаараа шатаагдсан Италийн эрдэмтэн, одон оронч
11. Шийтгэл
12. Олон улсын эрүүгийн шүүх ажиллагаа явагддаг Голландын хот
13. Уран бүтээл

ХӨНДЛӨНГӨӨР:

- Францын мөнгөний нэгж
7. Их хэлмэгдүүлэлтийн үед хороогдсон Монголын анхны нисэгч
8. Дугуйт тэшүүр
9. Шүхэртийн овгийн нэг наст өвслөг ургамал

10. Арван засгийн наадмын түрүү бөх, "Арвайхээрийн" хэмээх арслан
12. Хоолны газар
14. Дэлхийд агаарын бохирдлоор тэргүүлэгч хот
15. Он, сар, өдөр
16. Хэрлэнгийн хөдөө аралд байсан Чингис хааны их ордон

Өмнөх дугаарын хариу / 1.11



ЗГМ: СҮДОКУ


		1	3		5	8		
	4	2	7				6	
5				6			1	7
7				8			9	5
		5	4		7	6		
8	6			3				4
2	3			7				6
	9				3	7	4	
		7	6		9	1		

8	7	1	5	4	2	9	6	3
9	5	4	1	6	3	2	8	7
6	2	3	8	9	7	5	1	4
1	9	8	7	3	4	6	5	2
5	4	2	9	8	6	7	3	1
3	6	7	2	1	5	8	4	9
7	1	5	3	2	8	4	9	6
2	3	6	4	5	9	1	7	8
4	8	9	6	7	1	3	2	5


(Өмнөх дугаарын хариу)

ЦАГ АГААР

УЛААНБААТАР	I.12	I.13	I.14	I.15	I.16
	-9° -21°	-13° -18°	-14° -22°	-15° -23°	-16° -25°
Үүлшинэ	6 м/с 4 м/с	8 м/с 5 м/с	7 м/с 5 м/с	7 м/с 5 м/с	6 м/с 5 м/с
Үүлшинэ	Үүлшинэ	Ялимгүй цастай	Багавтар үүлтэй	Үүлшинэ	Үүлшинэ



ЗГМ. КОМИКС



ҮЗВЭР

УДБЭТ

А.Хачатуряны "Спартак" балет энэ сарын 27, 28-нд тоглоно. Уг балетыг анх 1984 онд Монголын тайзнаа Ардын жүжигчин, Хөдөлмөрийн баатар Б.Жамъяндагва хөрвүүлэн дэглэж, тайз чимэглэлийг Ардын зураач Ч.Гунгаасүх хийсэн байна. Тасалбарын үнэ 10-20 мянган төгрөг.

Ж.Вердийг "Трубадур" дуурийг ирэх сарын 3,4-нд тоглоно. Италийн суут хөгжмийн зохиолч Ж.Вердийн томоохон бүтээлүүдийн нэг болох дуурь нь дөрвөн бүлэг, найман үзэгдэлтэй. Энэ дуурийг анх 1853 онд Ромын Аполло театрт тоглож байсан бол 140 гаруй жилийн дараа Монголын тайзнаа амилуулсан билээ. Тасалбарын үнэ 10-20 мянган төгрөг бөгөөд 150 минут үргэлжилнэ.

УДЭТ

"Ромео & Жульетта" сонгодог жүжгийн 120 дахь удаагийн тоглолт энэ сарын 16-18-ны 17.00 цагт болно. Хагас мянгагны гэртээд бичигдэж, зуун зууны туршид хүн төрөлхтний аугаа хайр сэтгэлийн бэлгэ тэмдэг болон мөнхөрч, хэн бүхний зүрх сэтгэлийг эзэмдсэн энэ бүтээлийг УДЭТ гурав дахь удаагаа Төрийн соёрхолт Н.Наранбаатарын орчин цагийн шинэ тавилтаар дахин туурвилаа. Тасалбарын үнэ суудлын зэрэглэлээс хамаарч 10-30 мянган төгрөг.

УЛААНБААТАР ЧУУЛГА

Сүүн цагаан сэтгэл уран бүтээлийн тоглолт энэ сарын 18-нд болно. Улаанбаатар чуулгын гоцлол дуучин МУГЖ С.Гэнзоригийн бие даасан бүрэн хэмжээний тоглолтоо хийх гэж авна. Тасалбарын үнэ 10 мянган төгрөг.

МИШЭЭЛ ЭКСПО

Цагаан сарын баярт зориулсан үзэсгэлэн худалдаа энэ сарын 15-18-нд болно. Өргөтгөсөн худалдаагаар баярын ширээний хүнс болон бусад барааг үйлдвэрийн түнээр нь худалдаж авах боломжтой.

ЗУРХАЙ



Билгийн тооллын 26

Өвлийн дунд хар хулгана сарын гурдан хөх мэнгэтэй, хөх луу өдөр. **Үс засуулбал:** Жаргал үргэлжид ирнэ **Наран ургах: шингэх:** 08.29-17.27 **Барилдлага:** Шид **Шүтэн барилдлага:** Тийн мэдэхүй **Суудал:** Ус

Аргын тооллын нэгдүгээр сарын 12, Бархасвадь гараг. Билгийн тооллын 26, Онгоц одтой, хөх луу өдөр.

Өдрийн наран 08.29 цагт мандаж, 17.27 цагт жаргана. Тухайн өдөр хулгана, бич жилтнээ аливаа үйл хийхэд зерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр буян номын үйлд шамдах, бүтээл туурвил эхлэх, худалдаа арилжаа хийх, бизнес эхлэх, зэрэг дэвших, лус тахиx, хур оруулах, зэтгэрийг номхотгох, хөгжмийн зэмсэг урлах, дарханы үйлд сайн. Гүүр тавих, газар ухах, цөөрөм байгуулахад муу. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Хол газар яваар одогсод зүүн зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал жаргал үргэлжид ирнэ.

ГАЛТЭРЭГНИЙ ЦАГИЙН ХУВААРЬ

Москва-УБ	21.35	07.30
УБ-Москва	13.50	14.28
УБ-Эрхүү	21.10	02.40
Эрхүү-УБ	15.35	06.20
УБ-Замын-Үүд	20.00	07.50
Замын-Үүд-УБ	21.35	09.55
УБ-Эрдэнэт	20.30	07.45
Эрдэнэт-УБ	19.10	05.48
УБ-Сүхбаатар	10.55	19.52
Сүхбаатар-УБ	06.30	15.35

НИСЛЭГИЙН ЦАГИЙН ХУВААРЬ

УБ-Бээжин	08.15	10.30
Бээжин-УБ	11.30	04.00
УБ-Сөүл	00.00	03.20
Сөүл-УБ	13.00	15.50
УБ-Хонконг	07.50	12.25
Хонконг-УБ	13.25	18.05
УБ-Москва	08.00	09.50
Москва-УБ	00.00	07.10

Компаниудад халгаатай Трампын бодлого

Хөдөлмөрийн зах зээлээс нэг сая ажилчныг гаргавал “бүгд орвонгоороо эргэнэ” хэмээн ноён Донохью өгүүлсэн юм. > 10

Хэрэгцээгүй зам байгуулж буй Бээжинг Канберра шүүмжлэв

БНХАУ 2006-2016 оны хооронд Номхон далайн орнуудад 1.8 тэрбум ам.долларын зээл, тусламж олгожээ. > 10

Brent сүүлийн гурван жилийн үнэмлэхүй түвшинд өслөө

Бэлэн нөөц дундарсаар байгаа ч нефтийн зах зээл геополитикийн нөхцөлөөс шалтгаалан эмээг хэвээр. > 10

Мүн Жэ Ин Умардын удирдагчийг уулзалтад урив

Брайн Харрис, Катрина Мансон

Өмнөд Солонгосын Ерөнхийлөгч Мүн Жэ Ин Хойд Солонгосын удирдагч Ким Жон Унтай дээд хэмжээний уулзалт хийхэд бэлэн байна гээд үүний гол зорилго нь хойгийг цөмийн зэвсэглэлээс ангижруулах явдал хэмээн мэдэгдэв. Хоёр Солонгосын дулаарал дарангуйлагч дэглэмд үзүүлэх олон улсын шахалтыг сулруулах нь гэсэн болгоомжлолд ноён Мүн тайлбар өгөв. Тэрбээр хэлсэн үгэндээ Пхеньяны эсрэг хоригийг дагаж мөрдөхөө давтан илэрхийлсний зэрэгцээ дээрх саналыг тавьсан байна. Цагаан ордон лхагва гарагт гаргасан мэдэгдэлдээ Ерөнхийлөгч Трамп Өмнөд Солонгосын Ерөнхийлөгчтэй утсаар ярихдаа АНУ ба Хойд Солонгосын хооронд “зохих цагт, зөв нөхцөл байдалд” хэлэлцээ хийхээс татгалзахгүй гэж хэлснийг мэдээлэв.

Жил үргэлжилсэн пуужингийн туршилт, заналхийллийн дараа Умардын төлөөлөгчид Өмнөдийн албаныхантай мягмар гарагт нэг ширээнд нүүр тулан сууж, хоёр жилийн дараа анх удаа хэлэлцээ хийсэн билээ. 12 цаг үргэлжилсэн хэлэлцээний дараа Пхеньян Сөүлтэй цэргийн хэлэлцээгээ



Ноён Мүн баяр хүргэхийн хамт яриа хэлэлцээ хийж, 75 сая солонгосчуудад энх тайван, тогтвортой байдлыг авчрах найдвар тээж байгаа юм.

BBM©

сэргээхийг зөвшөөрснөөс гадна Өмнөдөд болох өвлийн олимпод тамирчид, албан төлөөлөгчдөө илгээхээ мэдэгдсэн. Ийм өрнөлд ноён Мүн баяр хүргэхийн хамт дайнч, тусгаарлагдсан дэглэмтэй яриа хэлэлцээ хийж, 75 сая солонгосчуудад энх тайван, тогтвортой байдлыг авчрах найдвар тээж байгаа юм.

Гэвч түүний бодлого дээд сэргийн шахалт үзүүлж буй

Вашингтоны хүчин чармайлтыг нурааж болзошгүй тул ноён Мүн Пхеньяны эсрэг хоригийн дэмжсэн хатуу байр сууриа мэдэгдэв. Тэрбээр “Өмнөд Солонгос олон улсын шахалт, хоригийг дэмжсээр байх болно. Бидэнд Умардын эсрэг хоригоо дангаар зөөлрүүлэх төлөвлөгөө байхгүй” гэсэн юм. Цагаан ордны мэдэгдэлд түүнчлэн хоёр Ерөнхийлөгч утсаар ярих үед ноён

Трамп дээд зэргийн шахалтын арга хэмжээ маш чухлыг дахин нотолсон гэжээ.

Үүний өмнөхөн Өмнөдийн Гадаад хэргийн яамны ажилтнууд олимпын үеэр Пёнчанд ирэх боломж олгохын тулд Хойд Солонгосын албаныханд тавьсан хоригийг түр цуцлах асуудлыг авч үзнэ гэж ярьсан юм. Ноён Мүн дээд хэмжээний уулзалт хийх саналаа давтсан боловч уулзахын

төлөө уулзалт хийх шаардлагагүй хэмээн тайлбарлав. Тэрбээр АНУ-ын шахалт Умардыг хэлэлцээний ширээнд суулгасан байж магадгүй гээд АНУ-ын Ерөнхийдөгчид талархал илэрхийллээ. Ноён Мүн “Өмнөд, Умардын яриа хэлэлцээ эхэллээ. Бид уулзалтыг хоёр Солонгосын харилцааг сайжруулах болон Хойд Солонгосын цөмийн асуудлыг хэлэлцээний замаар

FT

Нью-Йорк хот эрчим хүчний компаниудыг шүүхэд өгчээ



BBM©

Аттракта Мун, Эд Крукс

Нью-Йорк хотын эрх баригчид дэлхийн томоохон компаниудыг уур амьсгалын өөрчлөлтөд буруутгаж, хэдэн тэрбуммаар тооцогдох шүүхийн зарга үүсгэлээ. Хотын захиргаа бүр олборлодог түлшний компаниудад 189 тэрбум ам.долларын хувьцаа эзэмшдэг өөрийн тэтгэврийн сангуудын хөрөнгийг итгэмжлэлийн дагуу өөр салбар руу шилжүүлэх асуудлыг судалж үзэхээ мэдэгдэв. Нью-Йоркийн захирагч Билл де Блассио хэлэхдээ хотоос уур амьсгалын өөрчлөлтөөс хамгаалахын тулд “BP, Chevron, CopocoPhillips, ExxonMobil, Royal Dutch Shell зэрэг компаниас хохирлын нөхөн төлбөр авахыг эрмэлзэж байна” гэжээ.

Тэрбээр “Бид уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг тэмцлийг шууд олборлодог түлшний компаниуд руу чиглүүлж байгаа. Тэд хортойг нь мэддэг мөртөө ашгаа хамгаалахын тулд нийгмийг төөрөгдүүлдэг. Уур амьсгалын өөрчлөлт муудах тусам биднийг ийм байдалд оруулсан олборлодог түлшний компаниуд Нью-Йорк хотыг илүү тогтвортой, аюулгүй болгох зардлыг хуваалцах ёстой”

хэмээн онцлов. Нью-Йорк хотын холбооны шүүхэд мэдүүлсэн энэхүү зарга уур амьсгалын өөрчлөлтийн бодлого ашигт нь хэрхэн нөлөөлөх талаар хөрөнгө оруулагчдын судалгаан дээр нэмэгдлээ. Калифорни мужийн хот, тосгод уур амьсгалын өөрчлөлтөөс хүлээх хохирлын асуудлаар дээрх таван компанийг шүүхэд өгсөн нь одоо хэлэлцэх шатандаа явж байгаа юм.

Еххон компани эдгээр заргыг “Хууль хэрэгжүүлэх ба зарга мэдүүлэх тактикийг буруугаар ашигласан явдал. Энэ нь уур амьсгалын өөрчлөлт ба энэ бодлогыг үндэсний хэмжээнд хэлэлцэхэд оролцох компаниудын эрхийг царцаах оролдлого” хэмээн шүүмжлэв. Нью-Йоркийн захирагчийн алба саяхан илэрсэн баримтуудаас үзэхэд эрчим хүчний компаниудыг олборлодог түлш шатаах үйл явц нь дэлхийн агаар мандалд нөлөөлнө гэдгийг мэдэж байсан гэж буруутгажээ. Энд бичсэнээр “Тэд санаатайгаар төөрөгдүүлэх кампани өрнүүлж, дэлхийн дулаарал ба түүний нөлөөг үгүйсгэхийн хамт олборлодог түлшний борлуулалтаас ашиг олж, өөрсдийн өмч хөрөнгөө

далайн түвшин дээшлэлт, уур амьсгалын өөрчлөлтөөс хамгаалах арга хэмжээ авсан” байна.

Еххон хариуд нь “Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг далд санаагүй ямар ч тэмцлийг дэмжинэ. Хүлэмжийн хийн нөлөөг бууруулахад дэлхийн шийдэл шаардлагатай” гэжээ. “Харин манай эдийн засаг болон гэр бүлийн амьдралыг тэтгэдэг бүтээгдэхүүн үйлдвэрлэгч салбарын эсрэг ийм төрлийн зарга нь явуургүй зүйл” хэмэв. Өмнө нь тус компани уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийг ойлгож байсан авч олон нийтэд хүргэхийг хязгаарласан гэх дайралтыг няцаажээ. Еххон уг нотолгоог нефть, хийн эсрэг бүлгүүдийн бодож олсон, мөнгө төлж зохиомлоор хийсэн зүйл хэмээн тайлбарласан юм. Тус компани дээрх мэдээ бол компаниудын мэдэгдлүүдээс өөртөө тааруулан тасалж аваад мушгин Засгийн газрууд дулаарал болон цаг уурын үзэгдлийн нөлөөг багасгах талаар ажиллаж байна. Гэвч АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамп уг гэрээнээс гарахаар шийдвэрлэсэн. Дэлхий даяар Засгийн газрууд уур амьсгалын талаар хатуу зохицуулалт хийвэл хөрөнгө нь үнэгүйдэж болзошгүй хэмээн тэтгэврийн сангууд олборлодог түлшний комданиуд дахь эзэмшлээ татаж эхэлсэн байна.

FT

Сэтгүүлчдийг шүүхээс авч явах үеэр Ва Лоне “Бид үнэнийг илчлэхийг оролдсон учир цагдаа нар баривчилж, бидний эсрэг үйлдэл хийж байна” гэв.



BBM©

Мьянмар Британийн хоёр сэтгүүлчид ял тулгалаа

Жон Рид

Мьянмарт баривчлагдсан Reuters агентлагийн хоёр сурвалжлагчийг чөлөөлөх олон улсын шахалт үргэлжлэхийн сацуу энэ улсын ардчилсан шилжилтэд эргэлзээ үүсэлээ. Гэтэл прокурорууд хоёр сэтгүүлчид албан ёсоор ял төлөвлөхөөр бэлтгэж байгаа бололтой. Мьянмарын Рахин мужид аюулаас хамгаалах хүчнийхэн рохинжа омгийнхныг залхаан цээрлүүлж буй тухай сурвалжилга бэлтгэхээр ирээд өнгөрсөн сард баривчлагдсан Ва Лоне, Киав Со Оо нарыг лхагва гарагт Янгон хотын шүүхэд авчирсан байна. Тэдэнд колонийн үеийн Албаны нууцын тухай хуулийн дагуу ял тулгасан нь 14 жил хүртэл хорих шийтгэлтэй юм.

Тэднийг баривчилсны дараахан Мьянмарын эрх баригчид гавтай зургийг нь нийтлээд “Сэтгүүлчид хэвлэлд гаргах зорилгоор хууль бус аргаар мэдээлэл олж авсан” гэж мэдэгдсэн. Сэтгүүлчдийн ар гэрийнхэн ярихдаа тэд Янгоны нэгэн зоогийн газарт цагдаагийн ажилтнаас баримт бичиг авч байгаад баригдсаныг өгүүлжээ. Сэтгүүлчдийг шүүхээс авч явах үеэр Ва Лоне “Бид үнэнийг илчлэхийг оролдсон учир цаг-

даа нар баривчилж, бидний эсрэг үйлдэл хийж байна” гэв. Тэднийг цэргийн дэглэмийн үед улс төрийн хоригдлууд хорьдог байсан Янгоны шоронд хорьжээ. Reuters агентлаг Мьянмарын эрх баригчид сэтгүүлчдэд ял тулгах гэж байгаад маш сэтгэл дундуур байгаагаа мэдэгдэв. Тус агентлагийн ерөнхий редактор Стефен Адлер “Үүнийг бид хэвлэлийн эрх чөлөөнд ямар ч анхааруулгагүйгээр бүдүүлгээр халдсан явдал гэж үзэж байна. Манай ажилтнуудад Мьянмарын үйл явдлыг сурвалжлах ажилдаа эргэн орох боломж олгох ёстой” гэжээ. Мьянмарын Мэдээллийн сайд Пе Миент Financial Times сонины сурвалжлагчид өгсөн ярилцлагадаа “Тэднийг шударгаар шүүх бөгөөд гэм буруугүй нь тогтоогдвол чөлөөлнө. Би хэргийн шинж чанар болон яг юу болсныг сайн мэдэхгүй байна” хэмээн тайлбарлав.

Гэвч тэрбээр тус улсын иргэний засаглалаас илүү төрийн эрхийг атгадаг цэргийнхэнтэй уулзаж, сэтгүүлчдэд туслах арга хэмжээ авах асуултад хариулахаас татгалзлаа. Ноён Миент цааш нь “Би ардчилал, үг хэлэх эрх чөлөөнд итгэдэг. Гэвч бид бүрэн тогтсон ардчиллын улс биш. Ардчилал руу шилжих

шатандаа явж байна. Бид ардчилсан тогтолцоо, эрх зүйн дэд бүтэц байгуулж, хэрэгжүүлэх ёстой” гэсэн юм. Ва Лоне ажлын гараагаа эхлэхдээ People’s Age сэтгүүлд Пе Миентийн удирдлага дор ажиллаж байжээ. Сайд хуучин хамт ажиллаж байсан сэтгүүлчийг идэвхтэй залуу байсан гэж дурссан байна.

Гадаадын бусад мэдээллийн агентлагуудын адилаар Reuters Мьянмарын цэргүүд Рахин мужид рохинжачуудыг хайр найргүй цээрлүүлж байгааг мэдээлж байгаа. Энэхүү дайралтын улмаас 655 мянган рохинжа хүн хөрш Бангладеш улс руу зугтаж гарсан явдлыг НҮБ болон АНУ “үндэстний цэвэрлэгээ” хэмээн нэрлэсэн. 2016 онд засгийн эрхэнд гарсан Ан Сан Сучийн Засгийн газар уг явдлыг Рахин мужийг “Бенгалийн алан хядагчдаас цэвэрлэх цэргийн ажиллагаа” хэмээн өмгөөлж байгаа юм. АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Рекс Тиллерсон хоёр сэтгүүлчийг нэн даруй суллахыг шаардсан бид НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гутеррес Мьянмарт хэвлэлийн эрх чөлөө хумигдаж буйд түгшиж байгаагаа илэрхийллээ.

FT

Нэг сая ажилтан, ажилчдыг албадан гаргах аюул нүүрлэсэн нь эдийн засгийн өсөлтөд аюулт нөлөөтэйг АНУ-ын худалдааны танхимын тэргүүн анхааруулав.



BBM©

Компаниудад халгаатай Трампын бодлого

Барни Жопсон

АНУ-д ажилладаг нэг сая цагаачийн оршин суух хуулийн статуст Цагаан ордон заналхийлж буй нь эдийн засгийн өсөлтөд халгаагтайг бизнесийн бүлгийнхэн Ерөнхийлөгч Дональд Трампд санууллаа.

АНУ-ын Худалдааны танхимын тэргүүн Том Донохьюгийн хэлсэн үг татварын шинэчлэлийг уухайлан дэмжиж байсан бизнес эрхлэгч америкчууд Трампын санаачилгыг эсэргүүцэгч болон шуурхай хувирч буйн нотолгоо болов.

Том Донохью гадаад худалдааны асуудлаар урьд нь ч ноён Трампыг шүүмжилж байлаа. Умард Америкийн чөлөөт худалдааны хэлэлцээрээс гарах нь “сүйрлийн уршигт алдаа” хэмээн үзсэн тэрбээр АНУ-ыг хуучин хэлэлцээрээ сэргээхийн оронд шинэ тохиролцоо байгуулах нь зүйтэй хэмээн зөвлөв.

Цагаачлалын асуудлаарх ноён Трампын хатуу байр суурь бизнест садаатайг тайлбарласан Донохьюгийн үгс АНУ-ын бизнесийн гол лобби бүлгийн байр суурь болжээ. “Ажиллах хүчээ дэмжиж өргөжүүлэхгүй юм бол та бид эдийн засгаа тогтвортой өсгөж чадахгүй гэдгийг хэлэх байна”.

Тэрбээр Трампын засаг захиргааны хэд хэдэн арга

хэмжээг шүүмжилсэн юм. Үүнд 2001 оны аймшигт газар хөдлөлтөөс хойш АНУ-д хуулийн дагуу амьдарч буй 200 мянга орчим сальвадорчуудын “түр хамгаалалттай статус”-ыг цуцлах тухай мэдэгдэл ч орж байна.

Эдүгээ АНУ-д хууль бусаар нэвтэрсэн 800 мянган насанд хүрээгүй цагаач хүүхэд бий. Барак Обама dreamers гэгддэг эдгээр хүүхдийг албадан гаргах аюулаас аврахын тулд DACA (Deferred Action for Childhood Arrivals) хөтөлбөр хэрэгжүүлж хамгаалалтад авсан бол ноён Трамп уг зохицуулалтыг хүчингүй болгохоор бэлтгэж байгаа юм.

Трампын засаг захиргаа DACA хөтөлбөрийг цуцлах эрхгүй гэсэн шийдвэрийг АНУ-ын холбооны шүүх мягмар гарагт гаргасан ч хууль эрхийн занал бодитой болж хувирлаа. АНУ-ын цагаачлалын агентлаг лхагвар гарагт олон арван 7-Eleven дэлгүүрт шалгалт хийлээ. Цаашид иймэрхүү шалгалт олшрох төлөвтэйг сүлжээ дэлгүүрийн удирдлага тайлбарлаж байв.

Хөдөлмөрийн зах зээлээс нэг сая ажилчныг гаргаж орхивол “бүх юм орвонгоороо эргэнэ” хэмээн ноён Донохью хэвлэлийн хурал дээр өгүүлсэн юм. “Олон жилийн дараа хүмүүст гэнэтхэн саёонара гэж хэлж таарахгүй.

Ийм юм болох учиргүй” хэмээн тэрбээр тайлбарлав.

АНУ-ын бизнесийн бүлгийнхэн 2016 оны сонгуулийн кампаниас хойш ноён Трамптай халуун, хүйтэн сэлгэсэн харьцаатай явж ирлээ. Компаниуд дотоодын татвар, зохицуулалтыг багасгах Трампын амлалтыг талархдаг ч глобалчлалыг шүүмжилдэг, дотооддоо шигдмэл популист бодлогод нь түгшдэг.

Трампын засаг захиргаа дэлхийн худалдаанаас хөндийрөх аргагүйг ноён Донохью тайлбарлав. Умард Америкийн чөлөөт худалдааны хэлэлцээрийг шинэчлэх яриа хэлэлцээр нь “зах зээл хаагдах, хөрөнгө оруулалтад үүсгэсэн хамгаалалт сулрах, худалдаа буурах юм уу зогсох” шалтгаан болох учиргүй хэмээн тэрбээр үзэж байлаа. АНУ-ыг уг хэлэлцээрээс гаргах ноён Трампын сүрдүүлэг нь “сүйрлийн уршигт алдаа” хэмээн ноён Донохью мэдэгдлээ. “Бид хариу довтлох хэрэгтэй. Стратегийн түншүүдтэйгээ тогтоосон гадаад худалдаа, хөрөнгө оруулалтаа өсгөх нь зүйтэй. Жишээ нь Энэтхэг бол нэн тэргүүний түнш. Ойрх Дорнод, Африк зэрэг өсөн дэгжиж буй бүс нутагт аль болох анхаарах хэрэгтэй. Байгаа зах зээлдээ гай болохын оронд шинэ зах зээл нээх, аль болох олон яриа хэлэлцээ өрнүүлэх

шаардлагатай”.

Худалдааны танхим бусад зүйлд ч түгшиж байна. Технологи, Цахиурын хөндийн хүчин чадалд дургүйцэх явдал газар авсан нь хэт хөнгөн бодлого үүсэх суурь хэмээн ноён Донохью анхааруулав. “Технологийг адлах явдал газар авсаар инноваци, дэвшил хөгжлийг саатуулагч өргөн хүрээтэй зохицуулалт болж хувирахаас болгоомжлох хэрэг гарч байна”.

Ирэх арданнэгдүгээр сарын сонгуулийн үеэр конгрессын хоёр танхимд Бүгд найрамдахчууд хяналтаа тогтооход нь туслах кампанийг бизнесийн бүлгийнхэн өрнүүлэх гэж байгааг Худалдааны танхимын тэргүүн мэдэгдсэн юм. Ялангуяа бизнесийн төлөө байр суурьтай нэр дэвшигчдийг дэмжихэд “эрс идэвхтэй” байр суурь баримтлахаа ноён Донохью тайлбарлав.

Тэрбээр “Стив Бэннонууд, Элизабет Уорренууд гэх мэт хоёр намын хэт үзэлтнүүдийн аль алиных нь эсрэг эрс тэмцэнэ” хэмээн өгүүллэв. Уг тайлбар нь саяхан хэвлэгдсэн дуулиант номд хэлсэн үг нь орсноос болоод Цагаан ордны зэвүүг хүргэсэн Трампын хуучин зөвлөх, мөн сенат дахь зүүн жигүүрийн гишүүн хоёрыг хэлж буй хэрэг юм.



Brent сүүлийн гурван жилийн үнэмлэхүй түвшинд өслөө

Анжил Равал

ОПЕК тэргүүтэй олборлогчид үйлдвэрлэлээ танаж, дэлхийн газрын тосны нөөц бууран, геополитикийн дарамт үүсэж, АНУ-ын занарын олборлолт эрчимжсэнээс үүдэн Brent түүхий тосны үнэ сүүлийн гурван жилийн үнэмлэхүй түвшинд өслөө.

Дэлхийн газрын тосны бенчмарк лхагва гарагт баррель нь 69.37 ам.доллар болсон нь 2015 оны тавдугаар сараас хойш тохиолдож байгаагүй өсөлт юм. Бенчмарк дараа нь Лондоны биржид үдээс хойш 68.87 ам.доллар болон буурсан ч өдрийн дүнгээрээ долоон центээр үнэтэй байв.

“ОПЕК-ийн гишүүд, ОХУ олборлолтоо бууруулж, бэлэн нөөц багассаар буй шинэ орчин бүрдлээ. Үүн дээр геолополитик ч түгшүүртэй боллоо” хэмээн Petromatrix консалтинг компанийн Оливье Жэйкоб тайлбарлав. Иранд тавих нь тодорхойгүй байсан АНУ-ын хориг сэргэх магадлал ихсээд байгааг тэрбээр дурдсан юм.

Зах зээлийн нөхцөлтэй төдийлэн нийцээгүй энэ удаагийн үнийн өсөлт “шинэчилсэн зохицуулалт” үүсгэх эрсдэлтэйг Commerzbank-ны Карстен Фриц зэрэг шинжээч анхааруулж байна. Харин эсрэг байр суурьтай шинжээчид АНУ-ын доллар суларч, дэлхийн эдийн засгийн өсөлт сайжирсан нь газрын тосны эрэлт төдийгүй үнэ өсөх хүчин зүйл хэмээн тайлбарлав.

Нэгдүгээр сарын 5-наар төгссөн долоо хоногт түүхийн тосны нөөц 4.9 сая баррелиар багасаж, 419.5 сая болсныг АНУ-ын Засгийн газраас гаргасан статистик баталж байна. Харин Америкийн нефтийн хүрээлэнгээс (American Petroleum Institute) гаргасан өөр тооцоог үзвэл, энэ долоо хоногт газрын тосны нөөц бүр 11 сая баррелиар буурчээ. АНУ-ын түүхий газрын тосны бенчмарк WTI (West Texas Instruments) ч мягмар гарагт 2014 оноос хойш тохиолдож байгаагүйгээр өссөн. Өсөлт лхагва гарагт үргэлжилж, баррель нь 33 центээр дээшлэн 63.31 ам.доллар болов.

2018 онд олборлолтоо үргэлжлүүлэн бууруулах картелийн

шийдвэрээс үүдэлтэй өсөлтийг эдийн засаг нь бэрхшээлтэй ОПЕК-ийн зарим орон өөдрөг үнэлж байна. Brent-ийн үнэ өнгөрсөн арваннэгдүгээр сараас хойш бараг 10 хувиар өслөө.

Олборлолтоос илүүгээр орлогод анхаардгаа АНУ-ын занарын тосны компаниуд мэдэгдсэн. Гэтэл тус улсад занарын тосны үйлдвэрлэл өссөөр байгаад бусад олборлогч түгшиж эхэллээ. Занарын тосны үйлдвэрлэл энэ онд аварга амжилт тогтоож, ирэх 2019 онд өдөрт 11 сая баррельд хүрэх тооцоог АНУ-ын Эрчим хүчний яам гаргав. АНУ-ын байр суурь дэлхийн газрын тосны бэлэн нөөцийг багасгах бусад олборлогчдийн хүчин чармайлтад бэрхшээл учруулж болзошгүй.

Газрын тосны үнэ баррель нь 60 ам.доллараас дээш өсөхийг ОПЕК-ийн гишүүн зарим улс таашаахгүй байгааг Ираны Газрын тосны сайд Бижан Зангане дурдсан юм. Газрын тосны үнэ ингэж өсөх нь АНУ-ын занарын тосны салбарыг дэмжсэн хэрэг болно хэмээн сайд тайлбарласныг Ираны мэдээллийн Shana агентлаг уламжиллаа.

Сүүлийн хэд хоногт Brent-ийн үнэ өссөн нь олборлолт буурч, цаг агаар хүйтэрсэнтэй холбоотойг ноён Зангане тайлбарлаж байна. “Нефтийн бүтээгдэхүүний эрэлт ихсэж, үнэ нь өсдөг өвөл болчихоод байна шүү дээ” хэмээн сайд анхааруулсан юм.

Хэт хуримтлагдсан бэлэн нөөц дундарсаар байгаа ч Венесуэл зэрэг улсын олборлолт тасалдах магадлал, олборлогч зарим улсын геополитикийн нөхцлөөс шалтгаалан газрын тосны зах зээл эмзэг хэвээр.

Дэлхийн тэргүүлэх гүрнүүдтэй байгуулсан цөмийн хэлэлцээрийн ачаар цуцлагдсан газрын тосны хориг сэргэх аюултай тулгарсан Ираны нийслэл Тегеран болон бусад хотод иргэдийн эсэргүүцэл дэгдээд байна. Нийгэм, эдийн засгийн гүн гүнзгий шинэчлэл өрнүүлж буй Саудын Араб эрс идэвхтэй гадаад бодлого баримтлах болсон нь ч газрын тосны үнэд нөлөөлөх эрсдэлтэй.



Хэрэгцээгүй зам байгуулж буй Бээжинг Канберра шүүмжлэв

Марк Уэмбриж

Номхон далайн бүс нутагт нөлөөгөө өргөжүүлэх Хятадын хүчин чармайлтыг Австрали ширүүн шүүмжиллээ. Хэрэг багатай дэд бүтцийн төслүүдэд мөнгө цутгах аргаар бүс нутгийн жижиг улсуудад тал засаж байна хэмээн тив улс Бээжинг буруутгав.

“Хэн ч арчилж тордохгүй энэ олон хэрэгцээгүй барилга байгууламжаар Номхон далайн бүс дүүрэх нь” хэмээн Австралийн Олон улсын хөгжил, Номхон далайн бүс хариуцсан сайд Кончетта Фьерраванти-Уэльс лхагва гарагт мэдэгдсэн юм. “Хаашаа ч үл хүрэх зам бидэнд хэрэггүй. Барьж буй дэд бүтэц ядаж эдийн засаг, эрүүл мэндийн үр өгөөжтэй байгаасай” хэмээн сайд тайлбарлав.

Бээжин ч хариуг нь шуурхай өглөө. БНХАУ-ын Гадаад хэргийн яам шүүмжийг “бодлогогүй, хүндэтгэлгүй” хэмээн тодорхойлоод хатагтай Кончетта Фьерраванти-Уэльсийг “өөртөө дүн шинжилгээ хийх”-ийг зөвлөв


“Номхон далайн арлын орнуудын засаг төр, ард түмнийг хүндэтгэн үздэг” БНХАУ-ын тусламжийн төслүүд нь “нутгийн иргэдэд бодит ашиг тустай”-г тус яам онцлон тэмдэглэсэн юм.

Дотоодын бодлогод гаднын оролцоо, тагнан турших занал учрахаас хамгаалах шинэ хуулийн төслийг Канберрагаас дэвшүүлсэнтэй уялдан сүүлийн хэдэн сард муудаад буй хоёр улсын харилцааг уг мэдэгдэл бүр ч хүндрүүллээ. Хятадууд парламентын гишүүдэд нөлөөлдөг гэсэн хардлагаас үүдэлтэй шинэ хуулийн төсөл гадаадаас улс төрийн зорилготой хандив авах, лоббич нар гадаадын байгууллагын ашиг тусын төлөө ажилладаг эсэхээ ил болгоход чиглэсэн заалттай.

Канберра дахь БНХАУ-ын Элчин сайдын яам дээрх хардлагыг эрс няцааж, эрх баригчдын шүүмжлэл нь “үзэл суртлын гажуудал, хүйтэн дайны үеийн сэтгэлгээ бүхий Хятадын эсрэг нийтлэг хийрхэл”-ийн илрэл хэмээн тайлбарласан юм. Австралийн эрх баригчдын байр суурь “хоёр улсын бие биедээ итгэх улс төрийн итгэл”-ийг ганхуулж байгааг Элчин сайдын яам сануулав.

Австралийн Либерал намаас парламентад сонгогдсон хатагтай Кончетта Фьерраванти-Уэльс Бээжинг Номхон далайн бага жижиг улсуудад таагүй нөхцөлөөр зээл олгодог хэмээн мөн шүүмжиллээ.

“Хөгжлийн тусламжаа үр



бүтээлтэй, өгөөжтэй байдлаар хэрэгжүүлэхийг бид Хятадад уриалж байна. Товч хэлбэл, юу ч хамаагүй нэг юм байгуулахын төлөө битгий ажиллаасай” хэмээн сайд анхааруулсан юм.

БНХАУ 2006-2016 оны хооронд Номхон далайн өмнөд хагасын орнуудад 1.8 тэрбум ам.долларын зээл, тусламж олгосныг судалгааны Lowy

Institute тооцоолжээ.

Манус арал дээрх орогнол хүсэгчдийн хуарангуудтай холбоотой маргаанаас болж Австралитай түнжин муудсан Папуа Шинэ Гвиней нь Хятадын нөлөөнд татагдаж буй бүс нутгийн улсуудын ердөө нэг нь. Тус улс Бээжингийн “Нэг бүс, нэг зам” санаачилгын хүрээнд БНХАУ-тай дэд бүтцийн хэд

хэдэн гэрээ байгуулаад байна.

“Эдгээр төсөл манай уулархаг бүсийн хөдөө аж ахуй, зам харилцаа, усан хангамжийг бэхжүүлж, иргэдийн амьдралыг сайжруулан, эдийн засгийг урагшлуулж өгнө” хэмээн Папуа Шинэ Гвинейн Ерөнхий сайд Питер О’Нил хэлэлцээрт гарын үсэг зурах үеэр тайлбарлав. “Хятад улс бол манай хөгжлийн



Эдийн засаг



С.Батсайхан / ЗГМӨ

Бизнесийн чагнуурын таатай чимээ

ХАЙГУУЛЫН САЛБАРЫН ТӨЛӨВ ТААГҮЙ БАЙНА



МИБГ үнэт цаасны хөрөнгө оруулалтын компанийн гүйцэтгэх захирал А.Билгүүн -Эрдсийн үнэ, тэр дундаа суурь металлуудын үнэ өсөлттэй байгаа тул “Оюутолгой”, “Эрдэнэт” гэх мэт зэс олборлогчдын хувьд макро орчин маш таатай байна. Мөн цайрын ханш сүүлийн жилүүдэд байгаагүй дээд түвшинд хүрсэн. Тиймээс манай улсын экспортын орлого нэмэгдэх болов уу. Гэхдээ энэ бүхэн олборлолт хийж байгаа компаниудад л хамаатай. Харин хайгуулын салбарт өрсөлдөөн их байна. Торонтогийн бирж дээрх хайгуулын компаниудын хувьцааны үнэ 2017 онд төдийлэн сайн өссөнгүй. Уг нь хайгуулын салбар өндөр эрсдэлтэй байдаг шигээ өгөөж арвинтай. Гэтэл сүүлийн жилүүдэд хайгуултай

адил өгөөж ихтэй салбаруудад чиглэсэн мөнгөний урсгал эрчээ авлаа. Хамгийн тод жишээ бол криптовалюта, блокчейн дээр тулгуурласан технологийн өөр төслүүд юм. Мөн Умард Америкт каннабисын хэрэглээг хуульчилсан учраас хайгуулын хөрөнгө оруулалт тулгарч байгаа бас нэг эрсдэл болж хувирлаа.

Нөгөөтэйгүүр, манайд хайгуул хийгддэг эрдсүүд нь нүүрс, төмрийн хүдэр, хар тугалга, цайр, зэс гэх мэт аж үйлдвэрийн түүхий эд байдаг. Гэтэл дэлхий дахинд лити, кобальт, цайр гэх мэт тэжээлийн минералууд руу чиглэсэн хөрөнгө оруулалт нэмэгдэж эхэлсэн. Тиймээс хайгуулын салбар мөнгө татахад харьцангуй хүнд болж ирж байна. Микро орчны хувьд татварын нэмэгдэл энгийн иргэдийн худалдан авах чадварт нөлөөлнө. Тэр утгаараа дотоодын эрэлт хэрэгцээ багасаж, экспортын орлого нэмэгдэх байх. Тиймээс эдийн засаг богино хугацаанд тэлэх ч урт хугацаанд сулрах магадлалтай гэж таамаглаж байна.

ДИЖИТАЛ МАРКЕТИНГ НЭВТРҮҮЛЭХГҮЙ БОЛ ӨРСӨЛДӨӨНД ЯЛАГДАНА



Mmarket цахим худалдааны талбарыг үүсгэн байгуулагч, захирал Ч.Энхчулуун -Онлайн худалдаа энэ онд нэлээд идэвхжих хандлага ажиглагдаж байна. Банкуудын qPay, TDB pay, Khan pay зэрэг төлбөрийн хэрэгслийн хүртээмж манай улсад нэлээд сайжирч байгаа. Биет болон биет бус бараа бүтээгдэхүүний цахим худалдааны үйлчилгээ төрөлжих болов уу. Өөр нэг гэгээтэй тал нь дотоодын программ хангамжийн компаниуд гаднын зах зээлд бүтээгдэхүүнээ экспортолж эхлэх байх. Бидний хувьд Зүүн өмнөд Азийн зах зээлд цахим худалдааны платформоо экспортолохоор төлөвлөсөн. Камбож, Мьянмар цаашлаад Лаосын зах зээлд өрсөлдөх боломж

бий. Санамж бичгүүд байгуулах гээд хамтын ажиллагааны албан ёсны эх үүсвэр тавигдаж байна. Бидний зорьж буй шинэ зах зээл хүн ам ихтэйгээс гадна дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт нь тогтвортой тул давуу талтай. Дотоодын зах зээлийн хувьд компаниуд ERP, интернет худалдаа, төлбөр тооцооны бүтээгдэхүүнүүдийг голлон ашиглах шаардлагатай боллоо. Цахим шилжилт сайн хийж чадахгүй бол өрсөлдөх чадваргүй болно гэсэн үг. Монголд интернет хэрэглээ өндөр түвшинд хөгжиж байгаа учраас уламжлалт маркетингтай компаниуд хоцрогдож байна. Харин цахим шилжилт сайн хийж буй компаниудын өрсөлдөх чадвар тэр хэрээрээ нэмэгдэнэ. Үүнийгээ дагаад борлуулалт нь ч сайжирна. Нөгөө талаар, үндсэн үйл ажиллагаандаа цахим бүтээгдэхүүн нэвтрүүлж чадаагүй компаниуд дижитал маркетинг хийж чадахгүй.

ДААТГАЛЫН САЛБАР 15-20 ХУВИАР ӨСӨХ БОЛОВ УУ



“Мандал даатгал” ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Жавхлан -Даатгалын салбарт өнгөрсөн гурван жилийн турш өсөлт гараагүй. Харин гадаад орчин таатай байгаа тул энэ жилээс сэргэх дүр зураг ажиглагдаж байна. Нүүрсний үнэ өсмөгц уул уурхайн компаниуд машин механизм, тоног төхөөрөмжөө даатгуулах нь ихсэж байна. Мөн уул уурхай, эрчим хүчний салбарын мега

төслүүд хөдөлж эхлэхтэй зэрэгцэн төслийн туслан гүйцэтгэгчид даатгалын үйлчилгээнд хамрагдаж эхэлсэн. Энэ зах зээлд борлуулж байгаа голлох бүтээгдэхүүн нь мэргэжлийн хариуцлагын, ажил олгогчийн хариуцлагын, байгууллагын хариуцлагын даатгалын үйлчилгээ болж байна. Тиймээс 2018 он даатгалын салбарын хувьд нэлээд тэлсэн жил байх болов уу. Манай шинжээчид даатгалын салбарыг дор хаяж 15-20 хувиар өсөх болов уу гэж таамагласан. Гэхдээ Монголбанкнаас олгодог зээлийн эх үүсвэрийн хэмжээ буурвал эдийн засгийн идэвх хумигдах магадлалтай.

З.Цэлмэг

@tselmegZGM

Бизнесийн орчинд өрнөж буй бүхнийг сонор соргоогоор хүлээн авч, үйл ажиллагаагаа төлөвлөдөг ажил хэрэгч эрхмүүд энэ оныг хэрхэн төсөөлж байгааг хүргэж байна. Улс төрийн амьдрал халуун, эдийн засгийн эрх чөлөөнд сөргөөр нөлөөлөх олон үйл явдал сүүлийн үед өрнөж буй ч Монголын бизнесийн орчны эрүүл мэндийн гол туслагч нь гадаад орчны эерэг төлөв байна гэдгийг баялаг бүтээгч, ажил олгогчид онцолж байна. Түүхий эдийн үнийн өсөлт, дэлхий даяар өрнөж буй технологийн дэвшлийн давалгаанд монголчууд нэгдсэнээр эдийн засгийн зуданд хамаг тамираа барсан салбаруудыг тэтгэж, компаниудын өрсөлдөх чадварт эерэгээр нөлөөлөх төлөвтэй байгаа аж.

● **Татварын нэмэгдэл гадаад зах зээлийг онилж байсан технологийн компаниудын өрсөлдөх чадварыг сулруулна.**

● **Түүхий эдийн үнийн эерэг төлөвөөс даатгалын компаниудын хожоо их.**

● **Хайгуулын салбарт хөрөнгө оруулалт булаацалдах салбаруудын үйл ажиллагаа идэвхжиж байна.**

● **Засгийн газрын бодлого тодорхой бус байгаа нь бизнесийн орчинд савлагаа үүсгэх эрсдэлтэй.**

ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТӨЛӨӨ БҮГД ЗҮТГЭМЭЭР БАЙНА

“Монос” группийн ТУЗ-ийн дарга Л.Хүрэлбаатар -Манай компанийн хувьд экспортод чиглэсэн бодлого барьж, Япон, БНСУ-д эрүүл мэндийн бүтээгдэхүүн гаргах зорилт тавиад ажиллаж байна. Мөн олон улсын стандартын шаардлага хангасан эмийн үйлдвэрийнхээ дараагийн шатны хөгжүүлэлтийг амжилттай хийж байна. Харин энэ бүх зорилтдоо хүрэхэд эдийн засгийн макро болон улс төрийн орчин аль болох тогтвортой байгаагаар л гэж хүсэж байна. Гэхдээ тогтвортой байх төлөв харагдаж байна уу



гэвэл бас үгүй. Олон зүйл тодорхой бус тул тогтвортой байна гэж харахад хүнд. Хамгийн гол нь тогтвортой байлгахын төлөө бүгд л дор бүрнээ зүтгэж, өөрөөсөө шалтгаалах бүхнээ хийе. Надаас эхлээд бизнес эрхлэгчид, эдийн засагчид, улстөрчид гээд бүгд л зүтгэх хэрэгтэй.

СҮҮНИЙ ХЭРЭГЛЭЭ НЭМЭГДЭХ ТӨЛӨВТЭЙ

“Сүү” хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Гантулга -Өнгөрсөн таван жил эдийн засгийн зуд нүүрлэсэн хүнд үе байлаа. Өргөн хэрэглээний бараа, сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээ улсын хэмжээнд нэлээд өсөлттэй байгаа. Сүү, сүүн бүтээгдэхүүний салбарынх бусдаасаа илүү өссөн. Харин татвар нэмэгдсэн нь энэ эерэг хандлагыг эргээд бууруулах байх, тодорхой хэмжээгээр. Гэхдээ том дүр зургаар нь харвал сүү, сүүн бүтээгдэхүүний салбарын өсөлтийг энэ онд өөдрөгөөр харж байгаа. Өнгөрсөн онд манай компани “Биофит” нэртэй хоёр шинэ бүтээгдэхүүн гаргасан нь зах зээлд маш амжилттай нэвтэрсэн. Гэтэл төрөл бүрийн согтууруулах ундаа, жүүс, хийжүүлсэн ундааны хэрэглээ жилээс жилд буурч байна шүү дээ.



Мөн бид 2017 онд “Сүү” бонд гаргаж, зах зээлээс зургаан тэрбум төгрөг амжилттай босгож чадсан. Үүнээс гадна нийт 1000 гаруй хувьцаа эзэмшигчдээ тараасан ногдол ашгийн хэмжээ 3.4 тэрбум төгрөгт хүрсэн. Олон улсын санхүүгийн корпорациас 2011 онд авсан зургаан сая ам.долларын нэгдэл ашгийн хэмжээ 3.4 тэрбум төгрөгт хүрчээ. Ингэснээр тайлант үеийн нийт цэвэр ашиг 227 хувиар өсөж, 1.4 тэрбум болсон нь хөрөнгийн зах зээлд тоглогчид нэмэгдсэнийг харуулж байна. тавьсан.

ДОТООДЫН БОЛОВСОН ХҮЧНИЙ УРСТАЛ ГАДАГШЛАХ ЭРСДЭЛТЭЙ БОЛЛОО

“Бизнес 2.0 Академи”-ийн үүсгэн байгуулагч Д.Энхбат -2018 онд бизнесийн орчин тодорхойгүй байна. Татвар нэмэгдчихлээ. Компаниуд цалингаа нэмэх боломжгүй болж байгаа нь манай технологийн салбарт хүнд тусаж байна. Мэдээллийн технологийн мэргэжилтнүүд харьцангуй өндөр цалинтай хүмүүс. Харамсалтай нь Засгийн газрын шийдвэр дотоодын боловсон хүчний гадагшаа чиглэсэн урсгал эрчээ авах эрсдэл үүсгэлээ. Дотоодын технологийн компаниуд цалингаа нэмэх боломжгүй болж, ажилчдыг нь нэг бол гадаадын компаниуд мөнгө цохиж авна, эс бөгөөс гадаадын



хөдөлмөрийн зах зээл рүү өөрсдөө явна. Ингэснээр боловсон хүчиндээ тулгуурлан амжилттай явж байсан технологийн компаниудын өрсөлдөх чадвар асар их муудна. Нөгөөтэйгүүр, өргөн дүр зургаараа бол бизнесийн орчин түр зуурын улс төрийн эрх ашгийг дагаж савлаад байна. Эдийн засгийн урт хугацааны хараа, төлөвлөлт гэдэг бизнесийнхэнд тулах гол баганын нэг.

БИЗНЕСИЙН ШИНЭ БОЛОМЖУУД НЭЭГДЭНЭ

ITZone компанийн ТУЗ-ийн дарга Н.Баттулга -Дэлхий даяар идэвхтэй өрнөж байгаа цахим шилжилтийн давалгаа Монголыг ч бүрхээд байна. Тийм ч учраас мэдээллийн технологийн хэрэглээ өсөх хандлагатай байгаа. Тэрчлэн мэдээлэл боловсруулалт, мэдээллийн автоматжуулалт, аюулгүй байдлын чиглэлээр түлхүү хөгжих дүр зураг ажиглагдаж байгааг хэлбэ. Үүнийг дагаад мэдээллийн технологийн компаниудад бизнесийн шинэ



боломжууд өргөн нээгдэж буй. Ялангуяа, цахим шилжилттэй холбоотойгоор программ хангамжийн салбарт бизнесийн өсөлт ажиглагдах хандлагатай. Харин Засгийн газар үйлчилгээндээ мэдээллийн технологийг өнгөрсөн хугацаанд боломжийн хэмжээнд нэвтрүүлсэн. [ЗГҮ]

ЗГМ ТОВЧХОН

» ЭКСПОРТ

“Ганцмод”-ны боомт орчимд авто зам хааснаас мягмар гарагаас эхлэн нүүрсний тээвэр удаашраад байна. Мягмар гарагт 300 орчим машин нүүрс экспортолсон бол лхагва гарагт 110, пүрэв гарагт 10 гаруй болж буурсныг “Гашуунсухайт” боомтын захиргаа мэдээлжээ.

» УУЛ УУРХАЙ

Rio Tinto компани литийн олборлолтоор дэлхийд тэргүүлэгчдийн нэг Чилийн SQM компанийг худалдан авах саналаа цуцалсан гэдгийг ойрын эх сурвалж мэдээллээ.

» ИМПОРТ

20

Хувь. Татварын нэмэгдлийн улмаас суудлын автомашины импорт 2017 оны гуравдугаар улирлаас хойш 20 гаруй хувиар буураад байгааг YCX-ноос мэдээллээ. Харин хуучин автомашины үнэ 2-5 сая төгрөгөөр нэмэгдэж, инфляц өсгөх нөхцөл болж байгаа аж. Өнгөрсөн оноос цахилгаан хөдөлгүүрт, хос тэжээлт, шингэрүүлсэн хийгээр ажилладаг автомашинуудын борлуулалтын орлогоос авах татвар насжилт, хөдөлгүүрийн багтаамжаас шалтгаалж 1-6 сая төгрөг болсон юм.

» ҮНЭТ ЦААС

52

Андеррайтер, брокер дилерийн чиглэлийн 52 мэргэжлийн оролцогч СЗХ-нд бүртгэлтэй байна. Компаниудын онцолж байгаагаар иргэд дотоодын үнэт цааснаас гадна гадаадын компаниудын хувьцааг худалдан авах нь нэмэгдэж байна. Тэр дундаа Facebook, Alibaba, Tencent компаниудын хувьцааг хамгийн их сонгож байгаа аж.

5.5

Тэрбум төгрөг. 2017 оны гуравдугаар улирлын байдлаар үнэт цаасны компаниудын үйл ажиллагааны орлого хоёр тэрбум төгрөгөөр буюу 57 хувиар өсөж, 5.5 тэрбум төгрөгт хүрчээ. Ингэснээр тайлант үеийн нийт цэвэр ашиг 227 хувиар өсөж, 1.4 тэрбум болсон нь хөрөнгийн зах зээлд тоглогчид нэмэгдсэнийг харуулж байна.

» МАКРО ЭДИЙН ЗАСАГ

3.1

Хувь. Монгол Улсын эдийн засаг энэ онд 3.1 хувиар өснө гэсэн төлөв Дэлхийн банкаас гаргасан байна.

» ХӨРШ

28

Хувь. АНУ-ын Оюуны өмчийн газраас авсан зохиогчийн эрхийн тоогоороо БНХАУ анх удаа айргийн тавд багтлаа. Сүүлийн 10 жилийн хугацаанд АНУ-аас авсан патентын тоо нь 10 дахин өссөнөөр ийнхүү жагсаалтад байр ахин тэргүүлэгчдийн тоонд багтжээ.

ВАЛЮТЫН ХАНШ

АНУ доллар	2,430.35
Евро	2,930.52
Япон иен	21.48
ОХУ рубль	42.60
БНХАУ юань	374.81
БНСУ вон	2.29

Эдийн засаг

ГАДААД ХУДАЛДАА

Экспортыг адууны мах чирлээ

Махны экспортоос 140 орчим тэрбум төгрөгийн орлого олжээ

Г.Байгал
@baigalZGM

Манай улсын хил хязгаар, хот суурин газруудад малын гоц халдварт өвч тархаж, хорио цээрийн дэглэм тогтоон, аюулын дохио асаасан өнгөрсөн онд махны экспортын дүн цойлжээ. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны мэдээлснээр 2017 оны арванхоёрдугаар сарын 25-ны байдлаар Монгол Улс 27.8 мянган тонн мах экспортолсон байна. Энэ нь сүүлийн таван жилийн дунджийг долоо нугалсан өсөлт төдийгүй өнгөрсөн оныхоос гурав дахин өндөр үзүүлэлт. Ийнхүү сүүлийн хэдэн жил мал аж ахуйн салбарт харагдаагүй өсөлт өнгөрсөн онд ажиглагдаж, махны экспортоос 140 орчим тэрбум төгрөгийн орлого олжээ.

Экспортын өсөлтийг адууны мах голлон бүрдүүллээ. Тодруулбал, нийт экспортын 90 орчим хувийг адууны мах дангаар эзэлсэн болохыг Гаалийн ерөнхий газраас мэдээлэв. Харин бусад буюу ямаа, хонь, үхрийн махны экспорт нийлээд гурван мянган тоннд хүрсэн байна.

Өнгөрсөн онд манай улсын 10 сум, нийслэлийн хоёр дүүрэгт шүлхийн өвчлөл бүртгэгдэж, хорио цээрийн дэглэм тогтоосон. Малын гоц халдварт шүлхий өвчний улмаас зарим бүс нутгийн махны экспортод хязгаарлалт тогтоосон юм. Ялангуяа, адуунаас бусад малын махны экспортыг эрхийг эргэн харахаа худалдан авагч орнууд илэр-



С.Батсайхан / ЗГМ©

хийлсэн. Харин малын зарим өвчнөөс ангид байх боломжтой битүү туурайтан болох адууны махны нийлүүлэлт нэмэгдэж, экспортын үзүүлэлтийг өөд татжээ. Өнгөрсөн сарын эцсийн байдлаар гэхэд Монгол

Улс БНХАУ, ОХУ, Казахстан, Япон улсад адууны 24900 тонн мах нийлүүлсэн байна. Мөн дулааны аргаар боловсруулсан нөөшилсөн мах махан бүтээгдэхүүний экспорт 2000 тоннд хүрчээ.

Сүүлийн жилүүдэд тогтмол уруудсан махны экспорт өнгөрсөн онд ийнхүү өслөө. Энэ өсөлтөө 2018 онд хадгалах уу. Тоо толгой нь 66 саяыг даваад буй малынхаа махыг экспортолж, мөнгө болгох нь


монголчуудын хэзээний хүсэл байсан. Тэгээд бүр алт, зэс зэрэг уул уурхайн түүхий эдээс бус, хөдөө аж ахуйн түүхий эдээ худалдаж, экспортын орлогоо солонгоруулах нь Монгол Улсын макро эдийн засгийн гол зорилт.

Тэгвэл энэ оны төлөв ямар байгааг харцгаая. Засгийн газрын дэргэдэх Хүнсний аюулгүй байдлыг үндэсний зөвлөлөөс махны экспортын нөөцийг тооцсон байна. Энэ онд Монгол Улс үхрийн 27.9, адууны 43.6 мянган тонн мах экспортолх боломжтой гэсэн тооцоо гарчээ. Харин хонь, ямааны махны экспортын тоо, хэмжээнд хязгаар тогтоохгүйгээр экспортолыг зөвшөөрсөн байна. Одоогийн нөөцөө тооцоод үзвэл 2018 онд хонины 61.4, ямааны 47 мянган тонн мах хилийн чанадад худалдах боломжтой.

Өдгөө БНХАУ-д адууны мах экспортлох эрхтэй найман аж ахуйн нэгж байгаа. Харин хонь, ямаа, үхрийн мах экспортлох эрхтэй зургаан аж ахуйн нэгж бий аж. Түүнчлэн ОХУ-д мах махан бүтээгдэхүүн экспортлох эрх бүхий магадлан итгэмжлэгдсэн 29 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж буйг салбарын яамнаас мэдээллээ.

Шүлхийн улмаас зарим бүс нутгийн махны экспорт зогссон. Гэхдээ өнгөрсөн есдүгээр сард манай махны үйлдвэрүүдэд БНХАУ-ын талаас мал эмнэлгийн хянан магадлагаа хийсэн. Тус хяналтад нийслэл болон орон нутгийн 36 үйлдвэр хамрагджээ. Тэгвэл хянан магадлагааны хариут Хятадаас талаас хэд хоногийн өмнө ирүүлсэн байна. Үүнд манай улсын 13 аж ахуйн нэгж зарим зөрчлөө арилгавал махны экспорт хийх зөвшөөрөл олгох боломжтой гэсэн хариу иржээ. Энэ хэрээр мах экспортлогчдын тоо нэмэгдэхээр байна. Өөрөөр хэлбэл, энэ онд ч махны экспорт одоогийн өсөлтөө хадгалах боломжтой.

Монгол Улс адуунаас илүү хонь, ямааны махны экспортоо илүү нэмэх нөөц хийгээд сонирхолтой. Гэхдээ Монголын тал нутгаар тэнүүчилж буй шүлхийн аюул бусад малын махны экспортод эрсдэл дагуулсаар байна. [ЗГМ]



АПУ-гийн хувьцааны эрэлт их байна



Монголын хөрөнгийн биржийн нэгдүгээр ангилалд бүртгэлтэй АПУ компанийн нэгж хувьцааны ханш 0.2 хувиар буурч, 684.28 нэгжилд хүрэв. Гэхдээ тус компанийн хувьцааны ханш 2018 он гарснаас хойш Монголын хөрөнгийн биржийн хамгийн эрэлттэй үнэт цаасны тоонд багтаж байгаа. Өчигдөр буюу пүрэв гарагт Монголын хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулагчид 213 удаагийн

хэлцэл хийснээс АПУ компанийн хувьцаанд 54 удаагийн хэлцэл хийжээ. Тус компанийн хувьцааны ханш өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад ойролцоогоор хоёр дахин өссөн байна. Marketinfo.mn цахим хуудсанд мэдээлснээр энэ он гарснаас хойш АПУ компанийн хувьцаа хамгийн их хөрөнгө оруулалт татсан, зах зээлийн трэнд үнэт цаасны тэргүүнд бичигдэж байгаа аж. [ЗГМ]

[ЗГМ СОНИН]

ТАНАЙ КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ ЭНД БАЙРЛАЖ БОЛНО

99903584, 99903581

МОНГОЛД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛДАГ ГАДААД КОМПАНИУД						
НЭР	СИМБОЛ	БИРЖ	ВАЛЮТ	ХАНШ	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
RIO TINTO	RIO	ASX	AUD	79.075	▼ -0.23%	1/11/2018
WOLF PETROLEUM	WOF	ASX	AUD	0.02	▼ -10%	1/11/2018
PETRO MATAD	MATD	LON	GBX	10.05	▲ 3.08%	1/11/2018
ASPIRE MINING	AKM	ASX	AUD	0.011	▼ -8.33%	1/10/2018
GUILDFORD COAL	GUF	ASX	AUD	0.013	▼ -7.69%	1/10/2018
PROPHECY DEVELOPMENT	PCY	TSX	CAD	4	▼ -2.75%	1/11/2018
TURQUOISE HILL RESOURCES	TRQ	TSX	CAD	4.31	▲ 1.89%	1/11/2018
SOUTHGObI RESOURCES	SGQ	TSX	CAD	0.205	▲ 13.89%	1/10/2018
XANADU MINES	XAM	ASX	AUD	0.77	▼ -1.30%	1/11/2018
ENTREE GOLD	ETG	TSX	CAD	0.275	▼ -1.82%	1/11/2018

ТҮҮХИЙ ЭД					
НЭР	СИМБОЛ	НЭГЖ	ХАНШ (\$)	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
АЛТНЫ СПОТ	XAU	унци	1318.34	▲ 0.11%	1/11/2018
ЦАГААН АЛТ	PLA	унци	977.6	▼ -0.12%	1/11/2018
МӨНГӨ	SIA	унци	17.025	▼ -0.06%	1/11/2018
ЗЭС (COMEX)	HGA	фунт	324.2	▲ 0.20%	1/11/2018
ТӨМРИЙН ХҮДЭР	TIOA	тонн	77.4	▼ -0.28%	1/11/2018
WTI ТОС	CLA	баррель	63.47	▼ -0.16%	1/11/2018
БРЕНТ	COA	баррель	69.2	▲ 0.55%	1/11/2018
БЕНЗИН	XBA		183.34	▲ 0.04%	1/11/2018
БАЙГАЛИЙН ХИЙ	NGA	Mmbtu	2.913	▲ 0.24%	1/11/2018
НҮҮРС (NYMEX)	QZA	тонн	336.55	▲ 0.21%	1/10/2018
НҮҮРС (NEW CASTLE)	XWA	тонн	104.7	▲ 0.33%	1/11/2018
ЭЛСЭН ЧИХЭР	SBA	фунт	0.146	▼ -0.81%	1/11/2018
БУДАА	RRA	центнер	11.905	▼ -0.33%	1/11/2018
БУУДАЙ	WA	бушель	434.25	▲ 0.46%	1/11/2018
КАКАО	CCA	тонн	1941	▲ 2.32%	1/11/2018
КОФЕ	KCA	фунт	123.95	▼ -0.96%	1/11/2018

Энэхүү ханшийн мэдээлэл нь хүснэгтэд заасан өдрийн 15 цагийн байдлаарх дүн тул үүнээс хойш өөрчлөгдсөн байх боломжтой.



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ				
НЭР	СИМБОЛ	ХАНШ (нэгж)	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
АПУ ХК	APU	684.28	▼ -0.29%	1/10/2018
ГОВЬ ХК	GOV	24100	▼ -0.50%	1/10/2018
МОНГОЛ ШУУДАН ХК	MNP	644.34	▲ 5.65%	1/10/2018
ДАРХАН НЭХИЙ ХК	NEH	20980	▼ -4.64%	1/10/2018
СҮҮ ХК	SUU	254.25	▼ -0.56%	1/10/2018
ТАВАНТОЛГОЙ ХК	TTL	9615	▲ 3.50%	1/10/2018
АДУУН ЧУЛУУН ХК	ADL	3100	▲ 0.03%	1/10/2018
МОГОЙН ГОЛ ХК	BDL	9810	▼ -8.23%	1/10/2018
ХАСУ-МАНДАЛ ХК	HSR	3600	▼ -10%	1/10/2018
АЙТҮҮЛС ХК	ITLS	157.73	▼ -2.42%	1/10/2018
ЖЕНКО ТҮР БЮРА ХК	JTB	62	▼ -1.01%	1/10/2018
МАТЕРИАЛ ИМПЕКС ХК	MIE	9500	▲ 2.15%	1/10/2018
ШИВЭЭ ГОВЬ ХК	SHG	2297	▲ 4.93%	1/10/2018
ШИВЭЭ ОВОО ХК	SHV	2265	▲ 7.09%	1/10/2018
АВТО ИМПЕКС ХК	AOI	2249	▲ 14.98%	1/10/2018
БӨӨНИЙ ХУДАЛДАА ХК	BHL	400	▼ -14.71%	1/10/2018

Тухайн өдөр арилжаалагдсан хувьцаа

ДЭЛХИЙН ГОЛЛОХ ИНДЕКСҮҮД					
НЭР	СИМБОЛ	ХАНШ (нэгж)	ӨӨРЧЛӨЛТ ӨӨРЧЛӨЛТ %		ОГНОО
NASDAQ COMPOSITE	CCMP	7153.57	-10.01	▼ -0.14%	1/11/2018
DAX INDEX	DAX	13281.34	-104.25	▼ -0.78%	1/11/2018
TORONTO STOCK EXCHANGE	SPTSX	16247.95	-71.29	▼ -0.44%	1/11/2018
S&P/ASX 200	AS51	6064.199	-32.48	▼ -0.53%	1/11/2018
S&P 500	INX	2748.23	-3.06	▼ -0.11%	1/11/2018
SHANGHAI COMPOSITE	SHCOMP	3421.834	+7.94	▲ +0.23%	1/10/2018
DOW JONES INDUSTRIAL AVERAGE	INDU	25369.13	-16.67	▼ -0.07%	1/11/2018
TOP 20	MSETOP	20645.73	-94.19	▼ -0.45%	1/10/2018
FTSE 100	UKX	7748.51	+17.49	▲ +0.23%	1/11/2018
HANG SENG	HSI	31073.72	+62.31	▲ +0.2%	1/10/2018
NIKKEI 225	NKY	23635.08	-153.12	▼ -0.64%	1/11/2018

Мөнгөний урсгал

Төгрөгийн ирээдүй салаа замын уулзварт



С.Батсайхан / ЗГМ ©

Эдийн засагт ирэх дарамт багасав

Б.Баярмаа
@bayamaaZGM

Сүүлийн 16 жилийн өгөгдлөөс харахад төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн ханш нийт хугацааны 75 хувьд нь суларсан

байдаг. Ялангуяа сүүлийн хоёр жилийн турш төгрөгийн ханш огцом суларч, ханшийн эрсдэл улам нэмэгдсэн. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн хэлбэлзэл өндөр байгаа нь эдийн засгийн бүтцийн хувьд төрөлжөөгүй, уул уурхайгаас хэт хамааралтай байдлын бодит илрэл гэж зарим судалгаанд дурдсан нь бий. Тухайлбал, “Валютын ханшийг тодорхойлогч хүчин зүйлсийн суурь судалгаа”-нд эдийн засгийн өрнөлийн үед хангалттай нөөц,

хуримтлал бий болгож чадаагүйн үр дагавар хэмээн дүгнэсэн удаатай. Хангалттай нөөц, хуримтлал нь гадаад валютын улсын албан нөөц, түүнтэй тэнцэх хэмжээний хатуу валют болох алтыг хэлж байгаа юм. Эдийн засагчид төгрөгийн ханшийн төлөв байдлыг хэрхэн төсөөлж байгааг уншигч танд хүргэж байна. Уналтаас дөнгөж гараад амсхийж буй төгрөгийн ханш цаашид тогтворжих уу эсвэл огцом чангарах уу гэсэн асуулт хариулт нэхэх аж. [ЗГМ]

ТӨГРӨГ ЭМЗЭГ ХЭВЭЭР БАЙНА


Б.Алтанцэцэг (*МУИС-ийн Бизнесийн сургуулийн багш*)
-Төгрөгийн ханшийн төлөв байдлыг шууд тодорхойлж хэлэхэд хүнд байна. Ханш өөрөө Олон хүчин зүйлээс шалтгаалж байдаг. Одоогийнх шиг энэ хэвээрээ нөхцөл байдал өөрчлөгдөхгүй бол төгрөгийн ханш тогтворжих магадлалтай.



Хэрэв улс төрийн тогтворгүй байдал үүсвэл төлөв эргээд муудах талтай. Тулсан өрийн дарамт холдсон хэдий ч гадаад өрийн хэмжээ өндөр байсаар

байна. Үүнээс гадна татварын нэмэгдэл ч нөлөө үзүүлэх хүчин зүйлийн нэг. Төгрөгийн ханш эмзэг хэвээр байна. Өндөр инфляцын эрсдэл байгааг үгүйсгэхгүй. Төсвийн алдагдал цаашид улам багасч, Монголбанк хэрхэн тууштай бодлого хэрэгжүүлэхээс төгрөгийн хувь заяа шалтгаална.

ЗГМ: ИНФОГРАФИК



Төлбөрийн тэнцлийн ашиг 846 сая ам.долларт хүрэв

Г.Илч
ЗГМ

Монгол Улсын төлбөрийн тэнцлийн ашиг өнгөрсөн оны арваннэгдүгээр сарын байдлаар 846 сая ам.долларт хүрснийг төв банк мэдээллээ. Манай улсын бусад оронтой хийсэн эдийн засгийн харилцааг илтгэдэг энэ үзүүлэлт одоогоор гурван улирал дараалан ашигтай гараад байгаа юм. Мөн ашгийн хэмжээ нь тогтмол өсөж байгаа. Тухайлбал, 2017 оны хоёрдугаар улиралд 90 сая ам.доллартай тэнцэж байсан төлбөрийн тэнцлийн ашиг өнгөрсөн арваннэгдүгээр сард бараг 10 дахин өссөн

байна. Төлбөрийн тэнцлийн нэг тулгуур болох санхүүгийн дансын тэнцлийн ашиг өссөн нь гол нөлөө үзүүлжээ. Монгол Улсын экспортын гол бүтээгдэхүүний үнэ олон улсын зах зээлд ёроолын цэгээсээ өндийж, өсөж эхэлсэн. Энэ нь Монголыг чиглэх орлогын урсгалыг дэмжсэн юм. Өнгөрсөн онд экспортын хэмжээ анх удаа зургаан тэрбум ам.доллар давж, гадаад худалдаанаас 1.9 тэрбум ам.долларын ашиг олсон. Мөн гадаадын шууд хөрөнгө оруулалт 1.2 тэрбум ам.доллар, алтны худалдан авалт 20 тоннд хүрсэн. Тэрчлэн ОУВС-тай хамтран ашиг өнгөрсөн арваннэгдүгээр сард бараг 10 дахин өссөн

ийн хүрээнд хандивлагч орон, олон улсын байгууллагуудаас санхүүжилт орж эхэлсэн нь Монголыг чиглэх мөнгөний урсгалыг дэмжсэн байна. Өөрөөр хэлбэл, мөнгөний орох урсгал эрчимжлээ. Нөгөө талд, Монгол Улсын Засгийн газар, төв банк төлбөрийн гадагшлах урсгалыг бууруулж, нэмэлт санхүүжилт татах зорилгоор өнгөрсөн онд олон улсын зах зээлд нийт 1.4 тэрбум ам.долларын хоёр бонд гаргасан. Тодруулбал, өнгөрсөн оны гуравдугаар сард 600 сая ам.долларын “Хуралдай”, арваннэгдүгээр сард 800 сая ам.долларын “Гэрэгэ” бондыг тус тус арилжсан. Олон улсаас босгосон уг санхүүжилтээр

Хөгжлийн банкны таван жилийн хугацаатай, 580 сая ам.долларын Евро бонд болон хугацаа адил, 500 сая ам.долларын “Чингис” бондын төлбөрийг барагдуулсан. Ингэснээр тэрбум гаруй ам.долларын таван жилийн хугацаатай “Чингис” бондын 500 сая ам.долларын өр

онд 377 сая ам.долларын ашигтай байна гэж Монголбанк урьдчилан тооцоолжээ. Төгрөгийн ханшид гол нөлөө үзүүлдэг төлбөрийн тэнцэлд эерэг хүлээлт давамгайлж байна. Тиймээс энэ онд төгрөгийн ханшид огцом хэлбэлзэл үүсгэх хүчин зүйл харьцангуй бага гэж Монголбанкнаас тооцож байна. Макро эдийн засгийн нэг тулгуур болох төлбөрийн тэнцэл ашгийн зүг заалаа. Зэрэгцээд Монгол Улсын төсвийн нөхцөл байдал сайжирч, алдагдал нь өмнөх жилүүдийнхээс үлэмж хэмжээгээр буурч буйг сануулья. Эдийн засгийн хос хөдөлгүүрт ийнхүү эерэг шинж ажиглагдаад эхэллээ. [ЗГМ]

ЭШЛЭЛ



-Одоо хийгдэж байгаа хуулийн шинэчлэлүүд нь банк санхүүгийн салбарын “Хөгжлийн шинэ үе”-ийг эхлүүлнэ гэж үзэж байгаа. Үр дүнд нь эдийн засгийн нэг гол тулгуур бодлого болох мөнгөний бодлогыг хэрэгжүүлэгч институци буюу төв банкны үйл ажиллагаа илүү сайжирна. Мөн мөнгөний бодлого хэрэгжих, дамжих гол суваг буюу банк, санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааг оновчтой зохицуулах орчин бүрдэх юм. Ингэснээр санхүүгийн систем бүхэлдээ найдвартай ажиллах суурь болно. Мэдээж энэхүү шинэчлэлийг төв банк өөрөөсөө эхлэн хийж байна. Төв банкны тухай хуулийн өөрчлөлтөөр Монголбанкны ерөнхийлөгчид хэт их эрх мэдэл төвлөрөхөөс сэргийлсэн хамтын удирдлагын зарчим, Монголбанк мэргэжлийн бус хөндлөнгийн нөлөөллөөс ангид, хараат бус ажиллах тогтолцоо зэргийг давхар хийж өгч байгаа. Энэ бүхэн нь төв банк үнийг тогтвортой байлгах зорилгодоо хүрэх боломжийг нэмэгдүүлж, амжилттай ажиллах нөхцөлийг нь бүрдүүлж өгч байна гэсэн үг юм. Төв банкинд итгэх итгэлийг нэмэгдүүлэхийн төлөө ажиллана. Ингэснээр инфляцын хүлээлтийг оновчтой удирдах, бодлогын үр нөлөөг дээшлүүлэх боломжтой болох юм.

(Монголбанкны ерөнхийлөгч)
Н.Баяртсайхан

ЗГМ ТОВЧХОН

» ТҮҮХИЙ ЭД

1400

Ам.доллар. "Bank of China"-ийн тооцооллоор энэ онд алтны ханш үргэлжлэн өсөж, унц нь 1400 ам.доллар хүрэх төлөвтэй байна. Дэлхийн эдийн засгийн өсөлт нэмэгдэхтэй зэрэгцэн ам.долларын ханш суларч, бондын ханш унаж байгаа нь таварын үнэлгээ өсөх нэн тохиромжтой нөхцөл гэж дүгнэжээ.

» БАНК, САНХҮҮ

17

Сар. Банкны салбарын зээлийн өсөлт сүүлийн 17 сар дараалан эерэг гарав. Тус салбарт нийт 14 банк 1770 салбар нэгжтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

» ДЭЛХИЙН БАНК

4.5

Хувь. Уул уурхайн түүхий эд экспортлогч орнуудын нийлүүлэлт үргэлжлэн сэргээхтэй холбоотойгоор хөгжиж буй эдийн засагтай улсуудын ДНБ 2018 онд 4.5 хувиар тэлнэ гэдгийг Дэлхийн банк ээлжит тайландаа дурджээ. Тодруулбал, хөгжиж буй эдийн засагтай улсуудын өсөлт эрчимжинэ гэж тус байгууллага үзэж байна. Харин Евро бүсийн эдийн засгийн өсөлт удааширч, 2.1 хувьд хүрэх аж.

» УУЛ УУРХАЙ

62.9

Хувь. Алтны мөнгөжүүлэлтээс орсон орлого 625.5 сая ам.доллар байгаа нь ойролцоогоор гадаад валютын албан нөөцийн өсөлтийн 62.9 хувийг бүрдүүлж байна.

» ХӨРШ

6.4

Хувь. Бүтцийн шинэчлэлээ үргэлжлүүлж буй БНХАУ-ын эдийн засаг энэ онд 6.4 хувиар тэлэх төлөвтэй байна.

Мөнгөний урсгал

БАЙР СУУРЬ

Б.Баярдаваа: Зах зээлд оролцогчдын итгэл сэргэж байна

2018 оны мөнгөний бодлого эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чиглэнэ

Б.Баяртогтох @bayartogtokhZGM

Монголбанкны Мөнгөний бодлогын газрын захирал Б.Баярдаваатай ярилцлаа. Тэрбээр “Эдийн засгийн гадаад талд, төлбөрийн тэнцэлд эерэг өөрчлөлт гарахын зэрэгцээ дотоод зах зээлд оролцогчдын итгэл сэргэж байна” хэмээн тодотгов.

-Монголбанкны хувьд 2017 он ямар жил болж өнгөрсөн бэ. Төлөвлөж байсан бодлогын арга хэрэгсэл бүрэн дүүрэн хэрэгжиж чадсан уу?

-Гадаад өрийн эргэн төлөлтийг дотоод зах зээлд дарамтгүйгээр шийдвэрлэж чадлаа. Гадаад валютын нөөц хүрэлцээгүй байсан тул гадаад өрийн төлбөрийн хугацааг нь сунгахаас өөр бодлогын сонголт бидэнд байгаагүй. Монгол Улс 2016 оны сүүлийн хагаст гадаад зах зээлд бонд гаргах эхний оролдлогууд амжилтгүй болсон хэдий ч Хөгжлийн банк, Чингис бонд, Дим сам бондын дахин санхүүжилтийн асуудлыг 2017 онд шийдвэрлэсэн. Монгол-банкны зүгээс Хятадын ардын банкнаас своп хэлцлээр авсан зээлийн хугацааг сунгах ажил хэд хэдэн хэлэлцээр дамнан байж 2020 он хүртэл сунгасан. Ингэснээр 12 тэрбум юань буюу тухайн үеийн ханшаар 1.7 тэрбум ам.долларын эргэн төлөлтийг хойшлуулж, төлбөрийн тэнцлийн богино хугацааны хамгийн том төлбөрийг шийдвэрлэсэн нь эдийн засаг тогтворжиход маш чухал хувь нэмэр боллоо.

-Цаг хугацааны хувьд тулсан өрийн дарамт холдсон. ОУВС-гийн хөтөлбөр хэрэгжсэн нь дээрх нөхцөл байдлыг зөөл-лөсөн үү?

-ОУВС-гийн хөтөлбөрт хам-рагдаагүй тохиолдолд бусад олон улсын санхүүгийн бай-гууллага, донор орнуудтай хамтарсан хөтөлбөрүүд хэрэг-жихгүй. Монгол Улс болон ОУВС таван тэрбум гаруй ам.долларын санхүүжилттэй “Өргөтгөсөн санхүүжилтийн



С.Батсайхан / ЗГМӨ

хөтөлбөр” хамтран хэрэгжүүлэх тохиролцоонд хүрснээр ойрын гурван жилд шаардлагатай бай-сан санхүүжилтийн хомсдолоо шийдвэрлэсэн. Мөн Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк тэргүүтэй олон улсын санхүү-гийн байгууллага, Япон, БНСУ зэрэг хандивлагч улстай хамтарсан хөтөлбөрүүд хэрэг-жүүлэхээр болсон. Эдгээр хөтөлбөр нь өрийн эргэн төлөлтийн хугацааг сунгах, шинээр бонд босгох, төсөв, мөнгөний бодлогын хараат бус байдлыг сайжруулах, санхүүгийн зах зээлийн эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэхэд том хувь нэмэр болж байна. Эдийн засгийн гадаад талд, төлбөрийн тэнцэлд эерэг өөрчлөлт гарахын зэрэгцээ дотоод зах зээлд оролцогчдын итгэл сэргэж байна.

-Бизнесийн орчинд эерэг хүлээлт давамгайлж байна гэж үзэж болох уу. Эдийн засгийн төлөв байдал ямар байна вэ?

-Бизнес эрхлэгч, гадаад до-тоодын хөрөнгө оруулагчид, хэрэглэгчдийн итгэл сэргэж, хэлцлийн хугацааг уртасгахад эерэгээр нөлөөлж байна. Энэ нь зээлийн өсөлтийн сэргэлт, ажил эрхлэлтийн

өсөлт, хэрэглэгчийн болон менежерүүдийн итгэл сэргэж байгааг илтгэсэн статистик мэдээллүүдээс харагдаж байна. NRCC судалгааны байгууллагын хэрэглэгчийн итгэлийн ин-дексийн тайлангаас харахад 2016 оны хоёрдугаар улирлаас хойш тасралтгүй буурч байсан хэрэглэгчийн итгэлийн индекс 2017 оны гуравдугаар улиралд анх удаа сайжирсан. Үүнд ажлын олдоц болон орлого сайжирна гэсэн итгэл сэргэсэн нь нөлөөлсөн гэж дүгнэсэн. Мөн экспортын бүтээгдэхүүний үнэ харьцангуй өндөр түвшинд тогт-вортой байна.

-Мөнгөний бодлогын 2018 оны гол зорилго юу вэ?

-Монголбанк 2017 оны мөнгөний бодлогын зорилтыг эдийн засгийг тогтворжуулах гэж тодорхойлж байсан. Харин энэ оны мөнгөний бодлого нь эдийн засаг, санхүүгийн ча-давхыг бэхжүүлэх, эдийн засагт эрсдэл хуримтлуулж, инфляцын дарамт үүсгэхгүйгээр өсөлтийг дэмжихэд чиглэх болно. 2018 он бол эдийн засгийн реформыг тууштай хийх жил болох учиртай. Эдийн засгийн эмзэг байдлыг сууриар нь богино хугацаанд арилгаж чадахгүй

NRCC судалгааны байгууллагын хэрэглэгчийн итгэлийн индексийн тайлангаас харахад 2016 оны хоёрдугаар улирлаас хойш тасралтгүй буурч байсан хэрэглэгчийн итгэлийн индекс 2017 оны гуравдугаар улиралд анх удаа сайжирсан.

өсөлт дунд, урт хугацаанд тогтвортой хадгалагдах нь бүр илүү чухал юм. Эдийн засгийг идэвхжүүлэхэд хэт яарсан бодлого нь богино хугацаандаа эерэг нөлөө үзүүлж, олон нийтэд таалагдах хэдий ч энэ нь гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад эргэлзээ төрүүлж эргээд өсөлт саарах, нөхцөлийг бүрдүүлдэг. Иймд богино хугацааг харсан бодлого биш харин тогтвортой байдлыг зорьсон бодлого бидэнд хэрэгтэй. Ийм ч учраас Монгол-банк инфляцыг 2017-2020 онд тогтворжуулах бодлогоо тууш-тай хэрэгжүүлэхийг зорьж байна.

-Бодлогын хүлээгдэж буй үр дүнг хэрхэн төсөөлж байгаа вэ?

-Инфляц, эдийн засгийн өсөл-тийн зөв тэнцвэрийг хангах замаар эдийн засгийн өсөлтөөс иргэдийн амьжиргаанд очих нийгмийн хожоог хамгийн өндөр байлгахыг зорино гэсэн үг. Энэ-хүү бодлогоо хэрэгжүүлэхдээ эдийн засагт нийлүүлж буй зээлийн төрөл болон өсөлтийг зохистой түвшинд удирдах замаар эдийн засагт эрсдэл хуримтлуулж, инфляцыг хөөрөгдөхгүйгээр тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг дэмжих бодлого баримтална. Мөнгөний бодлого энэхүү дунд хугацааны зорилтыг бодлогын хүү болон банкны зохистой харьцааны үзүүлэлтийг хослуулах замаар хэрэгжүүлнэ.

-Долларжилтын эсрэг ямар бодлого баримтлах вэ. Сүүлийн үед долларжилт нэмэгдэж байна гэж судалгаа, тайланд дүгнэх боллоо?

-Өрх, аж ахуйн нэгж, санхүү-гийн байгууллагуудын балансын долларжилт эдийн засгийн эмзэг байдлыг нэмэгдүүлж, хямралын нөлөөг гүнзгийрүүлдэг сул талтай. Энэ нь 2008, 2009 оны хямрал болон өнгөрсөн үйл явдлаас тод харагдаж байна. Иймд Монголбанкнаас гадаад валютын орлогогүй хэрнээ гадаад валютын зээл авах, банк ийм төрлийн зээл олгохоос сэргийлэх макро зохистой бодлогыг хэрэгжүүлнэ. Зээлийн долларжилт нь банкны пассивын долларжилттой холбоотой учраас түүнийг бууруулахад чиглэсэн бодлогыг давхар хэрэгжүүлэх шаардлагатай. Ингэснээр эдийн засгийн гадаад сөрөг шокийн нөлөөгөөр төгрөгийн ханш сулрах тохиолдолд бодит секторт ирэх сөрөг нөлөө буурах төдийгүй гадаад валютын нөөцийн хүрэлцээг сайжруулахад дэмжлэг болох юм. [ЗГМ]

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ


Алт тушаалт 25 тоннд хүрэх боломжтой

Б.Тулгат ЗГМ

Монголбанк өнгөрсөн оны арванхоёрдугаар сард иргэд, аж ахуйн нэгжүүдээс 911.83 кг алт худалдан авснаар нийт алт худалдан авалт оны эцсийн байдлаар 20.01 тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс есөн хувиар өслөө. Энэ нь Монголбанкны сүүлийн жилүүдэд худалдан авсан алтны түүхэн дээд хэмжээ болж байна. Төв банк 2017 онд алт худалдан авалтыг нэмэгдүүлэх зорилгоор “Монгол Алт” аяныг хэрэгжүүлсэн. Мөн алт худалдан авах үнийг дэлхийн зах зээлийн ханштай нийцүүлэх зэрэг шат дараатай арга хэмжээ авсан нь алт худалдан авалтыг нэмэгдүүлэхэд үр дүнгээ өглөө. Монголбанкны алт худалдан авалт өссөн нь гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлэхэд чухал нөлөө үзүүлдэг. Гадаад валютын албан нөөц одоогийн байдлаар импортын зургаан

сарын хэрэгцээг хангах түвшинд байна. Олон улсын жишгээр гадаад валютын нөөц тухайн улсын гурван сарын импортын хэрэгцээг хангах түвшинд байвал нөөц хангалттай гэж үздэг. Энэ оны хувьд алт тушаалт дээрх хэмжээнээс илүү нэмэгдэх боломжтой. Учир нь, эдийн засгийг сэргээх зорил-гоор хэрэгжүүлж буй “Алт-2” хөтөлбөрийн хоёр дахь үе шат энэ онд эрчимжих юм. Ингэснээр алтны олборлолтыг жил бүр 2-3 тонноор нэмэгдүүлснээр 2020 он гэхэд 25 тонныг олборлох зорилгоор дээрх хөтөлбөрийн хүрээнд төсөөлж байгаа.

Энэхүү хөтөлбөрийн хүрээнд жилд алтнаас олох экспортын нөөцийн тодорхой хэсгийг алт хэлбэрээр бүрдүүлж ирсэн. Энэ нь алтны эрэлтэд жин дардаг. Хамгийн их алтны нөөцтэй төв банкууд хаана байна вэ. Улсаар нь авч үзвэл, АНУ, Герман, Итали,



Франц, БНХАУ, ОХУ эхний байранд орж байна. Манай улсын хувьд алтны нийлүүлэлтээр дэлхийд 2016 оны байдлаар, 23 дугаар байранд жагссан. Дэлхийн нийт алтны тавны нэгийг Ази тивд үйлдвэрлэдэг. Хэдий Ази

тив тоон үзүүлэлтээр тэргүүлэх боловч нийт нийлүүлэлтийн тал хувийг зургаан улс дангаар бүрдүүлж байна. Үүнд, БНХАУ-аас гадна Австрали, ОХУ, АНУ болон Канад багтдаг. Дэлхийн алтны эрэлтийг үнэт эдлэл,

технологи, аж үйлдвэр, хөрөнгө оруулалт, төв банк гэсэн дөрвөн үндсэн хэсэгт ангилж болно. Эдгээрээс дийлэнх хэсгийг үнэт эдлэл болон хөрөнгө оруулалтын зориулалттай алтны эрэлт эзэлж байна. [ЗГМ]

ЗГМ ТОВЧХОН

» ИПОТЕК

300

Тэрбум төгрөг. Ипотекийн зээлд Засгийн газар энэ онд 120 тэрбум төгрөг, Монголбанкны зээлийн эргэн төлөлтөөс 180 тэрбум төгрөг санхүүжүүлэхээр төлөвлөж байна.

» ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

1.2

Тэрбум ам.доллар. Гадаадын шууд хөрөнгө оруулалт 2017 онд 1.2 тэрбум ам.долларт хүрэв.

» ДНБ

3.8

Хувь. Эдийн засгийн өсөлт 2017 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр 3.8 хувьд хүрчээ. Өсөлтийг салбараар нь үзвэл хөдөө аж ахуй 4.4 хувь, үйлчилгээ 8.5 хувь өсөхөөр байна. Харин уул уурхайн салбар өнгөрсөн онд 7.8 хувиар буурсан дүнтэй гарчээ.

» ЭКСПОРТ

1.9

Тэрбум ам.доллар. Экспортын хэмжээ өнгөрсөн онд анх удаа зургаан тэрбум ам.доллар давж, гадаад худалдааны тэнцэл 1.9 тэрбум ам.долларын ашигтай гарсан байна.

» БАНК, САНХҮҮ

Санхүүгийн зохицуулах хорооны ээлжит хурлаараа Архангай аймагт үйл ажиллагаа эрхлэх хоёр Банк бус санхүүгийн байгууллагад шинээр тусгай зөвшөөрөл олголоо.

» ДААТГАЛ

17

Даатгагч. Улсын хэмжээнд ердийн даатгалын 15, урт хугацаатай даатгалын нэг, хөдөө аж ахуйн давхар даатгалын нэг компани, нийт 17 даатгагч үйл ажиллагаа явуулж байна.

ЭШЛЭЛ



-Эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан 2016 оны аравдугаар сараас ипотекийн зээлийн хөтөлбөрийн санхүү-жилтийг Монголбанк хязгаарлаж эхэлснийг та бүхэн мэдэж байгаа байх. Үүнээс шалтгаалан банкуудын орон сууцны зээл олголт багассан хэдий ч зогсоогүй. 2017 оны хувьд ипотекийн зээ-лийн санхүүжилтэд зориулж Монголбанк 243 тэрбум төгрөг, Засгийн газар 111 тэрбум төг-рөгийн эх үүсвэрийг банкуудад олгосон. Банкууд энэ эх үүсвэрээр 5600 орчим зээлдэгчийн орон сууцны зээлийг шийдвэрлэсэн бөгөөд үүний цаана 20 гаруй мянган иргэн шинээр орон сууцтай болсон гэж хэлж болно. Ипотекийн зээлийн хөтөлбөр энэ онд үргэлжлэн хэрэгжинэ. (Монголбанкны Нөөцийн удирдлага, Санхүүгийн газрын Санхүүгийн зах зээлийн хэлтсийн захирал) Д.Баянзул

Мөнгөний урсгал



Өсөлтийг тэтгэх бодлогын шинэ нөхцөл

Инфляц дунд хугацаанд тогтвортой хадгалагдахаар байна

Б.Мөнх
ЗГМ

Бодлогын хүүгээ оны өмнө нэг хувиар бууруулж, 11 болгосон Монголбанкны Ерөнхийлөгчийн дэргэдэх Мөнгөний бодлогын зөвлөлийн ээлжит хурал гуравдугаар сард болох товтой байна. Улирал тутам хуралдаж, бодлогын хүүг хэлэлцдэг тус зөвлөл 2-3 удаа хуралдаж байж эцсийн шийдвэр гаргадаг. Мөнгөний бодлогын зөвлөлийн хувьд өнгөрсөн онд хоёр удаа бодлогын хүүг өөрчилсөн. Харин энэ оны хувьд хамгийн сүүлд гаргасан шийдвэрийнхээ үр дүнг хүлээж харзнах нь дамжиггүй. Хэдий

тийм боловч хуваарь ёсоор бодлогын хүүг эргэж хардаг. Мөнгөний бодлогын мэдэгдэлд “Хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх жилийн инфляц дунд хугацаанд төв банкны зорилтот найман хувийн түвшинд тогтвортой байхаар байна. Уул уурхайн салбарын үйлдвэрлэл, бүтээн байгуулалт эрчимжиж, гадаад худалдааны нөхцөл сайжирч, богино хугацааны гадаад өрийн эргэн төлөлтийн дарамт буурч байгаагаас макро эдийн засгийн эрсдэл буурч, эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлж байна” хэмээн дурдсан юм. Тэрчлэн мөнгөний бодлогыг зөөлрүүлэх нь эдийн засгийн өсөлт, бизнесийн идэвхжил болон ажил эрхлэлтэд дэмжлэг үзүүлэхээр байгааг тодотгосон билээ. Тэгвэл оны өмнө бодлогын хүүг нэг хувиар бууруулсан нь эдийн засагт хэрхэн нөлөөлөх талаар эдийн засагчдын байр суурийг сонирхлоо. [ЗГМ]

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ҮР НӨЛӨӨГ НЭМЭХЭЭР БАЙНА

Х.Батеуурь (*Эдийн засагч*)
-Монголбанкны гадаад валютын албан нөөц жилийн дотор гурав дахин нэмэгдэж, гурав орчим тэрбум ам.долларт хүрсэн. Нөөц нэмэгдэх хэрээр төгрөгийн ханш тогтвортой байх боломж бүрдэнэ гэсэн үг. Нөгөө талаасаа төв банк эдийн засгаа дэмжих, мөнгөний зөөлөн бодлого хэрэгжүүлэх орон зай үүсэж байна. Энэ боломжийг алдахгүй ашиглах хэрэгтэй. Бодлогын хүүг нэг хувиар бууруулсан нь бизнесийн орчинд эерэг мессеж өгсөн. Төлбөрийн тэнцэл ашигтай гарч эхэллээ. Монголбанкны зорилтот түвшнээс инфляц доогуур байгаа. Эдгээр нь мөнгөний бодлогын үр нөлөөг нэмэхээр харагдаж байна. Бизнес эрхлэгчдэд хүү буурсан нь ээлтэй алхам болсон.

ЭДИЙН ЗАСАГ СЭРГЭЖ БАЙГАА ҮЕД НЭГ ХУВЬ ГЭДЭГ ЧАМЛАЛТТАЙ

Д.Ангар (*Хөрөнгийн зах зээлийн шинжээч*)
-Эдийн засагт мөнгөний хомсдол үүссэн. Үүнтэй холбоотойгоор зээлийн олдоц саарч, бизнес үйл ажиллагаагаа хэвийн явуулахад хүндрэл гарч байна. Тиймээс бодлогын хүүгээ дахиад бууруулах хэрэгтэй. Ингэснээр эдийн засаг идэвхжиж, мөнгөний эргэлт нэмэгдэнэ. Монголбанк мөнгөний бодлогын хүүгээ дахин бууруулснаар эдийн засгаа дэмжинэ. Хүнтэй зүйрлэвэл, эдийн засгийн цус нь мөнгө. Биеэр цус чөлөөтэй эргэлдэж байж хүн эрүүл чийрэг, эмгэг хуучгүй амьдарна гэсэн үг. Түүнтэй адил мөнгө чөлөөтэй эргэлдэж байх учиртай. Эдийн засаг сэргэж байгаа үед нэг хувь гэдэг чамлалттай.

БОДЛОГЫН НӨЛӨӨ ДУНД ХУГАЦААНД ИЛҮҮ ХАРАГДАНА

Ж.Дэлгэрсайхан (*СЭЗИС-ийн багш, эдийн засагч*)
-Бодлогын хүү өөрөө инфляцыг өсгөх, бууруулах үндсэн зэмсэг төдийгүй мөнгийг хумих, тэлэх үндсэн хэрэгсэл. Бодлогын хүүг бууруулах эдийн засаг бүхэлдээ сэргэхэд түлхэц болдог. Энэ утгаараа бодлогын хүүгээ төв банк нэг хувиар бууруулсан нь эдийн засгаа дэмжих гэсэн илрэл. Оны өмнө гаргасан мөнгөний бодлогын зөвлөлийн шийдвэр дунд хугацаанд эдийн засагт илүү тусгалаа олж, үр шим нь харагдах байх. Бодлогын хүү буурах хэрээр мөнгөний эргэлт сайжирч, эдийн засаг тэлнэ гэж үздэг. Гэхдээ бодлогын хүүг бууруулах үндэслэл нь илүү чухал.

ХҮҮГИЙН ӨӨРЧЛӨЛТ ӨНӨӨДӨР БИШ, МАРГААШ НӨЛӨӨЛНӨ

Н.Энхбаяр (*Ерөнхий сайдын эдийн засгийн бодлогын зөвлөх*)
-Бодлогын хүүгээ өөрчлөхийн өмнө төв банкнаас зах зээлийн судалгааг маш сайн хийх хэрэгтэй. Түүхий эдээс хамааралтай орны хувьд зөвхөн дотоод биш гадаад зах зээлээ маш сайн судлах хэрэгтэй. Дотоодын бизнесийн идэвхжил ямар байна. Хэрэглэгч, худалдан авагчдын сонирхол хэр байна. Тухайлбал, орон сууц худалдан авагчдын сонирхол хэр байна вэ гэх зэрэг мэдээлэлд тулгуурлах хэрэгтэй. Бодлогын хүү өнөөдөр биш, маргааш нөлөөлнө. Үр дүн нь дунджаар зургаан сараас нэг жилийн хугацаанд мэдрэгдэж эхэлдэг. Энэ бодлогын хүүгийн өөрчлөлт 2018 оны намар мэдэгдэнэ гэсэн үг.

“Санхүүгийн боловсрол” аян орон нутгийн иргэдийн 30 хувьд хүрсэн

ЕБС-ууд болон есөн их дээд сургуулийн хөтөлбөрт санхүүгийн боловсролын хичээл багтлаа

Х.Цолмон
ЗГМ

Олон нийтийн санхүүгийн боловсролыг дэмжих үндэсний хөтөлбөрийн хүрээнд Монголбанкнаас санаачилсан “Санхүүгийн боловсрол” аян өнгөрсөн гурван сарын хугацаанд хэрэгжиж дуусаад байна. Энэ талаар тус банкны Олон нийтийн боловсрол, мэдээллийн төвийн ахлах мэргэжилтэн М.Нургултай ярилцлаа.

–“Санхүүгийн боловсрол” аяныг хэрэгжүүлэх хугацаандаа Монголбанк ямар ажлуудыг гүйцэтгэсэн бэ?
-Энэхүү аяны хүрээнд Монголбанк Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийг дэмжин сурталчлах, иргэдэд мэдлэг, мэдээлэл олгох арга хэмжээг дөрвөн үндсэн чиглэлээр зохион байгуулсан. Үүнд, оюутан сурагчид, ажил эрхлэгчдэд олон нийтийн хийснээрээ онцлог. Тухайлбал, санхүүгийн эрсдэлээс өөрийгөө хэрхэн хамгаалах, хэнд хандан хохирлоо барагдуулах гэх зэрэг сэдвийн хүрээнд мэдлэг, мэдээлэл хүргэсэн.



ЗГМӨ

–Аян орон нутгийн иргэдэд хэр хүрч чадсан бэ?
-Монгол Улсын гурван сая гаруй хүн амын тал хувь нь орон нутагт амьдардаг. Тиймээс бид тухайн бүс нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон банкуудтай нягт хамтран ажилласнаар гайхалтай үр дүнд хүрсэн. “Санхүүгийн боловсрол” аяны хүрээнд орон нутгийн нийт иргэдийн гуравны нэгд хүрч ажилласан. Гуравхан сарын хугацаанд энэ бүхнийг амжуулсан нь маш том үзүүлэлт. **–Аяныг хэрэгжүүлэх үеэр Дэлхийн хуримтлалын өдөр тохиосон. Энэ өдөрт нэлээд ач холбогдол өгч байсан?**
-Дэлхийн хуримтлалын өдрийг 1800-гаад оны үеэс Герман улсад анх тэмдэглэж эхэлсэн байдаг. 2012 оноос Монгол Улс дээрх өдрийг тэмдэглэж эхэлсэн ч өргөн хүрээг хамарч чадаагүй.

Харин “Санхүүгийн боловсрол” аяны хүрээнд аравдугаар сарын 31-нд тохиодог Дэлхийн хуримтлалын өдөрт зориулан бид нийт арилжааны банкууд, Хадгаламжийн даатгалын корпораци болон Монголын банкны холбоотой хамтран томоохон ажлуудыг зохион байгуулсан нь маш олон хүнд хүрсэн. Тухайлбал, арилжааны банкууд тусгайлан санхүүгийн бүтээгдэхүүн буюу өндөр хүүтэй хадгаламж, эрсдэлээс хамгаалсан хадгаламжийг санал болгож, хүүхдийн хуримтлалын ач холбогдлыг таниулах зэрэг ажил зохион байгуулсан. Дээрх ажлуудыг ХБНГУ-ын Хадгаламжийн банкны олон улсын хамтын ажиллагааны сангийн санхүүжилтээр амжилттай хэрэгжүүлээд байна. **–Хүүхдэд санхүүгийн боловсрол олгох ажлыг эхлүүлсэнэ**

дэлгэрүүлэн тайлбарлахгүй юү?
-Нэгэнт төлөвшсөн хүмүүст хуримтлалыг дадал болгох хүндрэлтэй байдаг. Харин үүнийг хүүхдүүд маш хурдан хүлээж авдаг. Олон улсын жишгээр санхүүгийн боловсрол олгох хичээлийг хүүхдэд багаас нь ордог. Бид дүүрэг бүрээс нэг сургууль сонгож, хуримтлалын ач холбогдлын талаар хичээл зааж, анхны хуримтлал болох хуримтлалын хайрцаг бэлэглэсэн. Хуримтлуулахаас гадна төсөв хөтлөх буюу орлого, зарлагаа хянадаг байх нь чухал. Тиймээс бид ЮНЕСКО-гоос баталсан орлого, зарлагаа хянах халаасны мөнгөний дэвтрүүдийг тараасан. Мөн хүүхдүүдийн хуримтлалын талаар ойлголтыг сорих зорилгоор “Би мөнгөө юунд зориулж хуримтлуулах вэ” сэдэвт зургийн уралдаан

зарлахад хоёр долоо хоногийн хугацаанд 1150 орчим бүтээл ирүүлсэн зэргээс иргэд манай аянд маш идэвхтэй оролцсон нь харагдаж байгаа юм. **–Манай улсад санхүүгийн боловсролтой холбогдох хууль, эрх зүйн орчин хэр хөгжсөн бэ?**
-Хууль, эрх зүйн орчин маш сайн бүрдсэн. Төрөөс мөнгөний бодлогын талаарх 2018 онд баримтлах үндсэн чиглэлд санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хүрээнд хамтран ажиллана гэх заалт орсон. Мөн Засгийн газрын тогтоолоор баталгаажсан Санхүүгийн зах зээлийг сайжруулах 2025 оны хөтөлбөрт ч мөн энэ талаар багтсан байгаа. Үүнээс гадна Сангийн яам, БСШУСЯ болон Санхүүгийн зохицуулах хороо зэрэг байгууллага бидэнтэй цуг урагш алхаж байна.

Одоогоор санхүүгийн боловсролын стратегийг 65 улс хэрэгжүүлж байна

–Ер нь олон улсын түвшинд санхүүгийн боловсролыг хэрхэн авч үздэг юм бэ?
-Одоогоор санхүүгийн боловсролын стратегийг 65 улс хэрэгжүүлж байна. Хамгийн сайн хэрэгжүүлж буй орны тоонд ихэвчлэн хөгжилтэй улс багтдаг. ЕБС санхүүгийн боловсролыг тусгай хичээлээр дамжуулан хүүхдүүдэд хүргэх нь илүү үр дүнтэй гэж тэд үздэг. Гэхдээ нийт дэлхийн хэмжээнд авч үзвэл боловсролын

системдээ санхүүгийн боловсролыг тусгасан улс тийм ч олон биш. Үүний оронд ихэнх улс математик, гадаад хэл зэрэг голлох хичээлд төвлөрч, ТББ-ууд санхүүгийн боловсролыг олгох боломжтой гэж үздэг. Тэдгээр улсын гол зорилго санхүүгийн боловсролыг боловсролын системдээ оруулах. Харин Монгол Улсын хувьд боловсролын системдээ оруулж чадсан. Тиймээс манай улс энэ чиглэлээр бүс нутагтаа тэргүүлж, “Child and Youth Finance International” (CYFI) олон улсын байгууллагаас шагнал хүртээд байна. **–Боловсролын системд санхүүгийн боловсрол олгосон талаараа дэлгэрүүлэхгүй юү?**
-2012 оноос хойш Монголбанк Олон нийтийн санхүүгийн боловсролыг дэмжих үндэсний хөтөлбөрийг Дэлхийн банктай хамтран хэрэгжүүлж байна. Энэ хөтөлбөр 2015 онд батлагдсанаар гайхалтай үр дүнд хүрсэн. Монголбанкнаас агуулга болон холбогдох сурах бичгийг боловсруулсан “Бизнес судлал”-ын хичээлийг ЕБС-ийн ахлах ангийнхны хичээлийн хөтөлбөрт сонгон судлах боломжтойгоор оруулсан. Мөн МУИС, ХААИС, СЭЗИС, Улаанбаатар эрдэм, Этүгэн зэрэг есөн их, дээд сургуульд хувь хүний санхүүгийн чиглэлээр гурван багц хичээлийг заавал сонгон судлах хичээлийн тоонд багтаагаад байна. Эдгээр эерэг мэдээ бол бид БСШУСЯ-тай түлхүү хамтран ажилласны үр дүн. Гэхдээ энэ бүхэн “Санхүүгийн боловсрол” аянаар дуусахгүй. Нийгэм, эдийн засгийн тогтвортой байдлыг хангахын тулд бид цаашид ч энэ чиглэлээр ажиллана. [ЗГМ]

Мөнгөний урсгал

Хүлээлт үүсгэсэн шинэчлэлийн үр дүнд төв банкны засаглал бэхэжнэ

Б.Баяртогтох
@bayartogtokhZGM

Монгол Улс ашгийн төлөө бус, бодлогоо тодорхойлж, өөрөө түүнийгээ хэрэгжүүлдэг ганцхан банктай. Тэр нь арилжааны бус Монголбанк. Бие даасан бодлоготой, өөрийн гэсэн хууль эрх зүйн орчинтой энэ онцгой институци хэзээд анхаарлын төвд байдаг. Хэдий тийм боловч төв банкны засаглал, хууль эрх зүйн орчин эмзэг хэвээр байна. Төв банкны хараат бус бие даасан байдал засаглалын түвшиндээ хангалтгүй байгааг цөөнгүй судалгаанд хөнджээ. Энэ нь Монголбанкны бие даасан байдал алдагдсаар байгааг илтгэнэ. Хөрөнгийн үнэ цэнийг хадгалдаг, төлбөрийн хэрэгсэл, тооцооны нэгж болдог төгрөгийн худалдан авах чадварын “манаач” нь төв банк. Тиймээс энэ байгууллагын бие даасан, хараат бус байдал эргээд төгрөгийн үнэлэмжийг тодорхойлоход гол үүрэг гүйцэтгэдэг.

Гадаадын зарим улс төв банкны бие даасан байдал, үйл ажиллагааны зорилтыг Үндсэн хуульдаа хүртэл тусган хамгаалсан байдаг. Харин манай улсын хувьд зөвхөн Төв банкны тухай хуулиар Монголбанкны үйл ажиллагааг зохицуулж байгаа юм. Засгийн газрын үйл ажиллагааны бодлогоос Монголбанк шууд хамааралтай байна гэж зарим судлаач шуудхан хэлдэг. Тэрчлэн мөнгөний бодлогын үндсэн зорилгыг өөрсдийн ашиг сонирхолд нийцүүлэх замаар бодлого тодорхойлогчид гуйвуулах тэр орон зай сул чөлөөтэй байгааг мөн гаргаж тавьдаг. Санхүүгийн тогтвортой байдлыг хангах үүрэгтэй төв банкны үйл ажиллагаа, мөнгөний бодлогыг улстөржүүлэх нь эдийн засгийн хөгжлийг хойш татдаг гэмтэй. Тиймээс олон улсын төв банкууд өөрсдийн хараат бус бие даасан байдалдаа хэдийнэ санаа зовниж эхэллээ.

Төв банкны удирдлага буюу ерөнхийлөгч, тэргүүн дэд, дэд ерөнхийлөгч нь Засгийн газар, шинэ УИХ-тай хамт ирж, буцдаг. Энэ үзэгдэл хэвшмэл ойлголт болтлоо уджээ. Монголбанкны ерөнхийлөгчийг зургаан жилийн хугацаатай томилдог. Харин улс төрийн сонгууль дөрвөн жилд нэг удаа болдог. Гэтэл зургаан жилээ гүйцээсэн төв банкны ерөнхийлөгч манайд ховорхон байгаа нь тус банкны бие даасан засаглал



С.Батсайхан / ЗГМ©

ОУВС-гаас хийсэн судалгаа, бусад дотоодын судалгаанаас үзэхэд Монгол Улсын төв банкны бие даасан, хараат бус байдлын түвшин бусад улс оронтой харьцуулахад 50-60 орчим хувьтай байна.

“Тоглоомын дүрэм”-ээ тодорхой болгох шалтгаан

удирдлагын түвшин уруудаж байгааг гэрчлэх нэг баримт.

20 гаруй жилийн өмнө Монголын банк санхүүгийн салбарт хоёр шатлалт банкны систем бүрэлдэн тогтож, санхүүгийн зах зээлийн гараа 100 хувь банкны системээр эхэлж байсан. Харин энэ хугацаанд арилжааны банкны салбар цэцэглэн хөгжсөн ч төв банкны засаглал, хууль эрх зүйн орчинд дорвитой өөрчлөлт гараагүй болохыг СЭЗИС-ийн багш, судлаач Д.Түвшинжаргал өгүүлсэн юм.

Төв банкны засаглалаас төгрөгийн ханш шалтгаална. Монголын банкны хууль тогтоомжийг аваад

үзэхэд, 1991 оноос үүдэлтэй хоёр шатлал банкны тогтолцоо өнөөдрийн суурь хөрс нь гэж үзэж болох талтай. Учир нь, 1990-1996 оныг банкны салбарын анхан шатны хөгжлийн үе гэж онцолдог. Энэ үеэс л арилжааны банкууд бий болж, үйл ажиллагааны хүндрэлтэй учирч, зарим нь хаалгаа барих хүртэл асуудалтай тулгарч байсан нь тэртээ хол болохоор. Арилжааны банкуудын засаглал бэхжиж, үйл ажиллагаа нь шинэ шатанд гарсан. Гэтэл Монголбанкны үндсэн үйл ажиллагааг зохицуулах бодлогын баримт бичгүүд дархлаа сул хэвээр байна. Дараагийн үе нь 1996 оны

шинэ УИХ-ын анхны чуулганаас эхтэй. Энэ үед банкны салбарт салхи эргэж, Монголын банкны салбарт хоёр төрлийн хууль эрх зүйн шинэчлэл өрнүүлсэн нь Төв банк, арилжааны банкны үйл ажиллагаа, эрх зүйн орчинг хуулийн хүрээнд ялгаж заагласан явдал. Төвбанкны тухай хуульд 1996 оноос хойш өнөөг хүртэл бараг л салхи ороогүй хэлж болохоор. Монголбанкны хувьд 1996 оны УИХ-ын чуулганаар хэлэлцэн баталсан хууль эрх зүйн орчинтойгоо өнөөг хүртэл явж байна. Цаг үеийн нэмэлт өөрчлөлтийг эс тооцвол төв банкны хууль эрх зүйн орчинд шинэчлэгдэх

цаг болсныг Монголын банкны холбооны гүйцэтгэх захирал Ж.Үнэнбат хэлж байна.

Монголбанкны үйл ажиллагаа Засгийн газраас хараат бус байхаар төв банкны тухай хуульд заасан байдаг. Энэхүү заалт нь олон улсын жишигт нийцсэн дэвшилтэт заалт. Хэдий тийм боловч амьдрал дээр уг заалтын хэрэгжилт хангалтгүй байсаар. Өөрөөр хэлбэл, бэлгэдэл төдий байна. Төв банкны хараат бус байдал бэхэжсэн орнуудад мөнгөний бодлогыг нэг биш гурван жилээр баталдаг. Эдгээр улсын нэг нь Чех. Төв банкны үйл ажиллагаа тогтвортой, улс төрийн нөлөөлөөс хол байлгахын тулд

хуулиар хамгаалж, давуу эрх олгох хүртэл арга хэмжээ авсан нь түгээмэл байна. Төв банкны бие даасан, хараат бус байдал нь тухайн улс орны эдийн засгийн тогтвортой өсөлт, санхүүгийн тогтвортой байдалд голлох үүрэг гүйцэтгэдэг. ОУВС-гаас хийсэн судалгаа, бусад дотоодын судалгаанаас үзэхэд Монгол Улсын Төв банкны бие даасан, хараат бус байдлын түвшин бусад улс оронтой харьцуулахад 50-60 орчим хувьтай байна. Хуульд өөрчлөлт оруулснаар бие даасан, хараат бус байдлын түвшин 80 орчим хувьд хүрнэ гэсэн төсөөлөлтэй байгаа юм. [ЗГМ]

ЗГМ: ИНФОГРАФИК



ЭШЛЭЛ



“Бодлогын хувьд зорилготой, тууштай явсны үр дүнд сорилт ихтэй жилийг амжилттай үдэж, 2018 оны гарааг сайн тавьж өглөө. 2017 оны хувьд зөвхөн тулгамдсан асуудлуудыг шийдээд зогсохгүй дунд, урт хугацаанд үр нөлөөгөө өгөх бүтцийн шинж чанартай бодлогын арга хэмжээнүүдийг авснаараа онцлогтой жил боллоо.

Цаашдаа тодорхойлсон бодлогын чиглэлээ өөрчлөхгүй харин зорилго, зорилтоо өндрөөр тавьж хэрэгжилтийг хангаж ажиллана. Үүнд мэдээж мөнгөний бодлогын үндсэн чиглэлд тусгагдсан банкуудын эрсдэл даах чадварыг сайжруулах, эрсдэлд суурилсан хяналт, шалгалтын аргачлалыг нэвтрүүлэх, шаардлага үүсвэл дахин хөрөнгөжүүлэх зэрэг эдийн засгаа тогтвортой өсгөхөд чиглэсэн арга хэмжээнүүдийг шат дараатайгаар, төлөвлөгөөний дагуу цогцоор нь чанартай хийх ажил орно. Хөрөнгө оруулагчид, олон улсын байгууллагууд гээд түншлэгч нарын маань хүсэж байгаа зүйл бол энэ.

(Монголбанкны тэргүүн дэд ерөнхийлөгч)
О.Эрдэмбилэг

САНХҮҮГИЙН ТОЛЬ

Банкуудын зохицуулагч буюу төв банк

Орчин үеийн эдийн засагтай улс болгон төв банктай байдаг бөгөөд төв банкууд эдийн засагт маш чухал үүрэг гүйцэтгэдэг. Гэсэн хэдий ч иргэд төв банкны талаар төдийлэн сайн мэдэхгүй байх нь хэвийн зүйл юм. Учир нь төв банк арилжааны банкуудын нэгэн адил иргэдтэй шууд харилцдаггүй. Төв банкууд иргэдийн мөнгийг хадгалах, цалингийн зээл олгох, цахилгааны төлбөрөө хийх, хэн нэгэн рүү мөнгө шилжүүлж өгөх гэх мэт үйлчилгээ явуулдаггүй. Тэгвэл төв банкууд юу хийдэг учраас тийм чухал үүрэгтэй байгууллага вэ?

Монгол Улсын төв банк бол Монголбанк. Монголбанк юу хийдэг вэ гэхээр, нэгдүгээрт, мөнгөн тэмдэгт буюу төгрөгийг гүйлгээнд гаргадаг. Хэрэв төв банкнаас өөр хэн нэгэн төгрөг хэвлэвэл гэмт хэрэгт тооцогдох бөгөөд хуулиар хатуу шийтгэлтэй байдаг. Түүнчлэн Монголбанк нь манай улсын мөнгөний бодлогыг боловсруулж хэрэгжүүлдэг. Энэ нь төрөөс хэрэгжүүлж буй эдийн засгийн нэг гол бодлого юм. Төв банк эдийн засагт эргэлдэж байгаа мөнгөний нийлүүлэлтийг оновчтой удирдах нь нэг талаас эдийн засгийн өсөлттэй үед хэт халалт явагдах, улмаар бараа бүтээгдэхүүний үнэ хурдтай



С.Батсайхан / ЗГМ©

өсөх буюу өндөр инфляцаас сэргийлэхэд чухал. Харин нөгөө талаас хямрал, хүндрэлийн үед дефляц буюу бараа үйлчилгээ зарагдахгүй болж үнэ нь унах, улмаар бизнес эрхлэгчдийн орлого муудаж, ажилтнуудаа цомхотгох, бизнесийн шинэ төслүүдэд хөрөнгө оруулалт хийхгүй байх зэрэг сөрөг үр дагавруудаас сэргийлнэ.

Төв банкууд мөнгөний бодлого хэрэгжүүлэхдээ урт хугацаанд үнийг тогтвортой байлгахыг зорьдог бөгөөд ингэснээр эдийн засагт маш том хувь нэмэр оруулдаг. Учир нь зах зээлд дээрх бараа бүтээгдэхүүний үнэ тогтворгүй үед эдийн засаг сайн байх аргагүй юм. Тэгвэл инфляцаас гадна эдийн засгийн өсөлт, ажилгүйдэл

гэх мэт бусад чухал асуудал яах вэ гэдэг асуулт гарч ирнэ. Мэдээж мөнгөний бодлогоор эдийн засгийг түр хугацаанд идэвхжүүлэх боломжтой. Гэхдээ энэ нь урт хугацаанд удаан үргэлжлэх аргагүй юм. Учир нь мөнгө хэвлэх замаар эдийн засгийг дэмжих оролдлого удаан үргэлжлэх нь төв банкны үндсэн зорилго болох үнийн

тогтвортой байдлыг хангаж чадахгүйд хүргэх, бүр эдийн засгийг хямруулах эрсдэлийг ч бий болгодог.

Мөн төв банкуудын хийдэг өөр нэг гол ажил нь санхүүгийн тогтвортой байдлыг хангах явдал юм. Монголбанкны хувьд арилжааны банкуудын үйл ажиллагаанд хяналт тавьдаг “банкуудын зохицуулагч”

болдог.

Аливаа улс орны эдийн засгийн толь гэж хэлж болох банк, санхүүгийн систем найдвартай, үр ашигтай ажиллах нь маш чухал. Хэрэв иргэдийн дансан дахь мөнгөн хадгаламжийн найдвартай байдал, эсвэл компаниуд банкнаас хэрэгтэй санхүүжилтээ авах боломж үгүй бол эдийн засаг хэвийн ажиллаж чадахгүй. Иймд эдийн засгийн чухал дэд бүтэц болсон санхүүгийн үйлчилгээ явуулдаг банкуудыг эрүүл, найдвартай байлгахын тулд хяналт тавьж ажилладаг газар бол төв банк юм.

Төв банк эдгээр ажлаа хэр амжилттай гүйцэтгэх нь улс төрөөс хараат бус байх, сайн засаглалтай байх зэргээс ихээхэн хамаардаг. Иймд эдийн засаг нь амжилттай яваа улс орнууд төв банкныхаа хараат бус байдлыг хуулиар баталгаажуулж, засаглалын тогтолцоог нь сайн байлгах тал дээр онцгой анхаардаг байна. Учир нь мөнгө хэвлэх цор ганц эрхтэй энэхүү байгууллагын хараат бус байдал алдагдаж, улс төр нөлөөлснөөр гипер-инфляц үүсч, мөнгөн тэмдэгт нь цаас болж, эдийн засаг нь хямарсан тохиолдол дэлхийн түүхэнд цөөнгүй байдаг болохоор тэр юм. [ЗГМ]